

**“СУРАЛЦАГЧДЫН СУРАЛЦАХУЙГ ДЭМЖИХ АРГА ЗҮЙН ХӨГЖИЛ”
БСШУЯ, ЖАЙКА-ийн хамтарсан төсөл**

Бага боловсролын дидактикийн сургалт, судалгааны төв

**Ц.Наранцэцэг, Б.Булган, Ц.Оюун,
Наканиши Рейко, Б.Гэрэл**

Төсөлт ажлын арга зүй

Боловсролын түвшин: БАГА,СУУРЬ

ЗӨВЛӨМЖ - III

Зохиогчийн эрхийг Монгол Улсын Боловсрол, Соёл,
Шинжлэх ухааны Яам, Японы Олон Улсын Хамтын
Ажиллагааны Байгууллага эдэлнэ. Зохиогчийн
зөвшөөрөлгүйгээр хэвлэх, олшруулахыг хориглоно.

Улаанбаатар хот
2009 он

DDC
371.3
T-603

Зөвлөмжийг боловсруулсан:

Ц.Наранцэцэг	МУБИС-ийн Багшийн сургуулийн багш, ББДССТ-ийн эрхлэгч
Б.Булган	МУБИС-ийн Багшийн сургуулийн багш
Ц.Оюун	МУБИС-ийн МСС-ийн багш, доктор (Sc.D), проф.
Наканиши Рейко	УБ хотын Баянгол дүүргийн “Эрдмийн ундраа” цогцолбор сургуулийн багш
Б.Гэрэл	УБ хотын Сүхбаатар дүүргийн 23-р сургуулийн багш
Ц.Оюунсанаа	45 дугаар сургуулийн англи хэлний багш
Т.Мөнхтуяа	45 дугаар сургуулийн бага ангийн багш
Г.Норжмаа	45 дугаар сургуулийн бага ангийн багш
Д.Энхтуяа	“Сэтгэмж” цогцолбор сургуулийн химийн багш
С.Лхагвацэнд	“Сэтгэмж” цогцолбор сургуулийн бага ангийн багш
Т.Эрдэнэчимэг	97 дугаар сургуулийн монгол хэлний багш
С.Алтантуяа	97 дугаар сургуулийн бага ангийн багш
С.Дуламрагчаа	97 дугаар сургуулийн бага ангийн багш
Д.Нарантуяа	Сэлэнгэ аймгийн 4 дүгээр сургуулийн газарзүйн багш
В.Оюунбилэг	Сэлэнгэ аймгийн 1 дүгээр сургуулийн эрүүл мэндийн багш
Д.Ууганбаяр	Сэлэнгэ аймгийн Хушаат сумын сургуулийн англи хэлний багш
Ц.Энхмаа	Дорнод аймгийн Матад сумын сургуулийн нийгмийн ажилтан
Б.Уранжаргал	Дорнод аймгийн 5-р сургуулийн багш
Ц.Дулмаа	Дорнод аймгийн “Хан-Уул” цогцолбор сургуулийн багш

Зөвлөх:

Шигэрү Асанума	Токио Гакүгэй Их сургуулийн профессор
----------------	---------------------------------------

Редактор:

Г.Содномваанчиг	Боловсролын хүрээлэнгийн эрдэмтэн нарийн бичгийн дарга, доктор (Ph.D)
Ш.Оюунцэцэг	Боловсролын хүрээлэнгийн төслийн удирдагч
Б.Оюунцэцэг	МУБИС-ийн БС-ийн тэнхмийн эрхлэгч

Шинжээч:

Д.Улам-Оргих	МУИС, ФЭС-ийн сургалтын албаны эрхлэгч, доктор
--------------	--

ISBN 978-99929-0-896-3

ГАРЧИГ

I БҮЛЭГ. ЗӨВЛӨМЖИЙН ЕРӨНХИЙ ЗҮЙЛ.....	4
Өмнөтгөл	4
“Төсөлт ажлын арга зүй” гурав дахь жилийн зөвлөмжийн онцлог ба ашиглах заавар	9
II БҮЛЭГ. ТӨСӨЛТ АЖЛЫН ТӨЛӨВЛӨЛТ.....	11
III БҮЛЭГ. ТӨСӨЛТ АЖЛЫГ ТУРШСАН БОДИТ ЖИШЭЭ.....	20
3.1. Бага боловсролын түвшинд төсөлт ажлыг туршсан үр дүн, сургамж	21
3.1.1. Байгаль орчны сэдэв голлосон төсөлт ажил	21
3.1.2. Эрүүл мэндийн сэдэв голлосон төсөлт ажил	28
3.1.3. Хүмүүс хоорондын харилцаа голлосон төсөлт ажил	31
3.2. Суурь боловсролын түвшинд төсөлт ажлыг туршсан үр дүн, сургамж	40
3.2.1. Нийгмийн амьдрал, хүмүүсийн үйл ажиллагаатай холбоотой сэдэв голлосон төсөлт ажил	40
3.2.2. Тогтвортой хөгжлийн асуудлын хөндсөн төсөлт ажил	59
3.2.3. Монгол ёс заншил, уламжлалын асуудал голлосон төсөлт ажил	110
3.2.4. Амьдрах ухааны сэдэв голлосон төсөлт ажил	119
3.2.5. Байгаль орчны асуудал хөндсөн төсөлт ажил	140
НОМЗҮЙ	151

БСШУЯ-НЫ ӨМНӨТГӨЛ

Боловсрол, Соёл, Шинжлэх ухааны
Дэд сайд Ч.Куланда

Зулын гэрэл тосноос
Шавийн эрдэм багшаас
(Монгол ардын зүйр цэцэн үг)

Монгол Улс ерөнхий боловсролын салбарт цогц чадамжид суурилсан бага дунд боловсролын шинэ стандартыг хэрэгжүүлэх (2004), ерөнхий боловсролын сургуулийг 11 жил (2006) ба 12 жил (2008)-ийн сургалтын тогтолцоонд шилжүүлэх зэрэгцсэн, цогц шинэчлэл хийж байгаа билээ.

Боловсролын дээрх шинэчлэлийн хэрэгжилтийн хувь заяа нь анги танхимд сургалт явуулж байгаа багш нарын мэргэжил, арга зүйн хөгжлийн түвшнээс шууд хамаарна. Шинэ стандарт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэхийн тулд багш нарт тэдгээрийг хэрэгжүүлэх шинэ арга зүйг эзэмшүүлэх зайлшгүй шаардлагатай. Хэдийгээр Монголын багш нар итгэл үнэмшил, идэвхи оролдлого сайтай боловч тэр шинэ арга зүй нь өнөөдөр анги болгоны хичээл бүрээр боловсорч бэлэн болоогүй байна. Тэгээд ч шинжлэх ухааны судлагдахууныг боловсролын агуулга биш, харин мэдээлэл-материал болгон ашиглаж тогтвортой ажиллаж, амьдрах арга ухааныг боловсролын агуулга болгох болсон өнөө үед суралцагч энэхүү арга ухаанд өөрийн үйл ажиллагаагаараа суралцах тэрхүү шинэ арга зүйг бүтээнэ гэдэг нэг жилийн, нэг багшийн хийх ажил биш болох нь хэнд ч ойлгомжтой билээ.

Суралцагчдын суралцах арга, багшийн багшлах арга зүйд ихээхэн өөрчлөлт хийж, анги танхимын бодит нөхцөлд явагдаж байгаа хичээлүүдэд хэрэглэгдэж, үр өгөөжөө өгөх шинэ арга, арга зүйг бүтээх шаардлагын дагуу Монгол Улсын БСШУЯ нь Японы ЖАЙКА байгууллагатай хамтран 2006 оноос эхлэн “Суралцагчдын суралцахуйг дэмжих арга зүйн хөгжил” сэдэвт 3 жилийн хугацаатай төслийг хэрэгжүүлэн дуусаж байна.

Бага, дунд боловсролын шинэ стандарт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай сургалтын шинэ арга зүйг МУИС, МУБИС-ийн сургалт, судалгааны 4 төвийн 70 орчим судлаачид (профессор, доктор, магиструуд)-ын боловсруулж, Токиогийн Гакүгэй их сургуулийн профессор багш нар зөвлөн тусалж, Улаанбаатар хот, Дорнод, Сэлэнгэ аймгийн нийт 9 сургуулийн багш нартай хамтран туршиж сайжруулсан юм.

Төсөл хэрэгжих 3 жилийн хугацаанд арга зүйн чиглэлээр багш нарт зориулсан нийт 400 хэвлэлийн хуудас бүхий 27 зөвлөмж ном, 8 VCD-ийг бэлтгэн гаргаж, хот, хөдөөгийн бүх сургууль, багш нар эдгээр арга зүйн зөвлөмжийг судлан хичээлдээ турших боломж олгохоор нийт 32400 хувь хэвлэж, Монголын бүх сургуулиуд, холбогдох боловсролын байгууллагуудад хүргүүлсэн билээ. Энэ тоон үзүүлэлтийн цаана олон хүний маш их хүч хөдөлмөр, оюун ухаан шингэсэн болохыг онцлон тэмдэглэхийг хүсч байна. Төслийн явцад багш нар хамтран хичээлдээ бэлтгэх,

хичээлд сууж, хичээлийн судалгаа хийх, сургалтын хөтөлбөрөө боловсронгуй болгох, хичээлд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх шинэ арга зүй, менежментэд суралцсан явдал төслийн үр дүнг тодорхойлох чанарын чухал үзүүлэлт төдийгүй багшийн хөгжлийг тодорхойлох шим шүүс нь юм.

Төслийн үр дүнг нийтийн хүртээл болгох, сургалтын технологит шинэ соёл нэвтрүүлэхэд БСШУЯ цаашид онцгой анхаарал тавих бөгөөд Монголын бүх сургуулийн багш нарын суралцах ёстой зүйлийн нэг нь энэ төслийн үр дүнд боловсорсон “хичээлийн шинэ соёл” байх болно.

“Суралцагчдын суралцахуйг дэмжих арга зүйн хөгжил” төслийг амжилттай хэрэгжихэд хувь нэмэр оруулсан Монгол Улсын болон Япон Улсын бүх байгууллага, эрдэмтэн, профессор, багш, мэргэжилтэн Та бүхэнд гүн талархал илэрхийлж, эрүүл энх, эрч хүч, амжилт бүтээл хүсэн ерөөе.

«ЖАЙКА»-ИЙН МОНГОЛ ДАХЬ ТӨЛӨӨЛӨГЧИЙН ӨМНӨТГӨЛ

Япон улсын Олон улсын хамтын ажиллагааны байгууллага
“ЖАЙКА”-ийн Монгол дахь Төлөөлөгчийн Газрын
Дарга Юкио Ишида

Юуны өмнө “ЖАЙКА”-ийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцож, хамтран ажилладаг Та бүхэндээ чин сэтгэлийн гүн талархал илэрхийлье. Мөн “Суралцагчдын суралцахуйг дэмжих арга зүйн хөгжил” төслийн 3 дахь жилийн зөвлөмжийг боловсруулан хэвлүүлж, Та бүхэнд хүргүүлж байгаадаа туйлийн их баяртай байна.

Багш нарт зориулсан энэ зөвлөмжид “Практикт туршин боловсруулсан хүүхдийн чөлөөт сэтгэлгээ, бүтээлч чадварыг хөгжүүлэх” хичээлийн арга зүйг оруулсан юм. Мөн энэ зөвлөмжийн дагуу 8 төрлийн хичээлээр Улаанбаатар хот, Дорнод, Сэлэнгэ аймгийн загвар сургуулиудийн багш нараар туршилт хичээл явуулан, боловсрогдсон арга зүйг туршин, олон дахин засвар оруулж сайжруулсаны үндсэн дээр бий болсон билээ. Мөн 3 дахь жилийн зөвлөмжийг боловсруулахдаа багш нарын санал бодлыг бүрэн дүүрэн тусгасан юм.

Улс орны хөгжлийн зайлшгүй чухал хүчин зүйлийн нэг нь иргэдийн боловсролын түвшин юм. Тэр тусмаа ирээдүйг авч явах хүүхдүүдийн боловсрол нь аль ч улсын тэргүүлэх ач холбогдолтой асуудал болсоор байна. Тийм ч учраас Монгол улс 2004-2005 оны хичээлийн жилээс “Сургуулийн өмнөх болон бага дунд боловсролын шинэ стандарт”-ыг хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд ЖАЙКА болон БСШУЯ хамтран 2006 оны 4 дүгээр сараас “Суралцагчдын суралцахуйг дэмжих арга зүйн хөгжил” төслийг хэрэгжүүлж байна.

Төслийн хүрээнд боловсруулсан шинэ арга зүйг нэвтрүүлснээрээ хүүхдүүд “Бие даан өөрөө сурах чадвар”-ыг эзэмшиж чадах юм. Энэ “Бие даан өөрөө сурах чадвар”-ыг эзэмших нь зөвхөн хүүхэд насны бус насан туршийн үнэт зүйл болох чадварын нэг нь гэж хэлж болох бизээ. Ирээдүйн нийгэмд амьдрахад хэрэг болох энэ чадварыг хүүхдүүдэд эзэмшүүлж байгаа нь жинхэнэ “Боловсрол”-ыг олгож байгаа хэрэг гэж би боддог. Ийм чадварыг хүүхдүүд эзэмшихэд багш нараас их зүйл хамаарна.

Зөвлөмжийг хэрэглэх гэж буй багш нартаа хандан хэлэхэд хичээл бүртээ энэхүү шинэ арга зүйг нэвтрүүлэн хэрэглээсэй гэж хүсэж байна. Багшийн хувьд болон сурагчийн хувьд ч гэсэн суралцах баяр баяслаар бялхсан хичээл болох байх гэж бодож байна. Мөн та бүхнийг хүүхдүүдийн сурах хүсэл эрмэлзлээр дүүрэн байгаа тэр л хүсэл эрмэлзэл сэтгэлийг өдөөж, тэднийг дэмжиж ажиллаасай гэж хүсч байна.

Энэхүү зөвлөмжийн зорьж буй “Хүүхдүүд өөрөө бие даан суралцах чадварыг нээн хөгжүүлэх хичээл” нь нэг өдрийн ч өмнө болтугай аль болох хурдан Монголд мөрдөх стандарт болохыг чин сэтгэлээсээ хүсэхийн ялдамд Та бүхний цаашдын ажил амьдралд өндөр амжилт хүсье.

ЯПОНЫ ЗӨВЛӨХ БАГШИЙН ӨМНӨТГӨЛ

Токио Гакүгэй их сургуулийн
профессор Шигэру Асанума

Монгол Улсын багш нарт зориулсан төсөлт ажил хичээлийн зөвлөмж бичих төсөл хэрэгжээд 3 жилийн хугацаа өнгөрчээ. Боловсролын салбар дахь хөтөлбөр төсөлд хэзээ ч төгсгөл гэж байдаггүй ч, одоогоор энэ төслийн хүрээнд маш олон үр дүн, ололт амжилтууд тодрон гарсаар байна. Энэ нь бидний хүсэн хүлээж байсан үр дүнд хүрэхэд ойртож байгааг илтгэнэ. ЕБС-д хэрэгжүүлэх төсөлт ажлаас суурь боловсролын түвшний төсөлт ажилд хамгийн чухал нь “Би, Бид, Хамтдаа” гэсэн тулгуур багана дор чиглүүлэх ажил юм. Энэ багана хэдий чинээ бат бөх байх тусам олон сонирхолтой баримт жишээг цуглуулах боломж бүрдэх бөгөөд энэ нь нэн чухал юм.

Анхандаа энэ хичээлийн тухай хаанаас, юунаас эхэлж ойлгуулах вэ? гэж тээнэгэлзэж, Японы төсөлт ажлын янз бүрийн бодит жишээг танилцуулах замаар Монголын багш нарт төсөлт ажил хичээл ямар чухал болохыг ойлгуулахын төлөө чармайн ажиллаж байлаа. Ингээд олон сонирхолтой туршлагаудтай танилцуулж, тэд ч мөн хамтдаа суралцаж байлаа. Японы жишээнээс танилцуулахдаа “эрэл хайгуул хийх” гэсэн хамгийн энгийн бөгөөд ерөнхий аргаас эхлүүлсэн юм. Энэ үед монгол хүүхдүүд аливаа ажилд чин сэтгэлээсээ хүсэл эрмэлзэлтэй хандаж байсан бөгөөд мөн маш их хичээл зүтгэлтэй эрэл хайгуул хийцгээж байсныг дурьдахгүй өнгөрч болохгүй. Тэд Монголын уламжлалт анагаах ухаан, ургамал ногоо арчлах арга ухаан, сургууль соёлоо хэрхэн цэвэр цэмцгэр байлгах тухай гэх мэт олон зүйлийг нягтлан судалж олон сайхан үнэтэй санааг дэвшүүлж байлаа. Өөрсдийн эргэн тойрны амьдрал ахуйн хүрээнд гэхээсээ илүү хийсвэр хол асуудал судлах вий гэж санаа зовж байсныг нуух юун. Тэгтэл огт санаа зовох хэрэггүй байжээ гэдгээ ойлгосон юм. Хүүхдүүд үнэхээр өөрсдөдөө шууд хамаатай, эргэн тойрныхоо асуудлыг хөндөн судалж байсанд маш их сэтгэл хөдөлж билээ.

Монголын багш нар хүүхдүүдийг өөрсдөө бие даан асуудал судлахад анхаарал хандуулан ажиллаж байлаа. Японы төсөлт ажил нь дийлэнхдээ багш нар нь асуудлыг дэвшүүлэх нь олонтаа байдаг. Хүүхдүүд өөрсдөө бие даан асуудлаа сонгож судалснаараа тэдний сурах үйл ажиллагаа нь амьдралд тулгуурласан сонирхолтой туршлага болсон юм. Ер нь хүүхдүүд эрүүл мэндийн сэдэв, түүн дотроо сургуулийнхаа орчны эрүүл ахуйн тухай, тамхи эрүүл мэндийг хэрхэн хордуулдаг тухай түлхүү судалж байлаа.

Хүүхдүүд томчуудаас илүү аливаад үнэнч шударгаар хандаж тэднээс илүү сэтгэн бодож байсан юм. Мөн хот тосгоныг бохирдуулж байгаа гялгар уут, хог хаягдал зэрэг асуудалд нухацтай хандаж судалгаа хийж байсан. Томчууд байсан бол орчны тухай асуудлаас бага зэрэг хөндийрсөн ч байж болох ч хүүхдүүдийн хувьд томчуудын харалган байгаа асуудлыг олж харж, түүнийгээ тууштай судалж ажилласан гэдгийг хэлэхийг хүслээ.

Монгол хүүхдүүдийн байгаль эх дэлхийдээ хандах чин зүрхний мэдрэмж болоод түүнийгээ илэрхийлэх чадвар нь асар баялаг юм. Тэгээд ч монголчууд дэлхийд

эгнэшгүй үндэсний сайхан соёл, ёс заншил, өв уламжлалтай ба өвлүүлэн үлдээх талаар анхаарч ажиллах нь зүйн хэрэг болов уу гэж боддог. Хүүхдүүд төсөлт ажлаараа судалсан асуудлаа чин сэтгэлээсээ, үнэхээр бусдад хүрэхээр илэрхийлж байлаа. Тэд дүрд тоглохдоо үнэхээр гарамгай байсан юм шүү. Асуудал дэвшүүлж судлах, түүнийгээ илэрхийлж байгаа байдал нь яг л мэргэжлийн драмын жүжигчид шиг байсан. Судалсан зүйлээ ийм их итгэл үнэмшилтэй бусдад илэрхийлэхийг тэсэн ядан хүлээсэн төсөлт ажлын жишээг урьд өмнө нь хаана ч үзэж байгаагүй гэдгээ хэлмээр байна.

Ерөөсөө төсөлт ажил үнэхээр сонирхолтой юм гэх хүүхдүүд олон байлаа. Монголын хувьд, туршигдсан төсөлт ажил нь ололт амжилтаар дүүрэн байна. Аливаа үйлдвэрлэл, бүтээн байгуулалтыг эхлүүлэх оюун санаа сэтгэлгээ нь төсөлт ажил хичээлээр дамжуулан улам бүр өргөжин хөгжих биз ээ. Тиймээс цаашдаа Япон улс Монголын төсөлт ажлаас суралцах ёстой гэж бодож байгаагаа дахин илэрхийлж Монголын нийт багш нартаа улам ихийг хийж бүтээхийг хүсэн ерөөе.

«ТӨСӨЛТ АЖЛЫН АРГА ЗҮЙ» ГУРАВ ДАХЬ ЖИЛИЙН ЗӨВЛӨМЖИЙН ОНЦЛОГ БА АШИГЛАХ ЗААВАР

Энэхүү «Зөвлөмж-III» маань өмнөх жилүүдэд гарсан хоёр зөвлөмжтэйгөө нягт уялдаатай ба дараах хэд хэдэн онцлогтой. Үүнд:


1. “Суралцагчдын суралцахуйг дэмжих арга зүйн хөгжил” төслийн хүрээнд боловсруулсан «Төсөлт ажлын арга зүй» зөвлөмж-1, 2-ын үргэлжлэл болгож бага болон суурь боловсролын түвшинд төсөлт ажлыг монголын хөрсөнд буулган туршиж заасан багш нарынхаа туршилтыг төрөлжүүлэн нэгтгэн орууллаа. Хэдийгээр тодорхой сэдвийн дор төрөлжүүлэн оруулсан ч ямар сэдвийг голлон түлхүү судалсан бэ? гэдгээр нь «Байгаль орчны сэдэв голлосон төсөлт ажил», «Эрүүл мэндийн сэдэв голлосон төсөлт ажил» гэх мэтээр гарчигласан ба тухайн төсөлт ажлын дотор бусад сэдвүүд ч бас зэрэг хөндөгдсөн болно.
2. «Төсөлт ажил» нь хэдийгээр тогтсон стандарт, хөтөлбөр байхгүй ч тухайн орон нутаг болон сургуулийн онцлогийг тусган янз бүрийн түвшний төлөвлөлтүүдийг жил, улирал, цагаар хийж болохыг япон болон монголын багш нарын бодит жишээн дээр тулгуурлан бичиж орууллаа.
3. БСШУ-ны сайдын 2007 оны 8 дугаар сарын 20-ны өдрийн 296 дугаар тушаалаар баталсан «Ерөнхий боловсролын 12 жилийн сургуулийн дунд ангийн сургалтын төлөвлөгөө»-ний тайлбарт зааснаар төсөлт ажлаар суралцагчдад иргэний ба тогтвортой хөгжлийн боловсролыг олгоход чиглэсэн агуулгыг оруулах болсонтой уялдуулан төсөлт ажлаа тогтвортой хөгжлийн боловсролын агуулгатай хэрхэн холбон явуулж болохыг «Тогтвортой хөгжлийн асуудлыг хөндсөн төсөлт ажил» гарчигт бодит жишээгээр оруулсан ч бусад гарчгуудын дотор гол асуудлаа болгон судлаагүй боловч тодорхой хэмжээнд судалж тайлагнасан олон сайхан жишээг уншиж болно.
4. Энэхүү зөвлөмжөө эхний 2 жилийн зөвлөмжийн үр дүнг нэгтгэн дүгнэсэн, цаашид төсөлт ажлыг бага, суурь боловсролын түвшинд явуулах багш нар болон бусад хүмүүст нэгдсэн ойлголт өгөх, төсөлт ажлыг жинхэнэ утгаар нь хэрэгжүүлэхэд нь ширээний ном болгон толилуулж байгаа бөгөөд зөвлөмж ашиглах явцад эхний 2 жилийн зөвлөмжтэй уялдуулж, тодруулж унших шаардлагатай хэсгүүдэд хаалтан дотор тайлбар зүүлт оруулж өгснийг анхаараарай.

«Төсөлт ажил» баг

II БҮЛЭГ. ТӨСӨЛТ АЖЛЫН ТӨЛӨВЛӨЛТ

“Төсөлт ажлын арга зүй”-н өмнөх 2 зөвлөмжид төсөлт ажлын хөтөлбөрийг хэрхэн боловсруулах талаар тодорхой мэдээлэл, жишээ баримт оруулаагүй бөгөөд туршилтын явцад багш нар өөр өөрийн гэсэн арга барилаар хөтөлбөр боловсруулж ирлээ.


Ер нь аливаа ажлын үр дүн нь бэлтгэл, төлөвлөлтөөсөө шууд хамаардаг. Тэгээд ч төсөлт ажлын гол онцлогийн нэг нь багш, сурагч аль алинд нь нээлттэй байдаг төлөвлөлт юм. Хэдийгээр тухайн төсөлт ажлын явц хэрхэн өрнөхийг хичээл шиг урьдчилж төлөвлөхийн аргагүй ч ерөнхий баримжаа өгөх зорилгоор “Төсөлт ажлын төлөвлөлт”-ийг хийхдээ багшийн зүгээс юу юуг анхаарахыг энэхүү бүлэгт товч оруулж өглөө.



Ер нь төсөлт ажилд алс хэтээ харсан, системтэй үйл ажиллагааны төлөвлөлтийг хийх явцдаа тухайн үйл ажиллагаа тус бүрийн зорилгыг багтааж багцалсан 3, 4 жилийн хугацаанд хийх төсөлт ажлын нэгдсэн хүснэгтийг гаргах нь тодорхой тодорхой зорилго бүхий систем дэс дараатай үйл ажиллагааг хоорондын холбоо хамааралтай нь цогц байдлаар хэрэгжүүлж явахад удирдамж болдог байна. Үүнийг дараах жишээнээс харна уу.

жишээ-1

“ТӨСӨЛТ АЖЛЫН ЗОРИЛГО”



Ийнхүү төсөлт ажлын зорилгоо тодорхойлоод үйл ажиллагаанд оролцогчиддоо маш сайн танилцуулах хэрэгтэй. Ингэхдээ дараах зүйлүүдийг анхаараарай. Үүнд:

- Сурагчдад зорилгоо танилцуулах үед багш болон зэргэлдээ, ахлах ангийн туршлагатай сурагчдыг байлгах нь ач холбогдолтой байдаг байна. Ингэснээр тэд бие биенээсээ суралцахын хамтаар өөрсдийн санаа оноогоо нэмэрлэх боломж нээгддэг.
- Орон нутгийн байгаль орчин, нөхцөл байдал, сурагчдаа судалсны үндсэн дээр зорилгоо тодорхойлно. Ингэхдээ судалж байгаа хичээлүүд болон орон нутгийн үйл ажиллагаатай хэрхэн уялдуулахаа анхаарна.
- Эцэг эхчүүдэд төсөлт ажлынхаа талаар тодорхой ойлголт өгөх нь тэдний оролцоог сайжруулах сайн талтайг туршигч багш нар бүгд дүгнэсэн байдаг. Манай нөхцөлд эцэг эхийн хурлаар дамжуулж хэрэгжүүлэх боломжтойг туршилтаар харуулсан юм. Харин бусад орны хувьд “Эцэг эх, багш нарын холбоо (РТА) г.м. сайн дурын үйл ажиллагаагаараа нэгдсэн байгууллагуудаар дамжуулж тэднийг идэвхтэй оролцуулдаг байна.

Төсөлт ажлын төлөвлөлтөд хамгийн чухал анхаарах зүйлийн нэг бол төсөлт ажлын талаарх ерөнхий чиглэл. Тухайлбал, Японд дунд ангийн төсөлт ажлыг төлөвлөх “Төсөлт ажлын ерөнхий багана” байдаг бөгөөд үүнийг үндэслэн төлөвлөлтөө хийдэг байна.


Ингэхдээ хичээл, хичээлээс гадуурх ажил (ХГА)-ын уялдаа холбоог хэрхэн хангах, ямар ямар агуулга-сэдвийн хүрээ байж болох, сурагчдад ямар ямар чадвар төлөвшил олгож болохыг ерөнхий “хар зураг”-аар өгдөг байна. Үүнээс үндэслэн 3 жилийн хугацаанд хийх төсөлт ажлынхаа зорилго, хөтөлбөр, төлөвлөгөө, хүлээгдэж буй үр дүнгээ тооцож ажилладаг бөгөөд 3 жилийн төлөвлөгөөнөөс цааш задарч тухайн жил, улирал, 7 хоног, өдрийн төлөвлөлтийг хийх баримжаа болдог байна (*Дараах бүдүүвчээс харна уу*).



Үүнийг тус бүрт нь задалж “Төсөлт ажлын ерөнхий багана” (Асанума Шигэру “Төсөлт ажлын киррикулим боловсруулах нь”, Токио, 2000, 168 дахь тал), “Гурван жилийн төлөвлөгөө” (“Хүүхэд бүрийн суралцах үйл ажиллагааг хөгжүүлэх нь”, Токио, 2006, 126 дахь тал), “Улирлын төлөвлөгөө” гэсэн дараах бүдүүвчүүдээр жишээ болгож харуулъя.

жишээ-2

“ТӨСӨЛТ АЖЛЫН ЕРӨНХИЙ БАГАНА”



жишээ-3

“ГУРВАН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ”

Анги	Нэгдүгээр улирал	Хоёрдугаар улирал	Гуравдугаар улирал
Долоодугаар анги [Нутаг орноосоо суралцагч]	1. (Дунд ангид элсэн орох) Сургууль дотор судалгаа хийх Төсөлт ажил гэж юу вэ?	2. (Сэдэв сонголт) Нутаг дэвсгэртээ байгаа мэдэхгүй зүйлээ эрж хайх, нээлт хийх-1 (анги нийтээр, багаар)	3. (Сэдэв сонголт) Нээлт-2 (анги нийтээр, багаар) Сурах аргад суралцах
	Сурах аргад суралцах	Нутаг дэвсгэрээ таньж мэдэх	Бусад хичээлтэй интеграцчилах
Наймдугаар анги [Нутаг орондоо суралцагч]	4. (Ажлын байртай биеэр танилцах, хөдөлгөөнт танхим) Нутаг дэвсгэрийнхээ нийгэм болон хүмүүсийн амьдралтай танилцах (багаар, анги нийтээр)	5. (Хичээлээс гадуурх ажил) Дээр үед амьдарч байсан хүмүүсийн амьдрал, эд эдлэлийг судлах (багаар)	
	Өөрийн ирээдүйн төлөвлөгөөг цаашдын чиглэлтэй нь уялдуулах	Хичээлээс гадуурх ажилтай холбох	Ерөнхий эрдмийн хичээл болон хичээлээс гадуурх ажилтай холбох
	Тусгайлсан хөтөлбөр [Одоо амьдарч буй хүмүүсээс суралцах] (Найм, есдүгээр ангид) 6 удаа		
	Хүүхдийн ирээдүйн төлөвлөгөөтэй холбох		
Есдүгээр анги [Амьдрах ухаанаас суралцагч]	6. (Аяллаар явах) Киото хотод амьдардаг хүмүүсийн амьдрал, эд хэрэглэлийг судлах (багаар)	7. (Төгсөлтийн өмнөх судалгаа) Миний сүүлчийн судалгаа - 15 насны шийдвэр (ганцаарчилсан, багаар)	
	ерөнхий эрдмийн хичээл болон хичээлээс гадуурх ажилтай холбох	дунд ангийн төгсөлтийн диплом гэх мэтэд тусгах	

жишээ-4

“УЛИРЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ”

Бүлэг сэдвийн нэр	Асуудал дэвшүүлж шийдвэрлэх үе шат	Сургалтын үйл ажиллагаа
Судалгаа А	Танилцуулга	■ Өөрийн сонгосон удирдагч багштай уулзаж, судалгааны төлөвлөгөөгөө тайлбарлах, танилцуулга хийлгэх
	Сэдвийн судалгаа	■ Судалгааны төлөвлөгөөгөө засварлан сайжруулах явцдаа дэвшүүлсэн асуудлаа шийдвэрлэх (мэдээлэл цуглуулах, боловсруулах, засч сайжруулах)-ийг эрмэлзэх
	Сэдвийн судалгааны тайлан	■ Судалгааны үр дүнг доод ангийн сурагчдад зориулж (10 минут: судалгааны баг тус бүр) илтгэх
	Удирдсан багштай хийх уулзалт	■ Өөрийн асуудал дэвшүүлсэн судалгааг удирдагч багштайгаа хамтран эхнээс нь дахин хянах
Судалгаа Б	Бүлгийн тайлан	■ Бүлгийн тайланг дахин явуулж, судалгааны үр дүнг хамтдаа эзэмшинэ.
	Асуудал дэвшүүлсэн судалгааг нэгтгэх Удирдсан багштай хийх уулзалт	■ Асуудал дэвшүүлсэн судалгаагаар сурч мэдсэн, эзэмшсэн зүйл, мөн цаашид хиймээр байгаа судалгааны талаар нэгтгэх,
	Асуудал дэвшүүлсэн судалгааны тайлан бичих	■ Судалгааны үр дүнг асуудал дэвшүүлсэн судалгааны тайлан (А4 2 хуудас)-д нэгтгэнэ.

Бид төслийн хүрээнд боловсруулсан 2 дахь жилийн зөвлөмждөө өөрийн орны онцлог, багш нарынхаа ажиглалт судалгаа, сурагчдынхаа хэрэгцээнд тулгуурлан дунд ангийн төсөлт ажлын ерөнхий чиглэлийг “БИ–БИД–ХАМТДАА” гэсэн байдлаар 3 жилээр гаргаж өгсөн (Ц.Наранцэцэг, Б.Булган, Ц.Оюун, Наканиши Рейко “Төсөлт ажлын арга зүй” зөвлөмж-3, УБ., 2008, 22 дахь тал) ба өнгөрсөн хичээлийн жилд “Би” гэсэн агуулга-сэдвийн хүрээнд долоодугаар ангид туршилт явуулсан бол 3 дахь жилд “Бид” гэсэн агуулга-сэдвийн хүрээнд наймдугаар ангид туршилтаа явууллаа.

Хэдийгээр “Суралцагчдын суралцахуйг дэмжих арга зүйн хөгжил” төсөл маань энэ хичээлийн жилийн төгсгөлд дуусах ч есдүгээр ангид “Хамтдаа” агуулга-сэдвийн хүрээнд үргэлжлүүлэн туршвал асуудлыг бүхэл цогц байдлаар судлах болно гэдгийг та бүхэн анхаарч ажиллана гэдэгт эргэлзэхгүй байна.

ТӨСӨЛТ АЖЛЫН НЭГ ЦАГИЙН ХӨТӨЛБӨР

Жил, улирал, сар, өдрийн төлөвлөлтүүдээс яг тухайн цагийн өөрөөр хэлбэл хичээлийн нэгжийн (*хичээлийн нэгжийн тодорхойлолтыг төслийн хүрээнд гарсан “Төсөлт ажлын арга зүй” зөвлөмж 1-ийн хавсралтаас харна уу*) хичээлийн онцлог, үр дүн болон сурагчдын эрэлт хэрэгцээг онцгой харгалзан үзэж байж дараагийн цагаа төлөвлөх нь зохимжтой. Өөрөөр хэлбэл төсөлт ажлын хувьд тухайн улиралд танхимд орох 5 цагийг урьдчилж нэг зэрэг төлөвлөх аргагүй гэсэн үг. Заавал өмнөх тайлангийн үр дүнгээс дараагийн цагийг хэрхэн төлөвлөхөө тооцно гэж ойлгож болно.

Төслийн хүрээнд бага болон суурь боловсролын түвшинд төсөлт ажлыг туршсан багш нар маань хэдийгээр төсөлт ажлаа хэрхэн төлөвлөх талаар туршлага бага байсан ч өөр өөрийн гэсэн арга барилаар тухай бүр төлөвлөж байсан бөгөөд зарим жишээг дор орууллаа. Заавал яг ийм хэлбэр загвараар биш өөр ямар ч байдлаар төлөвлөж болох нь та бүхэнд нээлттэй гэдгийг хэлье.

Ер нь бусад хичээлүүдийн адил бүх явцыг урьдчилан төлөвлөх боломжгүй ч дараах байдлаар ерөнхий төлөвлөж болох юм гэж үзэж байна. Харин багш хичээлийн явцад сурагчдын ярианы гол санаа, шинээр дэвшигдэж буй асуудал, нэмж тайлбарлах зүйл зэргийг байнга тэмдэглэл хөтлөх нь практик ач холбогдолтой болохыг манай туршсан багш нар маань ярьдаг юм.

Ерөөсөө төсөлт ажлын явцад багш тогтмол тэмдэглэл хөтлөх шаардлагатай байдаг. Тэгж баймааж нь төсөлт ажлын маань гол зүйл болох “үйл явц”-д анализ хийж сурагчдаа хөгжих төлөвшихөд нь тусалж чадна гэсэн үг. Энэхүү төлөвлөлт нь “ЕБС-ийн 12 жилийн тогтолцооны сургалтын төлөвлөгөө”-нд 3-9 дүгээр ангид долоо хоногт 1 цагаар суугдаж өгсөн “Төсөлт ажил” гэсэн цагийн төлөвлөлт болно. Энэ төлөвлөлтийг хэрхэн хийж болохыг дараах хөтөлбөрөөр жишээ болгон харна уу.

жишээ-5

Сэдэв/агуулга: “БИ УГИЙН БИЧГЭЭ ЗОХИОЛОО”

Хамрах хүрээ: Сэлэнгэ аймгийн төвийн 4-р 11 жилийн сургуулийн 7-б анги

Хугацаа: 2008.2.26. (танхим 212, эцсийн тайлан)

Боловсруулсан багш: Д.Нарантуяа

Зорилго: Гэр бүл, удам угсаагаа мэдэж бахархах үзэл төлөвшүүлэх

Зорилт:

- Суралцагчид хичээлээр олж авсан мэдлэгээ хэрэглээ болгох чадварт сургах
- Бусдад өөрийгөө нээх боломж олгох

Хэрэглэгдэхүүн:

- “Монгол Улсын угийн бичгийг хөтлөх гарын авлага”
- 9-р ангийн эрүүл мэндийн сурах бичиг
- “English-3” сурах бичиг
- Сэлэнгэ аймгийн Сүхбаатар хотын иргэн И.Цоодол гуайн хөтөлсөн угийн бичиг
- ватум цаас, эсгий бал, өнгийн цаас

Хэрэгцээ:

1. Гэр бүлийн уламжлалыг дээдлэн удам угсаагаа мэдэх
2. Удамшлын өвчин эмгэг, оюун ухааны хомсдолтой хүүхэд төрөхөөс урьчилан сэргийлэх
3. Цус ойртохоос сэргийлэх

Агуулгын залгамж холбоо:

Өмнө судалсан агуулга	Цаашид судлах агуулга
- Монголчууд үр хүүхдэдээ нэр хэрхэн өгдөг зан үйл, уламжлал - Нэр цээрлэх ба эерүүлэх ёс - Нэрээ эрхэмлэн хайрлахын учир - Угийн бичийг хөтлөхийн ач холбогдол	- Гэр бүл бололцох, хуримлах - Насны ой тэмдэглэх - Хүүхдийн даахь үргээх - Хүүхдийг угаах зэрэг зан үйлийг судлах

Судлагдахуун	Ур ухаан
Миний зохиосон уийн бичиг нь гэр бүлдээ оруулсан том хувь нэмэр	- Асуудлыг олж харах, дэвшүүлэх чадвар олгох - Өөрсдийн сонирхсон зүйлээ судалж мэдэх нөхцөл бүрдүүлэх - Хүүхдэд сурах, судлах барилын хандлага төлөвшүүлэх

Арга зүйн зохион байгуулалт: Асуудал дэвшүүлж шийдвэрлэх

Сурагчдыг 4 багт хувааж ажиллуулна. Баг бүр өөрсдийн зохиосон угийн бичгийн давуу талыг гаргаж хэлэлцэнэ.

Хичээлийг сурагч Хонгорзул, Гантогтох, Амартүвшин нар удирдан явуулна.


Хичээлийн үйл явц:

Үйл явц	Сурагчдын үйл ажиллагаа	Багшийн дэмжлэг	Анхаарах зүйл
Сурагчдын дотоод нөөцийг илрүүлэх, асуудал дэвшүүлэх	1. Сэдвийн тороо товч танилцуулах 2. Өмнөх хичээл дээр сурч мэдсэнээ сэргээн санах 3. Үгийн сүлжээ бөглөх	Үйл явц болон сурагчдын яриаг анхааралтай сонсож, чиглүүлж дэмжих	Сурагчдыг ярих явцад багш байнга тэмдэглэл хөтлөх

Шинэ мэдээлэл солилцох мэдлэг бүтээх	• Өөрсдийн зохиосон угийн бичгээ тайлбарлах • Угийн бичиг хөтлөхийн ач холбогдол, хөтлөхгүй байхын хор уршгийг дүрээр тоглож үзүүлэх	Угийн бичгээ хэрхэн яаж хийснийг анхааралтай харж нэмэлт зөвлөгөө өгөх	• Сурагчид бусдынхаа яриаг хэр анхааран хүлээж авч, ойлгож байгааг багш ажиглах • Бусад нөхдөдөө сонсогдохоор ярихыг анхааруулах
Бататгах, шүүн ярилцах, нэгтгэн дүгнэх	• Өөрсдийн зохиосон угийн бичгийнхээ давуу талыг ярих • Аль загвараар угийн бичгээ хөтлөхөө сонгох • Үнэлгээний багийнхан сурагчдын хийсэн ажилд үнэлгээ өгөх	Сурагчдад товч тодорхой цэгцтэй ярихыг анхааруулж явах	• Сайн сонирхолтой хийсэн угийн бичгүүдийг ангийн хананд тогтмол байрлуулах • Цэгцтэй ярьж буй сурагчдаас үлгэр дуурайл авахыг сануулах


III БҮЛЭГ. ТӨСӨЛТ АЖЛЫГ ТУРШСАН БОДИТ ЖИШЭЭ

Энэхүү төслийн хүрээнд төсөлт ажлын шинэ арга зүйг бүтээхэд олон хүн, хамт олны хөдөлмөр шингэсэн ба ялангуяа төслийн эхний жил УБ хотын загвар 3 сургуулийн 6 багш (**Э.Мөнхтуяа, Г.Норжмаа, С.Лхагвацэнд, З.Нина, С.Алтантуяа, С.Дуламрагчаа**) төсөлт ажлыг бага боловсролын түвшинд, 2 дахь жилд УБ хот, Сэлэнгэ, Дорнод аймгийн нийт 9 багш (**Т.Эрдэнэчимэг, Д.Энхтуяа, Ц.Оюунсанаа, Д.Ууганбаяр, В.Оюунбилэг, Д.Нарантуяа, О.Дэлгэрцэцэг, С.Оюунчимэг, Ц.Энхмаа, Б.Уранжаргал, Ц.Дулмаа**) төсөлт ажлыг суурь боловсролын түвшинд тус тус амжилттай туршиж, өөр өөрийн гэсэн өвөрмөц арга барилаар хэрэгжүүллээ. Хэдийгээр туршигч багш нар маань төсөлт ажлыг явуулах туршлага хомс байсан ч өөрсдийн мэргэжлийн ур чадвар, багшлах эвдүй, шавхагдашгүй эрч хүчээрээ Монголын багш нарт үлгэр болохуйц өвөрмөц шинэ арга зүйг бүтээж чадлаа гэж “Төсөлт ажил” багийнхан дүгнэж байна.



3.1. БАГА БОЛОВСРОЛЫН ТҮВШИНД ТӨСӨЛТ АЖЛЫГ ТУРШСАН ҮР ДҮН, СУРГАМЖ

3.1.1. БАЙГАЛЬ ОРЧНЫ СЭДЭВ ГОЛЛОСОН ТӨСӨЛТ АЖИЛ



Төв аймгийн Алтанбулаг сумын дунд сургуулийн захирал Ганбүргэдэд хүсэлт тавьж зөвшөөрсний дагуу 2008 оны 9-р сард “Суралцагчдын суралцахуйг дэмжих арга зүйн хөгжил” төслийн Төсөлт ажил багийнхан зөвлөх профессор Асанума Шигэрүгийн хамт тус сургуультай танилцахаар очиход нийгмийн ажилтан Н.Оюун-Эрдэнэ, англи хэлний багш Ү.Маналжав, бага ангийн багш З.Баярбилэг нар найрсгаар хүлээн авч, сургуулиа танилцуулж явтал сахилдаган цэцэг, усан цэцэг зэргийг хонгил, анги танхимуудад хаа сайгүй ургуулсан байхтай тааралдав. Сонирхон асуувал, өнгөрсөн хичээлийн жилийн IV улиралд төсөлт ажлаараа энэхүү 2 төрлийн цэцгийг олноор нь үндэслүүлж тарьжээ.



Үндэслүүлсэн цэцгээ дөнгөж шороонд суулгаж байгаа нь



Тарьсан цэцэг нь 5 сарын дараа танигдахын аргагүй том болжээ.

Үүнээс үүдэн, төсөлт ажлыг хэрхэн явуулдаг тухай нийгмийн ажилтан Н.Оюун-Эрдэнээс сонирхсонд, ЕБС-д төсөлт ажил хичээл орж эхэлсэн цагаас энэ хичээлийг сум, орон нутгийнхаа онцлогт тохируулан явуулж, тодорхой үр дүнд хүрсэн тухайгаа ярих. Энэ сургуулийнхан өөрийн сумын нутаг дэвсгэрт орших Хустайн нурууны тахь үржүүлгийн газартай нягт хамтран ажилладаг ба байгалийн унаган төрхийг хадгалахын тулд жил бүр Хустайн нурууны ойр орчмын газрыг цэвэрлэдэг уламжлал тогтсон байна. Тахь үржүүлгийн газрынхан ч тус сургуулийн хичээлийн байрны номын сан, биологийн кабинет, мөн дотуур байрыг тохижуулж өгснөөс

гадна сурагчдын дунд байгаль орчныг хамгаалах талаар мэдээлэл хийх, зөвлөгөө өгөх, эсээ бичих болон зургийн уралдааныг жил бүр зохион байгуулдаг гэнэ. Үүний үр дүнд энэ сургуулийн багш, сурагчид байгаль орчноо хайрлан хамгаалах, цэвэр цэмцгэр байлгах талаар олон ажлыг санаачлан явуулдаг болжээ.

Ингээд 2006-2007 оны хичээлийн жилийн I улиралд энэ сургуулийн бага ангийн багш Д.Эрдэнэсүрэн, Э.Байгалмаа, Ц.Дуламсүрэн, З.Баярбилэг нар 6-а, 6-б, 5-а, 4-а ангийн сурагчидтай хамтран явуулсан нэгэн сонирхолтой төсөлт ажлыг танилцуулъя. Учир нь энэ ажлын талаар нийгмийн ажилтан Н.Оюун-Эрдэнэ бидэнд маш тодорхой ярьж өгсөн төдийгүй сурган хүмүүжүүлэх тэмдэглэл, холбогдох зураг, зарим материал зэргийг өгсөн нь үнэ цэнэтэй зүйл байлаа.

ЭХНИЙ АЛХАМ

5-р ангийнхан байгалийн ухааны хичээл дээрээ “Ус” сэдвийг үзэх явцад тэдэнд, *“Хүн усгүйгээр удаан амьдарч чадахгүй учир усаа яаж цэвэр тунгалагаар нь байлгах вэ? Ус ба хүний эрүүл мэнд ямар холбоотой юм бол? Усаар дамжиж, хүний эрүүл мэнд хохирч болох уу? Ерөөсөө бид чинь ямархуу усаар ундаалдаг юм бэ? Манай сумын худгууд хүний эрүүл мэндэд хэр тохиромжтой ус түгээдэг юм бол?”* г.м. бодлууд төржээ. Тэгээд энэ санаагаа нийгмийн ажилтандаа хэлж, 4-6 ажил явуулахаар тохиролцож, багш нар нь ч зөвшөөрчээ.

Ингээд сонгосон сэдвээрээ нухацтай ярилцтал, их өргөн хүрээтэй олон асуудал хөндөгдсөн тул судлах зүйлээ хумьж, аль болох шийдвэрлэж болох, ахуй амьдралд ойр, тодорхой сэдэв болгох үүднээс ерөөсөө Алтанбулаг суманд байдаг 3 худгийн усыг “Аль худгийн ус нь цэвэр вэ?” сэдвийн дор судалгаа хийхээр тогтов. Учир нь дээхэн үед Туул голоосоо л хүн мал ундаалдаг байсан бол 1990-ээд оноос Туулын ус харьцангуй бохирдолттой урсан өнгөрөх (Туул гол Улаанбаатараас Алтанбулагийг дайран урсдаг) болсноос худгууд баригдах болжээ. Одоо бол Туулын ус маш бохир байгаа болохоор хүн битгий хэл, зарим үед малаа услахад аюултай болжээ. Алтанбулаг суманд 3 худаг байдаг бөгөөд тэдгээрийг нутгийнхан Төв худаг, Урд худаг, Хойд худаг гэж ялган нэрлэдэг аж.

Сүүлийн үед энэ суманд олон хүн элэгний хатуурал өвчнөөр өвчлөх болсны нэг шалтгаан нь худгийн ус байж магадгүй гэсэн яриа нутгийнхны дунд бас яригдах болсон байна. Энэ яриа хэр үнэний ортойг мэдэхийн тулд сурагчид анги ангиараа ярилцсан ба ихэнх сурагчид хамгийн түрүүнд сумын хүний их эмч Л.Алтанхуягтай уулзах нь зөв гэдэг дээр санал нэгджээ.

ХОЁР ДАХЬ АЛХАМ

Ингээд Алтанхуяг эмчтэй уулзаж, сумын худгуудаас дээж авч шинжилгээнд явуулдаг тухай, шинжилгээгээр Төв худаг нь сумын төвд байрладаг тул газрыг хөрсөөр дамжин маш их бохирдсон байна гэсэн хариу ирсэн тухай, Хойд худгийн ус хатуулаг ихтэй, тунгалаг биш байдаг тухай, унданд хамгийн сайн тохирох цэвэрхэн устай нь Урд худаг болох тухай олон мэдээллийг баримттайгаар мэдэж авсан

байна. Эмч зөвхөн худгийн усны тухай биш, усны зөв хэрэглээний талаар, хүүхдүүд ойрыг нь бодож хамгийн их бохир устай Төв худгаас усаа авдаг учир сургуулийнхаа сурагчдад сэрэмжлүүлэх үүднээс сурталчилгааны ажил хэрхэн хийх талаар ч зөвлөгөө өгөв. Ийнхүү хүүхдүүд, Алтанхуяг эмчээс хангалттай мэдээлэл аваад, бүх худагтай биечлэн танилцацгаажээ.



Д.Эрдэнэсүрэн багштай ангийнхан худгуудтай танилцахаар явахын өмнө (сургуулийнхаа гадаа)



Худгуудыг судалж буй хүүхдүүд багш Э.Байгалмаагийн хамт бохирдолт ихтэй Төв худгийн гадаа

Тэгээд нэн түрүүнд хэдий бохирдолгүй ч гэсэн хатуулаг ихтэй, булингартай ус бүхий Хойд худгийн усыг яаж цэвэршүүлэх тухай бодоцгоожээ. Энэхүү төсөлт ажлын явцад нэг асуудлаас нөгөө асуудал руу орохдоо заавал анги дотроо нухацтай ярилцаж, дараа нь шинээр цуглуулсан мэдээллээ 7 хоногт 1 удаа анги хоорондоо солилцдог байжээ.

ГУРАВ ДАХЬ АЛХАМ

Хүүхдүүд, “Хойд худгаа хүний эрүүл мэндэд тохирсон устай болгочихвол сумынхан маань цэвэр устай 2 худагтай болчихно. Цаашлаад нутгийнхны маань эрүүл мэндэд ч сайнаар нөлөөлнө. Иймээс хэнд хандаж ямар тусламж хүсэх вэ?” гэдэг гарцыг хайж эхэлжээ. Ингээд юутай ч гэсэн Хойд худгийн ус түгээгч Дүгэрсүрэн гуайтай очиж уулзахаар бага ангийн багш Байгалмаа, Дуламсүрэн нартай хамт худаг дээр очжээ.



Хүүхдүүд ус түгээгч Дүгэрсүрэн гуайтай уулзахаар Хойд худаг дээр багш нарынхаа хамт очжээ

Дүгэрсүрэн гуайгаас энэхүү худаг нь 2005 онд баригдсан ч, магадгүй гүн ухагдаагүйн улмаас ус нь тааруу байдаг байж магадгүй гэдэг яриаг сонсов. Тиймээс сумын ИТХ-ын даргад хандвал асуудлыг шийдэхэд туслах болов уу? гэдгийг хэлж өгөв. Ингээд сумын ИТХ-ын дарга Л.Адилбиштэй уулзан, өөрсдийн санаж сэдсэн ажлынхаа талаар нэгбүрчлэн танилцуулж, Хойд худгийн усыг цэвэршүүлэх талаар туслахыг хүссэнд дуртайяа хүлээн авч, улмаар дунд сургуулийн дотуур байранд байрладаг Хустайн цогцолбор газрын захиргааны төслийн зохицуулагч Л.Хад, Д.Батжаргал нартай уулзаж, хүүхдүүдийн хүсэлтийг албан ёсоор тавьжээ.

ДӨРӨВ ДЭХ АЛХАМ

Хустайн цогцолбор газрын захиргааныхан тус сургуультай хамтран ажилласаар ирсэн тул хүүхдүүдийн хүсэлтийг биелүүлэх, улмаар Алтанбулаг сумын иргэдийн эрүүл мэндийн асуудлыг шийдвэрлэхэд хувь нэмрээ оруулах зорилготойгоор туслахаа амласан байна. Төслийн албаныхан шат шатандаа хүсэлт тавьж, Хойд худгийн усны хоолойд шүүлтүүр тавих шийдвэр гаргуулжээ. Ингээд 2008 оны 5-р сард 2.800.000 төгрөгийн үнэ бүхий шүүлтүүрийг усны хоолойд тавьж өгсөн байна.




*Хатуулаг ихтэй, тунгалаг биш устай Хойд худгийн ус дамжуулах
хоолойд суулгасан усны шүүлтүүр*

Усны хоолойд шүүлтүүр тавьж, шүүлтүүр бүхий худгийг хүлээлгэн өгөх үйл ажиллагааг баяр ёслолын байдалтайгаар нээсэн байна. Нээлтийн үйл ажиллагаанд төсөлт ажлынхаа үр дүнг бодитойгоор харсан хүүхдүүд, багш нар, цэвэр ус хэрэглэх болсондоо баярласан нутгийнхан, энэхүү асуудлыг шийдвэрлэхэд оролцсон хүмүүс болон Хойд худаг байрлах 1-р багийн дарга Ч.Баттулга нар оролцсон байна. Одоо энэ сумын 1-р багийн гэр хорооллынхон зайдуу байрлах цэвэр устай Урд худаг руу явахгүйгээр ойрхноос ундныхаа усыг авч хэрэглэх болсон байна.

ДҮГНЭЛТ

Хэдийгээр энэхүү төсөлт ажлын жишээ нь “ССДАЗХөгжил” төслийн загвар сургуулийнх биш ч, багш нарт дараах хэд хэдэн үйл ажиллагааг бодитойгоор харуулж өглөө. Үүнд:

- ▶ Сэдвээ заавал төсөлт ажлын цаг дээрээ биш, бусад хичээлээс сэдэлжүүлэн гаргаж, хэрэгжүүлж болдгийг,
- ▶ Сонгож буй сэдэв нь ерөнхий биш, аль болохоор тодорхой, ахуй амьдралд ойр байх тусмаа судалгаа тарамдахгүй, тодорхой зүйл дээр төвлөрч, үр дүнд хүрдгийг,
- ▶ Хэдийгээр бага болон суурь боловсролын төсөлт ажил нь онцлог ялгаатай явагддаг ч нарийн зааглалгүйгээр, асуудлыг судлаад тайлагнах хэлбэрээр (энэ хэлбэр бага, дунд ангид аль алинд нь байдаг) бага, дунд ангийн хэд хэдэн бүлэг нийлж, төсөлт ажлаа явуулж болдгийг,
- ▶ Ялангуяа хөдөө орон нутагт төсөлт ажлын хүрээнд сургуулиас бусад байгууллагууд шат шатандаа хэрхэн хамтарч ажиллаж болдгийг,
- ▶ Багш нарынх нь ярьснаар, санаж сэдсэн ажил нь санаснаас ч илүү үр дүнд хүрсэн учир хүүхдүүд хийсэн ажлаараа бахархаж, өөртөө итгэх урам, итгэл нь улам өрнөж, өөрсдийгөө “МУНДАГ” гэдгээ нээж, мэдэрч чаддагийг дурдаж болно.



Төсөлт ажлын бэлтгэл ажил:

1. Хүүхдүүдийг төсөлт ажлаар дамжуулан хийж бүтээхэд сургах.
2. Хийж бүтээх ажлын бэлтгэлийг хүүхдийн бие сэтгэлзүй болон сургалтын орчны талаас сайтар бэлтгэх.
3. Эцэг эхийг хүүхдийн дээрх бэлтгэлийг хангахад туслуулахад тус тус анхаарсан. Бага ангийн хүүхдэд өөрсдөд нь сэтгэл хөдлөл их, адал явдалтай зүйлд багшийн шаардлагагүйгээр идэвхтэй ордог онцлогтой.
 - ✓ Би энэ ажилтай холбогдуулж ангийн хана, тааз зэрэг үзүүлэн зүүж болох бүх л талбай, орон зайг сайтар ашиглаж ангидаа уг сэдэвт ажлын орчин бүрдүүлж бэлтгэсэн.
 - ✓ Хүүхдүүдийн хувцас, баг, маскийг хүртэл өөрсдийнх нь бэлтгэж байгаа сэдэвтэй нь холбогдуулж чимсэн. Энэ байдал хүүхдүүдэд маань их таалагдаж ажилдаа бушуухан орохыг тэсэж ядан хүлээж их л хөгжилтэй байгааг хараад би энэ төсөлт ажил үр дүнтэй болох нь дээ гэж урьдчилан мэдэрч чадсан юм. Энэ талаар доорх зургуудаас харна уу.



Багууд сонгосон сэдвээрээ сонирхолтой туршилт, жүжигчилсэн тоглолт хийлээ

Төсөлт ажлын үндсэн хэсэг:

Төсөлт ажлынхаа дэд сэдвийг:

1. Тэжээмэл амьтад
2. Амьтны ертөнц
3. Халуун рашаан
4. Агаар гэх мэт хүүхдийн танин мэдэхүйд ойр атлаа зайлшгүй мэдэх шаардлагатай сэдвээр сонгосон.

- ✓ Хүүхдүүд холбогдох сэдвээрээ судалгаа хийх, цуглуулгаа ашиглаж шинэ мэдээлэл олж авах, ном зохиол унших, эцэг эх, ах эгч нарынхаа мэдлэгээс хуваалцан өөрөө цааш ургуулан сэтгэж, туршиж, хийж бүтээж үзсэнээр нэлээд мэдлэг, туршлагыг хуримтлуулж чадсан.
- ✓ Хүүхдүүд баг багаараа хийх ажлаа ярилцан зөвшилцөж мэдлэгээ баг дотроо харилцан түгээж, эцэст нь хамтдаа өөрийн багийн гэсэн нэгдсэн ойлголттой болж түүгээрээ бусад багт мэдээлэл хийх хэрэглэгдэхүүн, танилцуулга бэлтгэцгээсэн.



Сурагчид өөрсдийн бэлтгэсэн материалаа ашиглаж бусдадаа сонирхолтой хэлбэрээр танилцуулга хийв

- ✓ Энэ төсөлт ажил нь баялаг материалтай, хүүхдийн мэдлэгээ илэрхийлсэн бүтээл ихтэй болж чадсан. Энэ бүхнийг хүүхдүүд өөрсдийн сэтгэл хөдлөл, сонирхол, хийе бүтээе гэсэн их эрмэлзэл, амрахыг мэдэхгүй уйгагүй хөдөлмөрөөрөө бүтээжээ. Би ангид байгаа тэдгээр бүтээлийг хараад хүүхэд сонирхсон сэдвээрээ юуг л бол юуг бүтээх чадвартай болохыг мэдэрч авсан юм.

“Байгаль” төсөлт ажлын үр дүн хүүхдэд хэрхэн нөлөөлөв?

1. Эх орны байгаль, цаг агаарын тухай хүүхдүүд олон талт интеграц мэдлэгтэй болж, жүжиглэсэн тоглолт хийх, ургамлын хатаамал, бэлэг дурсгалын зүйл, цэцгийн баглаа бэлтгэж үзэсгэлэн гаргах зэрэг байгалийн үзэмжийг илтгэсэн олон төрлийн зүйл хийж бүтээснээс гадна өөрсдийн тэжээдэг амьтдын тухай маш олон сонирхолтой мэдээллийг бодитойгоор үзүүлж тайлбарласан нь сурагчдын ярианы чадварт илт сайнаар нөлөөлсөн юм (Үүнийг энэхүү зөвлөмжийг дагалдан гарч байгаа “Бага, суурь боловсролын түвшинд

хэрэгжүүлэх төсөлт ажил” DVD-ний “Эцсийн тайлан” хэсгээс тодорхой үзээрэй).

2. Төсөлт ажилдаа Portfolio (бүтээлч тэмдэглэл) хийж өөрсдийн юу сурч мэдсэнээ тухай бүр тэмдэглэн, туршлагаа солилцсон нь өөрийн ба хөндлөнгийн үнэлгээг хүүхдүүд өөрсдөө хийж сурах нөхцөл бүрдүүлэв.
3. Ерөөсөө байгалиа хайрлан хамгаалж зүй зохистой ашиглах нь эргээд өөрсдөд нь эерэгээр нөлөөлөөд зогсохгүй эрүүл мэндээ эмгүйгээр эмчлэх таатай орчныг бүрдүүлдэг болохыг мэдэрч, ойлгож чадлаа.

3.1.2. ЭРҮҮЛ МЭНДИЙН СЭДЭВ ГОЛЛОСОН ТӨСӨЛТ АЖИЛ

С.Алтантуяа багшийн сэтгэгдэл

Миний бие “ССДАЗХөгжил” төслийн эхний жилд “Төсөлт ажил” багийн туршигч багшаар ажилласан бөгөөд өөрийн даасан 5д ангидаа 2006 оны 9-р сард албан бус туршилт, 2007 оны 2-3-р сард “Тамхи” сэдвээр албан туршилтыг бага боловсролын түвшинд тус тус удирдан явууллаа.

Манай ангийнхны хувьд хэл ярианы хөгжил сайтай, өөрийн гэсэн бодолтой, үзэл бодлоо хамгаалж чаддаг нэг хэсэг байхад бүрэг ноомой, битүү, санаж бодсоноо чөлөөтэй хэлж чаддаггүй нөгөө нэг хэсэг байлаа.

Багшийн хувьд ч зөвхөн тоо бодуулж сургах, цээжээр алдаагүй бичүүлж сургах, дүрэм цээжлүүлэх, эх зохиолгох мэтчилэн зөвхөн мэдлэгийг толгойд нь чихэгч байсан бөгөөд зарим үед байгаль шинжлэлийн хичээлүүдэд туршилт хийлгэдэггүй зөвхөн өөрөө ярьж өгдөг, эсвэл өөрсдөөр нь уншуулаад яриулдаг байжээ. Харин төсөлт ажил хичээлийг туршин зааснаар багш зөвхөн мэдлэгжүүлэх сургалт явуулдаг байснаас биш хүүхдээ хөгжүүлэх, төлөвшүүлэх сургалт явуулж байгаагүйгээ мэдэрч билээ.

Төслийн албан туршилт явуулахаас өмнө 2006 оны 9-р сард албан бус туршилтыг Багануур дүүргийн 1 бүлэг, манай сургуулийн 4, 5-р ангийн 10 бүлэг дээр явуулсан юм. Бид төсөлт ажил гэдгийг хэрхэн явуулдгийг төдийлөн сайн мэдэхгүй тул Наранцэцэг багшаас ерөнхий ойлголт санаагаа авч, түүний бичсэн “Төсөлт ажил” цуврал-1 гэсэн номыг уншиж судлаад туршилтаа явууллаа. Ер нь энэхүү туршилт маань алдаа оноон дээрээ суралцах чухал туршилт болсон гэж боддог.

Сэдвээ сонгох боллоо. Хүүхдүүд юм юм л судална гэгцгээв. Ингээд “Цаг”, “Сар”, “Ном”, “Хүн”, “Монголын түүх” гэсэн 6 сэдэв дээр сонирхлын бүлгээр хуваагдах болов. Гэтэл “Цаг”-ийг судлах хоёр л хүүхэд байсан тул би өөрөө багийн 3 дахь гишүүн болж орлоо. Дараа нь баг баг дотроо хэрхэн яаж ажиллахаа ярилцацгааав. Танхим дахь дараагийн цагт хүүхэд бүр олсон мэдээллээ танилцуулах болов. Гавьтай зүйл хийж ирсэнгүй ээ. Эндээс багш ихийг эргэцүүлэн бодож хүүхдүүддээ нэлээн сайн зөвлөгөө өгөв. Ийнхүү явсаар эцсийн тайлангийн өдөр ирэв. Хүүхдүүд олон сонирхолтой материал бэлтгэж түүнийгээ янз бүрийн хэлбэрээр танилцуулахаар бэлтгэжээ. Бүх баг бэлтгэсэн зүйлээ коридорын хананд байрлуулжээ. Судалгааны явцад “Ном”-ыг судалсан багийнхан номын

дэлгүүр, хэвлэлийн компаниар (“Экимто” хэвлэлийн газар) хүртэл орж танилцжээ. Ямар ч гэсэн анхны үеэ бодвол нэлээд зүйлийг судалж мэдээд нөхдөдөө ярьж танилцуулснаас гадна жүжигчилсэн тоглолтыг өөрсдөө бэлтгэж тоглож үзүүлэв.

Энэ үед “Төсөлт ажил” багийнхан зөвлөх багшийнхаа хамт ирсэн байлаа. Асанума багш тайланг ихэд олзуурхан бичлэг хийж байсан. Түүгээр ч зогсохгүй ийм их зүйлийг хичээлдээ явах, гэр орондоо туслах зэрэг олон ажлын хажуугаар яаж амжуулдгийг хүртэл гэрт нь очиж танилцаж, бичлэг хийж байсан. Одоо эргээд санахад жинхэнэ туршилтыг бодвол их л тааруухан зохион байгуулсан мэт санагддаг ч багш, сурагчдын хувьд их хол санагдаж байсан төсөлт ажлыг цаашид жинхэнэ утгаар нь явуулахад “том сургууль” болжээ гэж боддог. Сүүлд сонсоход, “Монгол хүүхдүүд ямар мундаг юм бэ? Маш их материал цуглуулж, бусдадаа сонирхолтой хэлбэрээр танилцуулж байна. Төсөлт ажил Монголд жинхэнэ утгаараа хэрэгжинэ гэдэгт итгэж байна. Чадаж байна” гэж Асанума багшийн хэлсэн нь бидэнд их урам хайрласан юм. Мэдээж анхны юманд алдаа оноо их л байсан байж таараа. Гэхдээ л зөвлөгөө өгч ажилласан багш нар маань дандаа л болж байгааг нь дөвийлгөн магтаж цаашид юуг анхаарч ажиллахыг тодорхой зөвлөж байсны хүчинд бид ч хичээнгүйлэн ажиллаж зохих үр дүнд хүрсэн гэж боддог. Хэрвээ бидний болохгүй талыг дандаа шүүмжилж хэлдэг байсан бол, болж байгаа юмаа олж харахгүй ч өнгөрөх байсан юм бил үү. Ямартай ч албан ёсны туршилтын өмнө явуулсан энэ туршилт маань “жинхэнэ туршилт” байлаа.

Дараа нь албан ёсны туршилтын өмнөх сургалтаар маш их зүйлийг мэдэж авсан, түүний дотор Японы төсөлт ажлын бодит жишээтэй кинонуудыг үзэж жинхэнэ сайн ойлгож авлаа. Киног үзэж суухдаа Японы кинон дээрх шиг ийм сайхан орчин нөхцөл манайд байхгүй л дээ гэсэн сэтгэгдэл төрж байсан ч, Монголынхоо нөхцөлд тохируулж боломжоороо хийвэл болохгүй нь юу байх вэ? гэж бодсон юм. Бид хүсэн хүлээсэн туршилтаа ч явуулж чадсан гэж боддог.

Ингээд 2007 оны хоёрдугаар сараас туршилт хичээл маань эхэллээ. Миний хувьд 9-р сарынхаа туршилтаар гаргасан алдаагаа давтаж биш, алдаанаасаа суралцаж, өөрөөр сэтгэж хийх юм шүү л гэж бодож байлаа. Миний гол алдаа бол хэтэрхий олон сэдэв сонгуулж юм юм руу үсчиж, хүчээ тарамдсан учир үлдэц нь бага байсан гэж боддог учир энэ удаа багш, сурагчдын нэрлэсэн сэдвүүдээс сайн багцалж, чиглүүлж байж тодорхой сэдэв дээр тогтох юм шүү л гэсэн бодолтой сэдэв сонголтын цагт орсон юм.

Сэдэв дэвшүүлэх болоход хүүхдүүд бас л олон янзын сэдэв хэлэв. Сэдвүүдийг самбарт багцалж бичсээр 9 сэдэв болгов. Энэ 9 сэдэв дээрээ санал авч дийлэнхийн саналыг авсан нэг сэдвээр төсөлт ажлаа явуулъя гэсэн саналыг би өөрөө хэлсэн юм. Хүүхдүүд ч зөвшөөрч санал хураахад 27 саналаар “Тамхи” гэсэн сэдвийг ангиараа судлахаар болов. Энэхүү ерөнхий сэдвийн дор 6 дэд сэдвийг дэвшүүлж 6 баг болж, тус бүртээ хэрхэн ажиллах төлөвлөгөөгөө боловсруулав.

Энэхүү төсөлт ажлаар хүүхдүүд маш сонин сонин санаа дэвшүүлж, түүнийхээ талаар цуглуулсан материалдаа маш сайн боловсруулалт хийж чадсан гэж боддог. Тухайлбал, тамхи анх ямар оронд үүссэн болох, хүн ямар шалтгаанаар тамхинд ордог, тамхичин хүний 1 сар, 1 жилд татах тамхины үнээр юу авч болох, юу бүтээж болох, ерөөсөө тамхины хайрцагар юу юу хийж болохыг хүртэл хийж үзэцгээсэн

байв. Жишээ нь тамхины хайрцгаар байшин барьж, хогийн сав хийж, санал хүсэлтийн хайрцаг хүртэл хийж ангидаа ажиллуулсан юм. Хүүхдүүдийн бодож сэтгэх, санаа бодлоо илэрхийлэх, хамтарч ажиллах, бие биедээ туслах, шударга шаардлага тавих, бусдыгаа гэсэн сэтгэл нь өдөр ирэх бүр сайжирч тэр хэрээрээ тайлангуудаа маш сайн тавих болсон. Нэгэн удаа миний орж ажилласан “Цаг” багийн 2 гишүүн маань тайландаа бэлтгэх хугацааг надад маш тодорхой хэлсэн ч ажил гарснаас болж хоцорч иртэл, тэд их л ажил хэрэгч байдлаар “Та яагаад цагаа барьсангүй вэ?” гэх нь тэр. Надад хэлэх үг олдсонгүй. Анх удаа сурагчдаасаа ийм үг сонсоод үнэхээр гайхсан шүү. Түүнээс хойш би дахин хоцроогүй. Ийнхүү сурагчид маань хэний ч албадлагагүйгээр зурж, бичиж, уншиж, судалж, тооцоолж, ярьж тайлбарлаж, харилцан ярилцаж гарсан даа. Заримдаа “Эд маань монгол хэлний хичээл дээр ингэж бичиж ярьдаг бил үү? Математикийн хичээл дээр ийм тооцоог гаргаж байлуу? Ийм гоё зурдаг бил үү?” гэж өөрөөсөө асуух үе ч гардаг байлаа. Өөрөөр хэлбэл хүүхэд өөрийн сонирхсон зүйлдээ хэний ч шахалтгүйгээр хичээлээр олж авсан мэдлэгээ жинхэнэ “хэрэглээ” болгон ашиглаж байлаа. Эндээс, аль ч хичээлийг сурагчдынхаа хэрэгцээ, сонирхолд нийцүүлэн заах юм бол тэднийг идэвхжүүлж, хөгжүүлж чадах юм гэсэн санааг олж авсан юм. Миний дээр өгүүлсэн нөгөө дуугүй, ноомой хүүхдүүд маань ярьж, “битүү” санаа бодлоо хэлж чаддаггүй байсан хүүхдүүд маань “Миний бодлоор бол ...” гэж байгаад л ярьдаг боллоо.

Хүүхдүүд гэдэг хөөрхөн улс. “Байгальд учруулах тамхины хор уршиг” сэдвийг авсан багийн гишүүн Батбуян, Төмөр-Очир, Солонго нар сургуулийн эргэн тойронд байсан тамхины ишийг улаан гараараа түүж авчирсан байлаа. Зөвхөн тамхины иш гэхэд л ийм их байгаа юм чинь хэчнээн их хогийг ойр орчимдоо хаядгийг ярьж байлаа. Энэ бол судалгаагаа нотлохын тулд авчирсан баримт боловч өөрсдийнхөө эрүүл мэндийг бодож ядаж л бээлий хийж түүх байсныг анхааруулсан юм.

Өөр нэг багийнхан тамхи зарж буй ТҮЦ-нүүдийн хананд “Насанд хүрээгүй хүүхдэд тамхи зарах хориотой” гэсэн хуудас наасан тухай, зарим худалдагч нар тэрхүү хуудсыг урж, хүүхдүүдийг хөөсөн тухай ярив. Сурагч Төгсбаяр “Миний дэлгүүр”-ийн хананд мөнөөх бичгээ наасанд худалдагч нь урж хаяад түүнийг хөөж гаргажээ. “Тамхи хүний эрүүл мэндэд нөлөөлөх нь” сэдвээр ажилласан багийнхан БЗД-ийн эрүүл мэндийн 10-р төв болон өрхийн эмнэлгүүдээр орж их зүйлийг яриулж авснаас гадна, сурталчилгааны олон материал авчирч хүүхдүүдэд тарааснаас гадна, өөрсдөө асуулга боловсруулж сургуулийнхаа ахлах ангийнхан болон багш нараасаа судалгаа авч дүгнэлтээ танилцуулав.


Төсөлт ажлаар хүүхэд үнэхээр их өөрчлөгддөг юм байна гэдгийг ойлгож авсан. Бас хүүхдүүд өөрсдөө мэдлэгийг бүтээдэг юм байна гэдгийг анзаарсан. Угаасаа түрүүчийн албан бус туршилттай харьцуулахын аргагүй сайн ажиллав.

Туршилт явуулахын өмнө хүүхдүүд маань тоо бодохдоо сайн байснаас биш ерөнхийдөө хэл яриа нь чөлөөтэй биш, хичээл хариулахдаа сул дуутай, өөртөө итгэлтэй биш, буруу хариулахаас эмээдэг, багшийн заасны дагуу л буцааж хариулдаг, бүтээлч биш байлаа. Харин туршилт хичээлийн дараа хүүхдүүд маань хэнээс ч эмээлгүй санаа бодлоо чөлөөтэй илэрхийлдэг, аливаа зүйлийг ухамсар, зорилготойгоор судалдаг, багаар маш сайн хамтарч ажилладаг, ер нь л бүтээлч сэтгэлгээтэй болж төлөвшсөн юм. Энэ анги маань одоо 7-р ангид орсон бөгөөд

хичээл ордог багш нар нь маш сайн бие дааж ажилладаг, арай өөр сэтгэдэг юм гэж ярьдаг юм. Миний хувьд ч өмнө нь төгсгөсөн ангийн хүүхдүүдээс арай илүү чадвар суусан гэж боддог. Энэ бол төсөлт ажлын ач гэж баттай хэлэх байна.

Миний хувьд зөвхөн оногдсон цагт туршилт хичээл заагаад орхисонгүй, “Төсөлт ажил” багийнхны зөвлөснөөр суурь боловсролын түвшинд төсөлт ажил турших багш Эрдэнэчимэгтээ зөвлөгөө өгч ажилласнаас гадна төсөлт ажлыг хэрхэн зохион байгуулах талаар өнгөрсөн нэг жилийн хугацаанд Булан аймгийн төвийн 2-р сургуулийн 47 багш, Гурванбулаг сумын 20 багш, Хэнтий аймгийн Баян-Адарга сумын сургуулийн бага ангийн 15 багшид тус тус сургалт явуулаад байна. Цаашид төсөл дууссаны дараа ч “Төсөлт ажил” багийнхантайгаа хамтран ажиллана гэж бодож байна.

3.1.3. ХҮМҮҮС ХООРОНДЫН ХАРИЛЦАА ГОЛЛОСОН ТӨСӨЛТ АЖИЛ



Зорилго:

- Хүн хүнээ хайрлах нандин сайхан уламжлалыг сэргээх
- Би гэж хэн бэ, ямар удам судартай хүн билээ? гэдгээ судалж мэдэх

Үйл ажиллагаа	Тайлбар зүүлт
1. Сэдэв сонголт • Багш сэдэв сонгуулахын өмнө сурагчдынхаа ерөнхий чадварыг харгалзан 5 баг болгон суулгасан байв. • Дараа нь сурагчдаасаа “Та бүхэн юуг сонирхон судалмаар байна?, Тулгамдаад байгаа ямар асуудал байна? Хэлэлцье” гэсэн асуулт тавив. • “Агаар, ус, хог хаягдал, ногоон төгөл, эх орон, дархан цаазат амьтад” г.м. голдуу байгаль эх дэлхийтэйгээ холбоотой сэдвүүдийг гаргаж иржээ. • Багш, яагаад энэ сэдвийг сонгож авсан учрыг асуув. “Агаар” сэдвийг сонгож авсан баг: Бидэнд хамгийн чухал зүйл бол эрүүл мэнд. Хүн эрүүл байх, ерөөсөө амьд явахад агаар хамгийн чухал гэж үзжээ. “Эх орон” сэдвийг сонгосон баг: Гадаадынхан Монголын сайхан орныг үзэхээр их ирэх боллоо. Бид ч бас гадад уруу их явах боллоо. Гэтэл бид өөрсдөө эх орноо, үзэсгэлэнт сайхан газруудаа хэр мэддэг билээ? гээд нэг сурагч аавтайгаа Хөвсгөл далайд очиж үзэж харснаа нөхдөдөө	Хэдийгээр сонгосон сэдвээсээ хальж яриа өрнөсөн ч нэг сэдвээс нөгөө сэдэв зайлшгүй урган гардгийг харуулж байна. Ангийн багшийн хувьд “Хүн чанар” гэсэн сэдвийг сонгохоор олон хүүхэд санал нэгдсэнд баяртай байв. Тэрээр энэ сэдвийг сонговол наанадаж анги, хамт олноо төлөвшүүлэхэд хэрэг болно хэмээн боджээ. Ингээд багш сурагчиддаа хандаж: – Хэдийгээр дийлэнхийн саналаар энэ сэдвийг сонгосон ч судлах явцдаа

ярихад Хөвсгөл далайг мэдэх хүүхэд бараг байхгүй байжээ. Үүнээс үүдээд эх орноо мэдэж байж гадны оронд жуулчлах хэрэгтэй гэсний үндсэн дээр энэхүү сэдвийг сонгосон байна.

Энэ мэтчилэн гадны орны хүмүүс манай орныг сонирхдог учир, ер нь Монголд гадаадын хүмүүс ажиллаж амьдардаг тухай ярицаж байтал, нэгэн сурагч гадаадын нэгэн иргэнийг хэрцгийгээр хөнөөсөн аймшигт хэргийг тухай ярихад. Хүүхдүүд дор бүрнээ л хүний мөсгүй тэр этгээдийг буруушааж улмаар сүүлийн жилүүдэд хүний мөс муудаж буй тухай олон жишээ баримт ярьцгаав. Бүр сүүлдээ “Бидний амьдралд агаар байгаль орчин чухал уу, хүн чанар чухал уу?” гэдгээр багуудын хооронд ширүүн мэтгэлцээн болов.

Нэлээд мэтгэлцсэний эцэст “Хүн чанар” чухал гэдэг дээр дийлэнх нь санал нэгдэв. Зарим багийнхан санал нэгдсэн хүүхдүүдээ багтаа оруулж ажиллах хүсэлтээ хэлэв. Харин багш:

– Анхнаасаа бүрдсэн багаараа ажиллахыг зөвлөв.

- Сэдэв сонголтон дээр чамгүй маргалдсан тул энэ цаг дээрээ сэдвийн тороо гаргаж амжсангүй. Иймээс багш гэртээ “Хүн чанар” сэдвээр цааш ямар ямар асуудал гарч болох тухай ярилцаад, 4-5 дэд сэдэв сонгоод ирээрэй гэсэн даалгавар өгснөөр хичээл өндөрлөв.

Хэдийгээр хичээл завсарласан ч хүүхдүүд ангид үлдэж бас мэтгэлцсээр байв. Гэхдээ “Ямар хүнийг хүн чанартай гэж хэлэх вэ?” гэдэг дээр өөр өөрийн бодлыг хэлцгээж байв. Мөн багууд ахлагчаа сонгож багтаа нэр өгснөөр гэр гэр рүүгээ явцгаажээ. Энэ үед багш ангидаа юм хийгээд сууж байсан ч тэдний ярианд огт оролцсонгүй. Гэсэн ч “Нээрээ, би өөрөө хүн чанарын хувьд ямар билээ? Эцэг эхчүүдтэйгээ яаж харьцдаг билээ?” гэж бодож суув.

2. Завсрын тайлангууд

- **Багууд дотроо** зөвлөлдөөд дараах байдлаар багтаа нэр өгч, ахлагч нараа сонгожээ. Мөн баг бүр дэд сэдэв дотроо хэн, хэн юу судлахаа төлөвлөжээ.

Багийн нэр	Багийн ахлагч
“Амьдралын арашин”	
М.Цэнгүүн	
“Амьдралын ухаан”	А.Дэмбэрэл
“New stars”	Э.Урангоо
“Оюуны ирээдүй”	Г.Сүхбат
“All leaders”	Э.Ууганбаяр

эх орон, байгаль орчин, агаар усаа ч холбон судалж болно шүү дээ хэмээн сэтгэл гонсгор үлдсэн хүүхдүүдийнхээ сэтгэлийг засч, мэтгэлцээнийг зөв голдирол уруу нь оруулж чиглүүлэв.

Энэ удаа тэдний сонгосон сэдэв маш сонирхолтой байсан, тэгээд ч хүн чанарын тухай асуудал зөвхөн хүүхдүүдэд төдийгүй багшид ч ихийг бодогдуулсан учир хэн хэн нь ангиасаа яаран явсангүй.

Энэ анги нь математикийн гүнзгий анги байсан төдийгүй 1-р ангиасаа англи хэл судалсан тул зарим багууд багийн нэрээ англиар өгсөн байна.

Ерөөсөө энэ ангийн сурагчид сэргэлэн чадварлаг хүүхдүүд учир багшийн оролцоогүйгээр нэлээд зүйлийг хийж ирсэн байв.

Тиймээс ч ажиглагч багш нар хүртэл энэ ангийн сурагчид арай илүү чадвартай болохыг олж харснаа хэлж байлаа.

Сурагчдын сонгосон жижиг сэдвүүдийг анзаарах юм бол үнэхээр л сайн чиглүүлж зангидаж өгөх нь чухал байж дээ гэж бодогдож байлаа.

- Баг тус бүрийн доторх судалгааны сэдвүүд:

Багуудын нэр	Цааш судлах дэд сэдвүүд
Амьдралын араншин	– Ахмад хүнийг яаж хүндлэх вэ? – Ахмад юмуу дүү хүнтэй яаж харьцах вэ? – Угийн бичгийг яаж хөтлөх вэ? – Бусдадаа яаж сайн үлгэр дуурайл үзүүлэх вэ?
Амьдралын ухаан	– Багшийг хүндлэх ёс журам – Өөрийнхөө зан аашийг яаж засах вэ? – Найз нөхөд, ангийн хамт олон, сургуулийн сурагчдын зан харилцаа
New stars	– Баяр ёслолоор хүмүүс хоорондоо ямар байдлаар харьцах вэ? – Ахмад хүмүүстэй хэрхэн харьцах вэ? – Баяр ёслолоор яаж хооллох вэ? – Баяраар мөнгийг хэрхэн зарцуулах вэ? – Бусад орнууд баяраа хэрхэн тэмдэглэдэг вэ?
Оюуны ирээдүй	– Хүний сайхан сэтгэл – Ерөөл, магтаал – Баярын ёс заншил, хувцаслалт – Дуу
All leaders	– Хүний зан ааш юунаас болж эвдэрдэг вэ? – Хүнд хандах хандлага хэдэн янз байж болох вэ? – Муу зан ааш юунаас үүдэлтэй вэ? – Хүнийг ялгаварлах үзэл яаж гардаг вэ?

- Завсрын тайлангаас эхлэн эцэг эхчүүдийн төлөөллийг суулгах болсон нь тэдэнд маш сайхан сэтгэгдэл үлдээж хүүхдэдээ аль болохоор тусалъя гэсэн сэтгэлийг төрүүлээд зогсоогүй хүүхдийн хөгжил төлөвшилд сайн нөлөө үзүүлэх сонирхолтой хичээл байна гээд 100% дэмжиж ажиллах болсон.



Хамгийн идэвхтэй оролцсон ээж

Энэ удаагийн төсөлт ажлын сэдэв нь хүүхдүүдэд ихийг бодогдуудсан бололтой. Ангийн дарга Дэмбэрэл ангийн багшаасаа зөвшөөрөл авч ээлжит бус ангийн хурал хийв. Тэрээр "Ангийн хурлыг өмнө нь би удирдаж явуулдаг байсан бол энэ удаа нээлттэй явуулна" гээд өөрийнхөө сайн, муу талыг тодорхой жишээ баримттайгаар ярьж эхэлснээр бусад сурагчид өөрсдийн сайн муу талыг ний нуугүй ярих. Нэг сонирхолтой зүйл нь хүүхдүүд өөрийнхөө сайн талаа ярихаасаа урьдаар дутагдалтай талаа илүү шударгаар ярьсан байна. Дараа нь муухай зан гаргаж бие биенээ гомдоосон бол уучлал гуйх, уучлах зэргээр их л найрсаг байдалтай хурал үргэлжлэв. Эцэст нь өөрсдөө хэлж чадаагүй дутагдлыг нь бусад хүүхдүүд үнэнээр нь хэлж ярьж өгөв.

Энэ үйл ажиллагаа огт төлөвлөгдөөгүй байсан ч төсөлт ажлын сэдвийн хүрээнд өөрсдийн дутагдалтай талыг засч, сайн талыг дуурайл болгоцгоохоор шийджээ.

- Бусад нөхдөдөө хэн юу танилцуулахаа хүртэл төлөвлөж, ярьж буй хүүхэд бүр аль багийн гишүүн, хэн болохоо хэлж ярихдаа, “Бид, манай багийнхан ярилцаад ингэж тогтлоо” гэж ярьж байсан нь нөхдөд нь төдийгүй сууж байсан багш нарт их таалагдав.



Урьдаас төлөвлөж бэлтгэсэн танилцуулга хүн бүхэнд ойлгомжтой байлаа

Багш нь ч гэсэн өөрт байгаа дутагдалтай талаасаа хэрхэн салах тухай эргэцүүлэн бодож суусан гэдэг. Нөгөөтэйгүүр багш өөрөө сурагчдаасаа илүү их мэдээлэлтэй байж “чиглүүлэгч” болохын тулд байнга суралцаж байдгаараа энэхүү хичээл нь багшийг зайлшгүй хөгжүүлдэг юм байна гэдгийг ойлгожээ.

Ажиглагч багш нарын санал сэтгэгдэл:

- Багш, сурагчдыг ярих явцад гол гол зүйлийг самбарт бичиж явмаар байна. Энэ нь бусдаасаа чухам юу юу сурч авав гэдгээ хүүхэд харж байх, нөгөө талаар багш өөрөө хичээлээ дүгнэхэд хэрэг болно гэж бодож байна.
- Хүүхдийн цуглуулсан материал хавтсандаа л үлдээд байна. Бусад нь нарийвчлан сонирхож үзэх, уншиж танилцах боломжийг хааж байна.
- Багш, сурагчид танилцуулсан материалаа эмхэлж цэгцлэхэд нь сайн чиглүүлж өгмөөр байна.
- Багш судалгааны аргын талаар хэрэглээ талаас нь тайлбарлаж хэлж өгмөөр байна.
- Хэвшүүлж хэрэгжүүлэх санаанууд нэлээд гарч байна. Жижиг гэлтгүй тогтож ярилцах, хэрэгжүүлэх арга замыг олж өгмөөр байна.
- Хүүхдүүд, сууж буй багш нарт хандаж яриад байна. Гол нь нөхдөдөө хандаж яриулах талаар анхаараарай.


- Судалгааны явцад хүүхдүүд чухам хүн чанар гэж юуг хэлдэг болохыг өөрсдийн зөнгөөр биеэр мэдэрч авсан төдийгүй аль болохоор олон хүнд тус хүргэж нинжин сэтгэлээр ханджээ. Тухайлбал, сургууль дотроо хэрэгжүүлэх дотоод журмыг боловсруулж батлахаар болжээ. Энэхүү журмандаа голдуу хүнтэй хүндэтгэлтэй харьцах заалтууд түлхүү оруулж эхэлжээ. Үүнээс үүдээд ахмад хүмүүс, багш нараа хэрхэн хүндэтгэх тухай асуудал урган гарч ирэхэд ерөөсөө “Манай сургуулийн хамгийн ахмад багш нь хэн юм бэ?” гэсэн асуултад хариу олохоор сурвалжилсан байна. Эцэст нь тус сургуулийн математикийн багш Ц.Дамдин хамгийн ахмад багш төдийгүй “Ард түмний гавьяат багш” цолыг хүртээд удаагүй байгааг ч мэджээ. Тэгээд Дамдин багшийнхаа гавьяатыг мялааж яаж тус хүргэх вэ? гэдгээ ярилцаж өөрийнх нь хэрэгцээтэй зүйлийг нь авч, ангидаа урин баяр ёслолын байдалтайгаар гардуулж өгчээ. Дамдин багш, тэдэнд хязгааргүй баярласнаа илэрхийлжээ.
- “Оюуны ирээдүй” багийн цуглуулсан зүйр цэцэн үгийн цуглуулга сурагчдын анхаарлыг ихэд татсан төдийгүй утгыг нь тодорхой жишээн дээр тайлбарлаж байсан нь үгийн утгыг ухааруулаад зогсоогүй өөрсдөө зүйр цэцэн үг зохиох сонирхлыг төрүүлсэн. Ингээд тайландаа зориулж хийсэн сонингийнхоо зургийн тайлбарыг дандаа зүйр үгээр хийсэн байна.



- Явцын дунд “Хүний зан ааш өөрчлөгдөх нь мөнгөтэй холбоотой юу?” гэдэг асуудал дээр бас мэтгэлцэж улмаар бүх юм мөнгөөр хэмжигдэж байгаа өнөө үед баян, ядуугийн ялгаа их болж, үүнийг дагаад ядарсан нэгэндээ тусалдаг монголчуудын бусдын төлөө гэх тусч сайхан сэтгэл үгүй болж, амиа хоохойлж амьдрах болсон дүр зураг нийтлэг ажиглагдаж байгааг шүүн дүгнэж ярилцсан байна.

Хүүхдүүд энэ үйл явдлаас хүнийг бага ч болов баярлуулах санаа нь сайхан сэтгэлээс төрөн гардгийг хамгийн сайн мэдэрчээ.

Энэхүү төсөлт ажлаараа хүүхдүүд, “Хүн чанар нь сайхан сэтгэлээс урган гардаг юм байна” гэдгийг ухаарсан төдийгүй хүнээ алдахгүйн тулд удам судар, үндэс угсаагаа мэдэж авах, бие биедээ элэгсэг хандах, ерөөсөө хайрлах шүтэх юмтай байх ёстойг ойлгож авчээ.



Танхим дахь эхний цаг дээр сэдэв сонголтыг сурагчдын сонирхлыг үндэслэн хийлээ.

Сэдэв сонголтоор сурагчид дөрвөн баг болон хуваагдлаа.

Баг	1-р баг	2-р баг	3-р баг	4-р баг
Сэдэв	Талх	Машин	Цагаан идээ	Мал маллах сайхан

ЭХНИЙ ЦАГ

Хугацаа 2007-02-06

Сэдэв сонголт

Зорилго:

- Багшийн болон өөрсдийн сонгосон сэдвүүдээс хэрэгцээ сонирхолдоо нийцүүлэн сэдвээ зөв сонгох
- Сурагчдыг бие даах болон хамтран ажиллах чадварт сургах
- Судалгаа эрэл хайгуулыг хэрхэн хийх тухай мэдлэг олгох

Зорилт:

- Өөрсдийн сонирхсон зүйлээ судалж мэдэх нөхцөл бүрдүүлэх
- Сонирхсон сэдвийн дагуу асуудалд нухацтай олон талаас нь хандах
- Сонгосон сэдвийн дагуу задаргаа хийж, судлах зүйлээ төлөвлөх
- Сурагчдыг нийгэмшин амьдрах ухаанд сургах

Хичээлийн бүтэц:

- Удиртгал
- Сэдэв сонголт
- Сэдвийн тор үүсгэх
- Дүгнэн ярилцах

Хичээлийн хэлбэр:

Багаар хамтран ажиллах

Сурагчид дөрвөн сэдэв сонгон авч сонирхлоороо багт хуваагдав. Судлах гэж сонгосон сэдвийнхээ талаар өнөөдрийн түвшинд хэр зэрэг мэдлэгтэй

байгаа талаар асууж ярилцав. Багш тулгуур дохионуудыг сурагчдад үзүүлснээр явж, үзэж харж, ярьж хийж туршилт судалгаа явуулна гэсэн ойлголтыг өглөө.

Дараа нь “Өнөөдөр юу хийсэн бэ? Дараагийн удаа юу хийх вэ? Дараагийн удаа хийх зүйлд бэлтгэл болгож юу хийх вэ?” гэдэг талаар ярилцаж төлөвлөлөө.

ХОЁРДУГААР ЦАГ

Хугацаа 2007 -02-13

Хичээлийн сэдэв:

- Сонгосон сэдвийн дагуух судалгаа

Хичээлийн зорилго:

- Сонгосон сэдвийн дагуу хийсэн судалгаа, мэдээллийг өөрсдийн үгээр чөлөөтэй илэрхийлж бусдын хүртээл болгох чадвар
- Багаар болон ганцаарчлан ажиллах чадвартай болгох

Зорилт:

- Өөрсдийн сонирхсон зүйлээ судалж, таньж мэдэх
- Сонирхсон сэдвийн дагуу асуудалд нухацтай олон талаас нь хандах
- Сэдвийн дагуу хийсэн судалгаа баримт, зураг цуглуулах, гарын доорх материал ашиглан загвар хийх

Төлөвлөлт:

- Сонгосон сэдвийн дагуу үүсгэсэн тороо танилцуулах
- Судалгаа шинжилгээний явцыг танилцуулах
- Дараагийн удаа хийх зүйлээ төлөвлөх
- Хичээл төлөвлөлтийн дагуу явагдлаа.

ГУРАВДУГААР ЦАГ

Хугацаа 2007-02-23

Сэдэв:

- Судалгааны явцын тайлан

Хэрэгцээ:

- Хүүхдийг чөлөөтэй бүтээлчээр ажиллах нөхцөлөөр хангах

Зорилго:

- Өөрсдийн сонгосон сэдвийн дагуу хийсэн судалгаа шинжилгээний ажлыг бусдад дамжуулж багаар болон ганцаарчлан ажиллах

Зорилт:

- Сонгосон сэдвээр судалгааны ажил явуулах
- Судалгааны явцад янз бүрийн хүмүүстэй уулзаж сонирхсон сэдвээрээ ярилцлага авах
- Олсон мэдээллээсээ хэрэгтэй зүйлээ сонгож авах
- Судалгааны явцад сурч мэдсэн зүйлээ амьдралд хэрэгжүүлэх

Төлөвлөлт:

- Судалсан зүйлээ товч танилцуулна (өнгөрсөн хичээл дээр)
- Өнөөдөр ямар мэдээ8 мэдээлэл авчирснаа баг болон сурагч нэг бүр танилцуулна.
- Өнөөдрийн хичээл дээр юу хийхээ ярилцаж төлөвлөж хийнэ.
- Сурагч бүрийг тусгай хүснэгтээр асуултын дагуу өөрийн үнэлгээ хийлгэнэ.
- Дараагийн үйл ажиллагаагаа төлөвлөнө.

ДӨРӨВДҮГЭЭР ЦАГ

Хугацаа 2007-02-27

Явцын тайлан:

Сурагчдын үйл ажиллагаа	Багшийн сэтгэгдэл
1. “Цагаан идээ” багийнхан фото танилцуулга хийж ирсэн байв. Үдийн цай хөтөлбөрийн хүрээнд манай сургууль “Дабль-Эрдэнэ” хувьцаат компанийн сүүний цехээс сүү, таргаа авдаг тул тэр цехийн үйл ажиллагаатай танилцаж ирснээ сурагчид уралдан ярьж танилцуулав. Шар сүүгээр ундаа хийж бусдадаа амсуулав. УНДААНЫ ОРЦ 1 литр шар сүү + 1 литр ус + сироп (киви) Ундаа сонгоогүй, цагаан идээ сонгосон сайн хүүхдүүд байна гэж очсон үйлдвэрийн эгч тэднийг магтсан тухай яриу. 2. “Авто машин” баг – фото танилцуулга хийсэн, солонгос машины сэлбэгийн дэлгүүрт очсон. 3. “Талх” баг – сурагч Ариунгэрэлийнд очиж боов хийснээ фото танилцуулгаар хийхийн зэрэгцээгээр авчирч амталгаа явуулав. Мөн сурагч Ганцэцэгийнд очиж 7-8 цагийн турш хамтран талх хэрхэн хийснээ яриу.	Хичээл эхлэхэд багууд бүгд манайх эхлээд, манайх эхлээд гэгцгээж байсан нь судалгааныхаа ажлыг сайн хийж ирсэн нь харагдаж байлаа. – Ундаа үнэхээр амттай болсон байлаа. Нэг сурагчийн ээж дагуулж явж сурагчдад сэлбэгийн дэлгүүр үзүүлж туслав. Сурагчдын ярих чадвар дээшилсэн байлаа.

4. “Мал маллах сайхан” багийн гишүүд бүгд элгэвч хийсэн байлаа. Сурагч Ренцэн-Очир олсоор жижиг ногт зангидаж ирсэн, мөн хазаар авчирсан байлаа. Аварга малчдын талаар гурван малчны товч танилцуулга авчирсан байв. Тэдний малын тоо толгойг диаграммаар дүрслэн үзүүлжээ.	Багуудаас бусад багтаа асуулт тавьж харилцан ярилцаж байлаа.
---	--

ТАВДУГААР ЦАГ

(Энэхүү тайлангийн талаар DVD-ээс тодорхой үзээрэй).

Эцсийн тайлан


Хугацаа 2006-03-06

Сурагчийн үйл ажиллагаа

Сурагчдын үйл ажиллагаа	Багшийн сэтгэгдэл
1. “Талх” – Энэ хугацаанд “Хоргын хүү” нарийн боовны цехийн үйл ажиллагаатай танилцаж нарийн боовыг хэрхэн хийх технологитой танилцжээ. – Гурилан бүтээгдэхүүний төрөл ангилал хийх аргачлалын талаар сурагч бүр зөвлөмж бичсэн. – Ханын сонин гаргасан. Өөрсдийн гараар хийсэн талх боовыг авчирч сугалаат амталгаа явуулав. 2. “Цагаан идээ” – Цагаан идээний ач холбогдлыг харуулсан жүжигчилсэн тоглолт бэлтгэж ирснийг үзүүлэв. – Багуудын хооронд шүлгийн уралдаан явуулсан. – Шар сүүний ундааныхаа төрлийг ихэсгэж амтлуулав. – Сурагч бүр зөвлөмж бичиж ирсэн байна. 3. “Машин” баг – Замын хөдөлгөөний дүрэмтэй холбоотой жүжигчилсэн тоглолт үзүүлэв. – Ханын сонин гаргасан. – Зөвлөмж бичсэн байлаа. 4. “Мал маллах сайхан” баг – Өөрсдийн гараар элгэвч, ногт, чөдөр хийснээ үзүүлэв. – Ханын сонин гаргасан байв. – Баг бүрт нэг сурагч очиж тооно туших аргыг зааж өгөв. Жич: Ангийн орчныг хичээлүүдээр хийсэн бүтээлээр дүүргэж үзэсгэлэн гаргав.	Сурагч бүр дор бүрнээ үүрэг хариуцлагаа ухамсарлаж аливаад хандаж байгаа хандлага нь өөрчлөгдөж байгаа нь ажиглагдаж байлаа. Тайлан үзэсгэлэнгээ олон хэлбэрээр харуулж чадлаа. Хичээлүүд төлөвлөлтийн дагуу явагдаж зорилгоо хангасан гэж үзэж байна.

3.2. СУУРЬ БОЛОВСРОЛЫН ТҮВШИНД ТӨСӨЛТ АЖЛЫГ ТУРШСАН ҮР ДҮН, СУРГАМЖ


3.2.1. НИЙГМИЙН АМЬДРАЛ, ХҮМҮҮСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААТАЙ ХОЛБООТОЙ СЭДЭВ ГОЛЛОСОН ТӨСӨЛТ АЖИЛ



Төсөлт ажлын төлөвлөлт

Цаг	Үе шат	Хугацаа	Үйл явц
1-р цаг	Сэдэв сонгох Багт хуваарилах Сэдвийн тор гаргах Төлөвлөлт хийх	2.20	Сурагчид багийн ахлагчаа сонгоно. Сэдвийн тороо гаргаад багийн ахлагчаа сонгоно. Судалгааны ажлаа хуваарилж авна.
2-р цаг	Явцын тайлан Нэрийн түүхээ ярих Судалгааны багуудын уулзалт ярилцлага	3.07	Гэрийн даалгаварт судалсан өөрсдийн нэрийн түүхээ сурагч бүр бусаддаа ярина. Судалгаагаа нэгтгэнэ. Юу судалж мэдсэнээ бусад багууддаа танилцуулна. Портфолио тэмдэглэл хөтөлнө.
3-р цаг	Явцын тайлан	3.12	Гэрийн даалгаварт бичсэн “Нэр” сэдэвтэй шүлэгнүүдээ бүх сурагчид бусдадаа уншиж танилцуулна. Портфолио тэмдэглэл хөтөлнө.
4-р цаг	Эцсийн тайлан	3.27	Сурагчид тайлангаа тавина. Өөрийгөө дүгнэх карт сурагчдад өгч сурагчдыг өөрсдөөр нь үнэлүүлнэ.

Явц:

Цаг	Зорилго	Үйл явц	Сургамж
Нэгдүгээр цаг	Судлах сэдвээ сонгох, сэдвийн тор байгуулах, сурагчид багаар сууж юу судлахаа шийднэ.	Зөвлөмж 2-т өгсөн боломжит сэдвүүдийг сурагчдыг сэдэлжүүлэх зорилгоор самбарт бичиж өгсний дараа ярилцаад тэднээс өөрийн зохиосон бяцхан судалгааг аван дүнг нэгтгэхэд сурагчдын 92% нэрийн түүхээ мэдэхгүй байв. Иймээс бид санал нэгтгэйгээр “Миний нэрийн түүх” сэдвийг сонгоцгоолоо.  Сэдвийн тороо хананд байрлуулсан байдал Сурагчид саналаараа баг болж хуваагдаад сэдвийн тороо байгуулцаав. Сурагчдад ямар чиглэлээр, яаж судалгаагаа хийх талаар зөвлөгөө өгснөөр энэ хичээл өндөрлөв. Дараагийн уулзалт хүртэл нэрийн түүхээ судахаар болов.	Өөрийгөө таньж мэдэхэд нэрнээсээ эхлэх нь чухал байв. Саналаар баг болж хуваахад зарим нь гологдож үлдэх тал ажиглагдаж байсан учир багш зохицуулах нь зүйтэй болов уу?
Хоёрдугаар цаг	Гэрийн даалгавар шалгаж сурагч бүрийг яриулах, судалгааны явцаа тайлагнах, санаа оноогоо солилцох	Сурагч бүр өөрсдийн нэрийн түүхээ мэдэж ирсэн байлаа. Хүүхэд бүр маш сонирхолтой түүх ярьцгаав. Багууд судалгааныхаа талаар бусдадаа мэдээлэл хийсний дараа бусад багууддаа зөвлөгөө өглөө. Зөвлөгөө өгөх үед хүүхдүүдээс их олон санаа гарч байв. Яриа өрнөөд ирэхээр хүүхдүүдийн идэвх нэмэгдэж байлаа. Энэ үед багшийн дэмжлэг огт хэрэггүй болж ирсэн. Гэрийн даалгаварт: Судалгаагаа үргэлжлүүлэхийн зэрэгцээ “Нэр” гэсэн сэдэв өгч шүлэг зохиох даалгавар өгөв.	Сул ярьдаг сурагчдад үлгэр үзүүлэхийн тулд сайн ярьдаг сурагчдаар эхэлж яриулах хэрэгтэй. Манай сумын хувьд ном дутагдалтай учир мэдээлэл цуглуулахад хүндрэл гарч байгааг хүүхдүүд хэлж байв.

Гуравдугаар цаг	Зохиосон шүлгээ унших, Мэдээллээ анхааралтай сонсох, бие биенээ үнэлэх	Бүх сурагч зохиосон шүлгээ уншлаа. Шүлгээ зохиож ирээгүй зарим нэг хүүхэд найзтайгаа хамтран зохиож, уншив. Энэ хичээлийг сурагчдын санал хураалтаар сонгогдсон “Сурагч-багш” удирдав. Энэ хичээлийн явцад сурагчид бие биенээ маш сайн сонсож байв. Энэ удаа 6, 8, 9-р ангийн сурагчид болон бага, дунд ангийн багш нар бидний хичээлийг үзэж сонирхлоо.	Хүүхэд бүр гарцаагүй оролцох даалгавар өгөхөд муу ярьдаг хүүхэд хүртэл оролцох боломж нээгддэг юм байна.
Дөрөвдүгээр цаг	Эцсийн тайлан тавих, Эцэг эх, багш нартаа өөрсдийгөө нээж илэрхийрэх	Сурагчид баг багаараа сууж өөрсдийн судалсан зүйлээ ханын сонин, хэлбэрээр гаргасан байв. Багуудын бүх гишүүд мэдээлэл хийсэн бөгөөд ярих чадвар зарим сурагчдын хувьд маш сайн нэмэгдсэн байв. Энэ хичээлийг мөн “Сурагч-багш” удирдав. Сурагчдын сонсох чадвар мөн адил нэмэгдсэн байлаа. Ярианы чадвар сайтай зарим сурагчид бусад багуудаас сонирхсон асуултаа асууж байв. <i>Багш, сурагчдын сонирхсон асуултад хариулж байгаа нь</i>	Эцэг эхийг заавал хичээлдээ суулгах хэрэгтэй юм байна гэж үзлээ. Хүүхдүүдийн цуглуулсан мэдээллийг хянах шаардлагатай. Үг үсгийн алдааг мөн хянах хэрэгтэй.

БАГШ ЮУГ АНХААРАХ ВЭ?	СУРАГЧДАД ХЭРХЭН ТУСЛАХ ВЭ?
◆ Хүүхдүүдтэй элгэмсэг дотно, чөлөөтэй харьцах ◆ Ямар ч үед хүүхдүүддээ зав гаргаж байх ◆ Хэрэгцээтэй ном, сонин, сэтгүүлээр туслах ◆ Хүүхдүүдээ байнга ажиглаж тэдний ахиц өөрчлөлтийг тэмдэглэж, дүгнэлт хийх ◆ Хүүхэд бүрийг яриулах даалгавар өгч байх ◆ Хүүхдийг хүндэтгэлтэй сонсох ◆ Энгийн хялбар судалгааны асуулга боловсруулж сурагчдаа тандах ◆ Сурагчдыг мэдээллээ нэгтгэн боловсруулах арга зүйд сургах	◆ Судалгаа хийх арга замыг зааж өгөх ◆ Судалгаа хийх явцад уулзах иргэд, байгууллагын удирдлагатай урьдчилан ярилцаж хүүхдүүдэд дэм болох ◆ Хүүхдүүд бие биенээ хүндэтгэн сонсох, байнга идэвхтэй оролцох орчныг бүрдүүлж өгөх ◆ Хүүхдүүдийн хийж байгаа судалгааны ажлыг эцэг, эхэд ойлгуулах ◆ Хүүхдүүдийн бие биенээ шүүмжлэх, бие биетэйгээ өрсөлдөх гэх мэт асуудлыг хөндлөнгөөс хянаж зөв чиглүүлж өгөх


БАГШИЙН СЭТГЭГДЭЛ

- ❖ Багшийн арга зүйн хувьд маш их өөрчлөлт гарсан төдийгүй хүүхдүүдэд ч мөн адил маш их ахиц гарсан.
- ❖ Хүүхдийн хэл ярианы хөгжил, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх чадварууд хүүхдэд сайн төлөвшүүлж чадвал цаашид сурах арга барилаа сайн эзэмшиж, бусад хичээлд ч мөн адил амжилт гаргах боломж бүрэн байгааг олж харсан.
- ❖ Төсөлт ажил нь багшийн чөлөөт сэтгэлгээг нээдэг төдийгүй хүүхдүүдэд ч мөн адил чөлөөтэй сэтгэж бодох боломжийг олгож өгдөг юм байна.
- ❖ Багш өөрөө хичээлээ удирдаж явуулах гэж хэт эрмэлзэлгүй, хүүхдээр хичээлээ удирдуулбал хүүхдүүдэд их сонирхолтой байх ба бас тухайн хичээлийн сэдэвтэй холбогдуулан зочин урьж оролцуулж ч болох юм.
- ❖ Төсөлт ажлын явцад багш хүүхдүүдийн сонсох, ярих, бие биенээ хүндэлж харьцах тал дээр голлон анхаарч төлөвшүүлэх, мөн хүмүүжүүлэх шаардлага өөрийн эрхгүй урган гарч ирэх учир энэ асуудалд нухацтай хандах хэрэгтэй. Өөрөөр хэлбэл төсөлт ажил нь сурагчдыг нийгэмшүүлэхэд хамгийн сайнаар нөлөөлдгийг мэдэрлээ.
- ❖ Ерөөс төсөлт ажлын явцад хүүхэд төдийгүй багш өөрөө ч хөгжиж байдаг. Тухайлбал, багш тухайн сэдэвтэй холбоотой маш их зүйлийг уншиж судлах хэрэгцээ шаардлага гардаг.
- ❖ Багш зөвхөн хүүхдүүдийн илтгэлийг сонсоод өнгөрөх биш, өөрөө судалгаа, асуулга гаргаж сэдэвтэйгээ холбогдуулан хүүхдээ давхар судлах нь өгөөжтэй санагдав. Дараах асуулгаар судалгаа авч дүгнэлт хийсэн маань өгөөжтэй болсон.

АСУУЛГА

1. Хүнд яагаад нэр өгдөг юм бол?
.....
2. Чиний нэрийг хэн өгсөн бэ?
.....
3. Чи нэрийнхээ утгыг мэдэх үү?
а) Тийм б) Үгүй в) Мэдэхгүй
4. Чамд нэр чинь таалагддаг уу?
.....
5. Чамай хүмүүс ямар нэрээр чинь дууддаг вэ?
а) Бүтэн б) Хагас в) Хоч
6. Чи нэрээ өөрөө сонгож болох байсан бол ямар нэрийг сонгох вэ?
.....

❖ Эхний хичээлүүдэд эдгээр зөвлөмжүүдийг сайн анхаарч ажилдаа тусгаж чадвал дараа дараагийн хичээлүүд аяндаа таны гарт орсон байх болно.



Хичээлийн хэлбэр:

Асуудлыг судлаад тайлагнах

Хичээлийн зорилго:

Сурагчид өөрийнхөө тухай эргэцүүлэн бодох, өөрийгөө нээх, бодол санаагаа бусдад чөлөөтэй илэрхийлэх, бусдыг сонсох, сонирхол, хүсэл мөрөөдлөө олж авах, өөрийн сул ба давуу талыг олж харан зорилготой амьдрахад чиглэсэн.

Улаанбаатар хотын Сүхбаатар дүүргийн 45-р сургуулийн 7^б ангид “Би хэн бэ?” сэдвээр нийт дөрвөн цагийн хичээлийг 33 сурагчийн дунд амжилттай зохион байгуулж явууллаа. Сэдэв сонголтыг эхний цагийн хичээл дээр сурагчдын сонирхлыг үндэслэн хийж дөрвөн баг бүрдүүлээ.

Баг:	1-р баг	2-р баг	3-р баг	4-р баг
Дэд сэдэв:	“Зорилго”	“Эрүүл мэнд”	“Харилцаа”	“Мэргэжил”

Жич: Сурагчид өөрсдийн сонирхлын дагуу хуваагдсан учраас багийн хүүхдийн тоо харилцан адилгүй байлаа.

ХИЧЭЭЛ №1

Зорилго:

- Сурагчдын санирхолд нийцсэн сэдэв сонголт хийх
- Сонирхлын бүлгээр багаа бүрдүүлэх
- Сэдвийн талаар ойлголт өгөх
- Судалгаа эрэл хайгуулыг хэрхэн хийх тухай мэдлэг олгох.

Багшийн үйл ажиллагаа:

- Агуулга сэдвийн хүрээг танилцуулах
- Сэдвийн тор үүсгэхэд сурагчдад дэмжлэг үзүүлэх
- Сэдвээсээ халихгүй байхад дэмжлэг үзүүлж, чиглүүлж өгөх.

Энэ цагийн хичээлээр сурагчид багт хуваагдсанаас гадна багш сэдвийн дагуу зохих ойлголтыг сурагчдад өгөхийг хичээсэн боловч цаг хангалтгүй байсны улмаас бүрэн гүйцэд ойлголтыг хараахан өгч амжсангүй. Сурагчид өөрсдийн сонирхсон сэдэв, мөн өөрсдийн хамтарч ажиллах сурагчидтайгаа баг бүрдүүлсэн болно. Гэсэн хэдий ч сурагчид өөрсдийн судлах, хийх гэсэн ажлуудынхаа ерөнхий ойлголтыг авч чадсан. Хамгийн гол нь сэдэв сонголт дээр багш сайн дөхүүлж, чиглүүлж өгөх хэрэгтэй юм байна гэж багшийн зүгээс үзэж байна. Сурагчдад дараагийн хичээлд юуг судлаж мэдсэн байх ёстойг тайлбарлан зөвлөгөө өглөө.

Энэ хичээл дээр сурагчид яаж багаар ажиллах, хамтарч судлах зүйлээ хийх зэрэг ойлголтуудыг авч чадлаа. Дараагийн хичээл дээр сурагчид хэрхэн яаж бэлтгэх талаар өөр хоорондоо ярилцан хуваарилан авлаа.

ХИЧЭЭЛ №2

Зорилго:

- Бусдын өмнө өөрсдийн бодол санаагаа илэрхийлж сурах
- Бусдыг сонсож өөрийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлж чадах
- Бусдад шүүмжлэлтэй хандан өөрийн дутагдалд дүгнэлт хийж сурах

Энэ цагийн хичээлээр сурагчид өөрсдийн олж судалж, мэдэж ирсэн зүйлээ бусдадаа ярьж тайлбарлан өөр хоорондоо мэдээллээ солилцов. Мэдээлэл солилцох явцад зарим сурагчдын дунд багаар хамтарч ажиллах чадвар дутмаг байдлаас хамааран бусдадаа өөрийн судалсан сэдвээр чөлөөтэй ярих чадвар дутмаг, мөн өөр хоорондоо, ялангуяа баг дотроо үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх,

бусдынхаа олж ирсэн сэдвийн талаар мэдлэг дутмаг байгаа нь өөр хоорондоо мэдээллээ солилцоогүйгээс болсон гэж багшийн зүгээс дүгнэсэн болно.

Ийм учраас энэ цагийн хичээл маань зорилгоо бүрэн гүйцэд хангаж чадсангүй гэж үзлээ. Иймд багшийн зүгээс дараагийн хичээлд хэрхэн яаж хамтарч ажиллах, бусадтайгаа мэдээллээ солилцон баг бүр нэг шийдэлд хэрхэн яаж хүрэх талаар зөвлөгөө өгч ярилцлаа. Зарим сурагч өөрсдийн мэдээллийг янз бүрийн арга хэлбэрээр бусдадаа тайлбарлан ярьсан нь сурагчдын сонирхлыг татсан мэдээлэл болж чадлаа.

Ялангуяа “Эрүүл мэндийн баг”-ийн мэдээлэл бусад сурагчдын сонирхлыг татаж чадсанаас гадна эрүүл мэндээ хэрхэн яаж хамгаалах талаарх ойлголт, мөн шинэ соргог санаануудыг бусдад ойлгуулж чадсан гэж үзэж байна. Учир нь багш хүүхэд бүрийг яриулахыг хичээж байв.

ХИЧЭЭЛ №3

Зорилго:

- Бусдын сонирхсон асуудалд хариулт өгч сурах
- Багаар хамтарч ажиллах
- Мэдээллээ янз бүрийн арга хэлбэрээр өгч сурах.

Энэ цагийн хичээл дээр сурагчид бусдын асуусан асуултуудад хариулт, тайлбар, зөвлөгөө өгөх зэргээр харилцан санаа бодлоо солилцох хэлбэрээр явагдлаа.

Сурагчид сонирхсон асуултандаа бүрэн гүйцэд хариултуудыг авахыг хүсэж байгаа нь өмнөх хичээлүүдэд гарсан алдаа дутагдлаа дахин давтахгүйг хичээж байсан нь сурагчид маань багаар ажиллаж сурч байгаа нь багшид ажиглагдаж байлаа.

Энэ хичээл дээр сурагчид өөр хоорондоо харилцан ярилцаж бэлдэж ирсэн нь асуулт, хариулт өгч, авч байгаа байдлаас ажиглагдаж байлаа. Сурагчид өөрсдийн зорилго, зорилтоо ухамсарласан нь хариулж байгаа хариултуудаас илэрхий харагдаж байлаа.

Мөн сурагчдын олж ирсэн мэдээллүүд нь бусдынхаа сонирхлыг татаж чадаж байсан нь тэдний хоорондоо мэтгэлцэж маргалдаж байснаас илүү их зүйлийг хамтарч хийж болдог гэсэн ойлголт авсныг харуулж байгаа бөгөөд энэ нь хичээлийн маань үр дүн байлаа.

Сурагчид илүү их зүйлийг мэдэхийг хүсэж, өөр хоорондоо харилцан ярилцаж бусдаасаа илүү их зөвлөгөө, мэдээллүүдийг авч чаддаг гэдгийг хамтран ажилласны үр дүн гэж ойлгож авсныг багш миний зүгээс сайшааж байлаа.

Ер нь сурагчдын дунд идэвх санаачилга нь илүү өсөн нэмэгдэж байгаа нь, сурагчид маань энэ хичээлийн зорилго, зорилт гэдгийг багшийн зөвлөгөөнөөс ойлгож авсан байна гэдгийг харуулж байна.

ХИЧЭЭЛ №4**Зорилго:**

- Мэдээллээ олон арга хэлбэрээр илэрхийлэх
- Мэдээллийг олж болох олон арга замуудтай танилцах
- Өөрсдийн ажилд үнэлэлт дүгнэлт өгч сурах.


Багууд өөрсдийн судалсан сэдвийн талаарх мэдээллийг асуудал дэвшүүлэх арга, маргаан мэтгэлцээний арга, үзүүлэн зурагт хуудас ашиглан тайлбарлах арга, судалгаа шинжилгээний арга, дүрд тоглох арга, бусдыг сонсож хариулт авах зэрэг арга хэлбэрүүдийг ашиглан дүгнэлт хийж, өөрсдийн олж судалсан судалгааныхаа үр дүнг хамгаалж чадсан гэж үзэж байна.

Энэ хичээл дээр сурагчид маань өмнөх хичээлүүдийг бодвол арай илүү бодол санаагаа илэрхийлж, өөрсдийн дүн шинжилгээг чөлөөтэй илэрхийлж сурсан нь харагдаж байна. Баг тус бүр өөрсдийн гэсэн арга хэлбэрээр мэдээлэл өгч, дүгнэлт хийж сурсан гэж бодож байна.

ДҮГНЭЛТ

Энэ дөрвөн цагийн хичээлээр сурагчдад ойлгуулбал зохих мэдлэг, хүмүүжил, арга барил болон судалгаа шинжилгээ хэрхэн яаж хийх, олж авсан мэдлэгээ бусдад хэрхэн яаж чөлөөтэй илэрхийлэх, бусдын үгийг сонсох, бусдыг хүндлэх, багаар хамтарч ажиллах, бусадтайгаа хэрхэн яаж харилцан санаа сэтгэлээ ойлголцох, өөрийн сонирхсон асуултаа хэрхэн илэрхийлэх, түүндээ яаж хариулт авах зэрэг хэлбэрүүдийг ашиглан чөлөөтэй бодол санаагаа илэрхийлэх анхны алхамуудыг судалж сурсан гэж дүгнэж байна.

- ▶ Ер нь төсөлт ажлын цагийн хичээл болон бусад хичээл дээр сурагчдыг багаар ажиллуулбал илүү үр дүнтэй юм шиг санагдлаа.
- ▶ Энэ хичээлийн дөрвөн цагийг заахад сурагчид хичээлээс гадуур олон цагийн судалгаа шинжилгээ, уулзалт, ярилцлага, маргаан мэтгэлцээнүүдийг хийж хамтарч ажиллаж байлаа.
- ▶ Энэ бүхэнд багш байнгын зөвлөгөө өгөн хамтран тусалж дэмжиж байлаа. Гэсэн хэдий ч сурагчдад маань энэ ажлыг хийх явцад нь хүндрэл бэрхшээл тулгарч байв. Үүний үр дүнд сурагчид маань хамтарч ажиллахын үр өгөөжийг мэдэж чадсан нь сайшаалтай байлаа.



Хичээлийн зорилго:

1. Өөрийгөө нээж, таньж мэдсэнээр өөрийгөө хөгжүүлэх, үнэ цэнээ мэдрэх, байр сууриа тодорхойлох, бүтээлч идэвхтэй иргэн болж төлөвших
2. Өөртөө тулгамдаж буй асуудлыг олж харах, бие даан шийдвэрлэх
3. Аливааг эргэцүүлэн бодох, нийгмийн амьдрал, хүмүүсийн үйл ажиллагааг судлах, суралцах
4. Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлж сурах, бусдыг хүлээцтэй сонсох, мэддэг зүйлээ бусдад зааж сургах, бусдаас суралцах, багаар хамтран ажиллах

Нэгдүгээр цаг. СЭДЭВ СОНГОЛТ

Үйл явц	Ажиглалт, тэмдэглэл
✓ Сурагчид өөрийгөө сайн таньж мэдэхийн тулд багшийн өгсөн дараах асуултад хариулна. 1. Чи өөрийгөө зан чанарыг ямар дүрсээр илэрхийлэх вэ? 2. Чи өөрийгөө сэтгэл хөдлөлийг ямар өнгөөр илэрхийлэх вэ? 3. Чи өөрийнхөө зан төрхийг ямар амьтантай зүйрлэх вэ? 4. “Чи өөрийгөө сайн магтаад өг” гэвэл юу гэж магтах вэ? 5. Чи өөрийнхөө сул талыг нэрлэнэ үү? ✓ Энэхүү бичил судалгаа нь сурагчдын төрх байдал, зан ааш, харилцаа, биеэ авч яваа байдал, хэл ярианы хөгжлийг тодорхой хэмжээгээр мэдэх зорилготой байлаа. ✓ Багш сурагчдад өөрийгөө сайн таньж мэдэхийн ач холбогдлыг суут хүмүүс, эрдэмтэн мэргэдийн хэлсэн онч мэргэн үгээс иш татаж ярилцав. Тухайлбал, “Ямагт өөрийнхөө хүрч чадахгүй зүйлд дурлаж амьдрах хэрэгтэй. Өөдөө тэмүүлдгийнхээ хүчинд хүн өндөр болдог” (А.М.Горький), “Хүн өөрийгөө хэрхэн үнэлж цэгнэнэ, түүний үнэ яг тийм байдаг” (Франсуа Рабле), “Өөрийгөө хэрхэн таних вэ? Үйл ажлаараа таньж болно. Оногдсон үүргээ биелүүлэхийг чармай. Чи өөрийнхөө үнэ цэнийг мэдрэх болно” (Гёте) г.м.	Багш хүүхэд бүрээр яриулахыг эрмэлзсэн. Сурагчид багшийн тавьсан асуултад товч, ганц нэг үгээр хариулж байсан нь, тэд өөрсдийнхөө тухай өмнө нь нэг ч удаа эргэцүүлэн бодож байгаагүйг илтгэнэ. Хүүхдүүд сэтгэгдэл маш өндөр, сонирхон хүлээж авсан.

✓ Багш сурагчдад дээрх асуултыг сайн ухаарах, мөн өөрийнхөө талаар өөр юу юу мэдсэн тухайгаа ярихыг зөвлөв. ✓ Сэдвийн тороо үүсгэх явцад олон чухал асуудал хөндөгдөн гарч ирэв. ✓ Удаан ярьж зөвлөлдсөний үр дүнд дараах дэд сэдвүүдээр судалгаа хийхээр тогтлоо. ✓ Судлах агуулгадаа тохируулж, “Уламжлал”, “Шинэ”, “Мэргэдийн орон”, “Жиргээ” гэсэн нэртэй 4 багт хуваагдав. “Уламжлал” баг – монголчууд үр хүүхдэдээ нэр хэрхэн өгдөг уламжлалыг судлах, “Шинэ” баг – монгол нэрийн утга учрыг мэдэх, “Мэргэдийн орон” баг – эрдэмтэн мэргэд, суут хүмүүсийн хэлсэн онч мэргэн үгсийг цуглуулж, нэрээ хайрлах тухай хэрхэн сургасныг тайлбарлах, “Жиргээ” баг – нэрээ өндөрт өргөж яваа хүмүүсийн амьдрал замналыг судлахаар болов. ✓ Судалгааны ажлын төлөвлөлт хийж, ажлаа хуваарилж авав. Үүнд: Хэн хэн юу хийх, хэн ахалж хариуцах, ямар хугацаанд гүйцэтгэх г.м. ✓ Мөн мэдээллийн эх сурвалжууд юу юу байж болох, хаанаас олж авах тухайгаа хүртэл ярилцаж, нэг хүний идэвх чармайлтаас багийн амжилт шалтгаална гэдгийг ярилцаж тохиролцов. ✓ Гэрийн даалгаварт: 1. Судлах 5 асуудлыг сайн томъёолох, материал цуглуулах 2. Өөрийн нэрийн тухай судалж ирэх	Сурагчид өөрсдийнхөө зорилгыг тодорхойлов. Сэдвээс халихгүй байх, чухал бус асуудалд цаг алдахгүй байхыг багш анхааруулж, чиглүүлж байв.
---	--

Хоёрдугаар цаг “НЭРЭЭ ХАЙРЛАХЫН УЧИР”

Хичээлийн зорилго:

Хүн, нэрээ хайрлахын учир утгыг ойлгуулах, нэрээ өндөрт өргөж явахыг эрмэлзэх

Хичээлийн үйл явц:

- Долоо хоногийн хугацаанд хийсэн ажлаараа багууд тайлан тавив.
- Сурагч бүр өөрийн нэрийн түүхийн тухай эсээ бичиж ирснээ баг дотроо уншиж багаасаа хамгийн сайн бичсэн 2 эсээг шалгаруулж, нийт сурагчдад ярьж өгсөн. Эндээс шилдэг 3 эсээг шалгаруулахад сурагч Э.Намуунтөгс, А.Баярсайхан, Б.Амартүвшин нар тодров.

Бусад сурагчийн бичсэн эсээг ангидаа байрлуулж, уншиж танилцсанаар бие биеэсээ суралцан, санаа авч, нэрийн түүхээ илүү сайн бичихээр болов.



*Тайлангийн явцад багш хичээлийн судалгаа хийн,
тэмдэглэл хөтөлж байгаа нь*

Багууд маш сонирхолтой мэдээллийг нөхдөдөө танилцуулав.

Нэгдүгээр баг: НЭР ХАЙРЛАХ МОНГОЛ ЁСОН

- Нэр залах, шинэ мэндэлсэн хүүхдэд нэр өгөх зан үйл гүн гүнзгий утга учиртай. Нэр өгөх өдөр цагаа товлож, бэлгэ дэмбэрэл дүүрэн нэр хайрладаг. Дуудах нэр нь хүний нэг насны амны хишиг буян заяанд нөлөөлдөг гэж үздэг. Нэр залах эцэг хүн төв сайхан хувцсаа өмсөж, алд цэнхэр хадаг бэлдэн нэр хайрлах өндөр настан, ихэс дээдэс лам хуврагт өргөн барьж хүндэтгэл үзүүлэн ёсолж, шинэ мэндэлсэн хүүхдэдээ нэр залдаг. Нэр хайрлах өдрийн хамгийн сайн гариг нь эрэгтэй хүүхдэд Лхагва, эмэгтэй хүүхдэд Баасан гараг ээлтэй. Нийт олноороо заншсан сайн гарагууд нь Даваа, Лхагва, Пүрэв, Баасан юм. Тэгвэл хишиг буян заяанд сайн ажээ.
- Нэр өгөхдөө эрэгтэй хүүхдийн баруун чихэнд, эмэгтэй хүүхдийн зүүн чихэнд нэрийг нь 3 удаа шивгэнэж хэлдэг.
- Өгөх нэрүүдийг цаасан дээр бичиж хуйлан, аяганд хийгээд дээрээс нь будаа хийж дүүргээд зөөлөн сэгсрэхэд хамгийн дээр гарч ирсэн нэрийг өгч ч болдог байна.
- Үр хүүхэд нь тогтдоггүй айлд шинээр хүүхэд мэндлэхэд эсвэл нэр нь хүндэдсэн хүүхдийн нэрийг нь өөрчилж амьтны нэр өгдөг байна.

Хоёрдугаар баг: НЭРИЙН УЧИР

Монголчууд ихэвчлэн төвд нэр өгдөг байсан нь харь хэлийг шүтэж биширсэндээ бус, учир шалтгааны үүднээс амны бэлгэ дэмбэрэл гүн гүнзгий утга учир оршдог байжээ. Энэ баг 50 гаруй төвд нэрийн тайлбарыг судалж ирсэн ба энд ангийнхаа төвд нэртэй сурагчдын нэрийн утгын тайлбарыг оруулжээ.

Балбар	–	Цогбадрах
Бүжинлхам	–	Хүү төрүүлэх охин тэнгэр
Хажидмаа	–	Огторгуйд зорчигч эх
Цоодол	–	Далайг гэтлэгч
Сэнгээ	–	Арзгар арслан
Тавхай	–	Мэргэн арга
Юндэн	–	Хас тамга

Сурагчид өөрсдийн нэрийн утгын бэлгэдлийг мэдсэн нь маш их сонирхолтой байсан ба аав ээж, ах дүү, эмээ өвөөгийнхөө нэрийг ч сонирхон мэдэж авсан. Хүүхдүүд нэрээрээ бахархаж, өндөрт өргөж явахаа ч хэлж байлаа. Нэр цээрлэх ёс байна. Үүнд:

- Хүний нэрийг дутуу буюу товчилж дуудаж болдоггүй.
- Харанхуй шөнөөр хүний нэрийг бүтнээр нь дууддаггүй зэргийг сурагчид мэдэж авснаар нэрээ хайрлаж, бие биеэ бүтэн нэрээр нь дууддаг болсон нь энэ багийн ажлын үр дүн байсан.

Гуравдугаар баг: МЭРГЭДИЙН ОРОН

Хүний нэртэй холбоотой зүйр цэцэн үгс цуглуулж, бусад багийн сурагчдад тайлбарлаж өгсөн нь аливаа юмны утга учир, мөн чанарыг ойлгуулахад хувь нэмрээ өгсөн. Тухайлбал,

Дуудах нэрийг эцэг эх нь өгдөг
Дуурсах нэрийг өөрөө олдог

Сайн хүн нэрээ
Тогос шувуу өдөө

Нэр хугарахаар
Яс хугар

Сайн нэрийг хүсэвч олдохгүй
Муу нэрийг хусавч арилахгүй

Аавын хүү алдраараа гайхуулна
Ээжийн хүү эрдмээрээ гайхуулна

Мөн ардын уранзохиолч Ш.Сүрэнжавын “Нэр” шүлгийг багаараа уран тод уншиж сонирхуулсан. Энэ шүлгийг монгол хэл, уран зохиолын багш нар, ном, сурах бичиг, аймгийн номын сан зэргээс эрж хайж, асууж сураглаж байж олсон нь сурагчид их идэвх чармайлт гаргасны үр дүн юм. Шүлгийг уншихад багийн бүх гишүүд, тэр

дундаа дуу цөөтэй, бараг дуугардаггүй сурагчид идэвхтэй оролцсон нь хүүхэд бүр өөрийгөө нээж, таньж мэдэхэд тус дөхөм болсноороо энэ багийн ажил их сонирхолтой байв.

Дөрөвдүгээр баг: НЭРЭЭ ХАЙРЛАХЫН УЧИР

Тус багийнхан сурагчдаар “НЭР” сэдвийн дор богино хугацаанд шүлэг зохиолгов.

- Сурагчид ямар их авьяас чадвартай, сонирхолтой зүйлдээ ямар их идэвхтэй оролцдогийг харуулж чадсан.
- “Нэр хугарахаар яс хугар”, “Дуурсах алдрыг өөрөө олдог” сэдвүүдээр жүжигчилсэн тоглолт хийлгэхэд чин сэтгэлээсээ дүрдээ орж тоглосон ба цэцэн үг ямар агуу утга илэрхийлдгийг ч мэдрүүлэв.
- Багуудын тайлан хамгаалалт маш сонирхолтой, хөгжилтэй байлаа. Сурагчид их бүтээлч эрэл хайлт хийсэн, их зүйл сурч мэдсэн, өргөн хүрээтэй мэдээлэл цуглуулсан зэрэг нь сурагчдын ярьж, хэлж, бичиж, тоглож байгаагаас тодорхой харагдаж байв.



Хичээлийн бус цагаар ангидаа цуглан, шинэ мэдээлэлд боловсруулалт хийж, өөр өөрсдийн хавтсандаа хийж байгаа нь

- Сурагчдын идэвх оролцоо хичээлээс хичээлд улам өсч байгаа нь тэдний хийсэн бүтээл зохиосон шүлэг, бичсэн эсээ, дуулсан дуу зэргээс мэдрэгдэж байлаа. Завсрын тайлан хэдийгээр хоёрхон цаг үргэлжилсэн ч ажиглагч

багш нар сэтгэл хангалуун байв. Гэрийн далгаварт угийн бичгээ бичиж сурцгаах, түүний ач холбогдлыг судалж мэдэх даалгавар өглөө.

Гурав, дөрөвдүгээр цаг. “УГИЙН БИЧИГ ХӨТЛӨХИЙН АЧ ТУСЫГ МЭДЭЖ АВЦГААЯ”

Хичээлийн зорилго:

Гэр бүлийн соёл, уламжлалыг дээдлэн хөгжүүлэх, удам угсаагаа мэдүүлэх, удмын сангаа цэвэр ариун байлгах, монголын хүн амын тогтвортой өсөлтийн хангахын чухлыг ойлгуулах

Хичээлийн хэлбэр:

Асуудлыг судлаад тайлагнах төсөлт ажил

Дэвшүүлсэн асуудал:

Угийн бичгийг хөтөлснөөр удамшлын өвчин эмгэг, согог, оюуны хомсдолтой хүүхэд төрөхөөс урьдчилан сэргийлэх, цус ойртолтоос хамгаалж чаддаг болох нь үнэн үү?

Сэдэл:

Сүүлийн үед удмын гаралтай өвчин эмгэг ихэссээр байгаа нь сэтгэл эмзэглүүлэх болсон. Энэ нь угийн бичгийг хөтлөхийн мөн чанар, ач холбогдлыг мэддэггүйтэй холбоотой. Иймээс хүмүүст ойлгуулах, энэ өвчнөөс урьдчилан сэргийлэх ач холбогдлыг мэдүүлэхийн тулд энэ сэдвийг судаллаа.

Төсөөлөл:

Монголчууд эрт дээр үеэс угийн бичиг хөтөлж байсан уламжлалтай. Бидний цөөхөн монголчууд харийнханд уусалгүй өнөөг хүртэл үндэс угсаагаа хадгалсаар ирсэн ард түмэн юм. Үүнээс үүдээд тэр сайхан уламжлалыг сэргээж, бүлийн угийн бичигтэй болох, хөтөлж сурах

Судалгаа:

- Угийн бичгийг хэрхэн хөтөлдөг аргаас суралцах,
- Угийн бичгийн хэдэн хэлбэр төрөл байдгийг мэдэх,
- Угийн бичгийг бичиж, хадгалан үлдээж өвлүүлдэг байсан уламжлалыг судлах,
- Угийн бичгийн зөв зохистой хэрэглээ, ач тусыг тодорхойлох

Судалгааны арга:

- Ном, сурах бичиг, сонин сэтгүүл гэх мэт бичгээр илэрхийлсэн материалын судалгаа ба сонссон зүйлээсээ мэдээлэл цуглуулах, Үүнд: Түүхч академич И.Цоодол гуайтай уулзалт хийх,
- Айл өрх бүр угийн бичиг хөтлөх тухай эрхзүйн орчин,
- Монголын уламжлалт зан заншил, товч тайлбар толь,
- Туршилт

Сурагчид угийн бичгийн хэлбэрүүдийг судалж, өөрийн сонирхсон хэлбэрээр гэр бүлийнхээ гурван үеийн угийн бичиг хөтлөхөөр болов.

Тавдугаар цаг. “БИ УГИЙН БИЧГЭЭ ХӨТӨЛЖ СУРЛАА”

Сурагчид өөрсдийн сонгосон хэлбэрээр гэр бүлийнхээ гурван үеийн түүхийг хамарсан угийн бичиг зохиолоо. Энэ нь тэдэнд тийм хялбар байгаагүй. Учир нь айл бүр угийн бичиг хөтөлдөггүй нь хүндрэлтэй байсан ч И.Цоодол гуайн зааж өгсний дагуу эцэг эх, эмээ өвөөтэйгөө хамтран, угийн бичгээ зохион, маш сонирхолтой хийж, хамгаалсан юм. Тухайлбал,

- Хонгорзул – фото зургийн сан хэлбэрээр,
- Намуунтөгс – эмээгээрээ заалган, торгон дээр шаглаж оёсон байдлаар,
- Баярсайхан – уламжлалт арга болох арьсан дээр,
- Энхмаа – модны үндэс, мөчрөөр дүрсэлсэн зэрэг нь илүү сонирхолтой болж, багш сурагчдын анхаарлыг татсан юм.



Танхим дахь явцын тайланг дугуйрч суух хэлбэрээр зохион байгууллаа


ДҮГНЭЛТ

Энэ хичээлээр сурагчид аав ээж, эмээ өвөөгийнхөө угсаа гарал, ах дүү төрөл саднаа мэдэж авсан нь тэднээрээ бахархах, гэр бүлийн түүхээ судалж, гэр бүлээрээ бахархах, хүндэтгэх, гэр бүлийн үнэт зүйлсээс суралцах сайхан боломж олдов. Тухайлбал, сурагч Хонгорзулын 4 дэх үе болох өндөр өвөг нь партизан байсныг мэдэж авсан бол сурагч Ангирмаагийн өвөө нь хятад гаралтай, эмээ нь орос гаралтай гэх зэргээр сонин зүйл их байв.

Сурагчдын хийсэн угийн бичиг дотор тусгай дүрс тэмдгээр тэмдэглэсэн болон модоор зурсан угийн бичиг хамгийн олон байсан нь энэ хэлбэрийн угийн бичиг хэрэглэхэд амар хялбар, дөхөмтэй байсан болов уу.

Энэ хичээл нь сурагчдад судалгаа хийх аргыг зааж өгөхийн зэрэгцээ олсон мэдээллээ боловсруулж сурах, мөн хийсэн ажлаа тайлагнахад сургаснаараа үнэлж баршгүй их ач холбогдолтой байсан. Сурагчид дараагийн хичээлээ догдлон хүлээж, өөрийгөө нээгээд зогсохгүй гэр бүлээ хайрлан хүндэтгэх болсон юм.

Сурагчид илүү их зүйлийг сурч мэдэхийг хүсч байлаа. Дараагийн хичээл дээр “Дэгдээхий нас минь” сэдвийн дор сургуульд анх орсон тухайгаа болон өөрсдийн зорилго, хүсэл мөрөөдлийг нарийн судлахаар болов.



Ээлжит хичээлийн төлөвлөлт

Эхний цаг. СЭДЭВ СОНГОХ

Зорилго:

- Тогтвортой хөгжлийн боловсролын талаарх ойлголт өгөх
- Суралцагчдын сонирхолд нийцсэн сэдэв сонгох.

Зорилт:

- Улс орны тогтвортой хөгжлийн төлөө өөрсдийн оруулах хувь нэмрийг тодорхойлох
- Өөрийн нутаг орны өмнө тулгамдсан асуудлуудыг судлан шийдвэрлэх аргад сургах
- Суралцагчдаар сонирхсон сэдвийн тор бүтээлгэх
- Санал бодлоо чөлөөтэй илэрхийлэх чадвар эзэмшүүлэх.

Хичээлийн хэлбэр:

Харилцан яриа

Хичээлийн бэлтгэл:

Суралцагчдын санал бичих хуудас, Тогтвортой хөгжлийн боловсролын талаарх мэдээлэл, маркер, дэлгэц цаас, шохой г.м.

Төсөлт ажлын бэлтгэл ажил:

Багш энэ ажлыг сонгосны учир бол Монголын 13 настай хүүхдийн нас, сэтгэцийн хэрэгцээнд чухлаар үгүйлэгдэж байдаг сэдвийн нэг нь яах аргагүй өөрийгээ танин мэдэх, энэ талаар бусдын санал зөвлөгөө авч өөрийгээ зөв чиглүүлэх явдал байдаг. Энэ хэрэгцээг харгалзан би 7 дугаар ангийн хүүхдэд **“Би хэн бэ?”** сэдвийг төсөлт ажлын нэг цөм болгосон юм.

Ингээд сэдвийн хүрээ, агуулга хүүхдүүдэд ч их таалагдаж энэ ажлыг хэрхэн явуулах талаар багш сурагчид хамтран сайн тохирч авснаар ажил эхэлсэн. Бид юуны өмнө “Би хэн бэ?” сэдвийнхээ дэд сэдэв, сэдвийн торыг сайн гаргах хэрэгтэй гэж үзээд ярилцсаар:

1. Миний хүн чанар
2. Миний найз нөхөд
3. Миний бага нас
4. Миний өвөг дээдэс гэсэн сэдвээр баг болж ажиллах болсон.



- 



хүргэж чадсан юм. Энэ мэтчилэнгээр хүүхдүүд их бүтээлч ажиллахад өөрснөө л сурч байсан.

Энэ мэт ажилласны дараа хүүхдүүд олсон мэдээлэл дээрээ боловсруулалт хийж хэсэг ажилласан.

Мөн хүүхдүүд “Би хэн бэ?” төсөлт ажлын дэвтэр дээр багшийн өгсөн, өөрийгээ шинжих шалгуураар өөрийгээ шинжиж, асуултад хариулан зарим хүснэгтийг бөглөсөн.

Дараа нь хамтарч багаар ажлаа тайлагнахад бэлтгэж, зориулалтын том цаасан дээр өөрсдийн нээлтээ цэгцтэй бичиж, зурах, хайчлан наах зэргээр ажилласан.

Эдгээр үйл ажиллагааг харуулсан зурагт мэдээлэлтэй танилцана уу.




Энэ ажлын төгсгөлд төсөлт ажлын тайланг баг бүр хамгаалж, харилцан сонирхсон зүйлээрээ асуулт тавьж хариулт аван, саналаа хэлсэн юм. Мөн төсөлт ажлын талаар Жюгё кенкю хэлбэрээр үнэлгээ хийлээ.

“Би хэн бэ?” төсөлт ажлын үр дүн хүүхдэд хэрхэн нөлөөлөв?

1. Хүүхдүүдийн ярих чадвар дээшилж, хүнтэй харилцах, сонирхсон зүйлээрээ мэдээлэл авч чадах болж, харилцааны соёлд суралцсан
2. Мөн хүний яриаг тэмдэглэж, асуудлын голыг олж, ялгаж ухаарч чадах болсон.
3. Багаар хамтран ажиллах, мэдээлэл хуваалцахад сурсан.

Өөрийгээ таньж мэдэн олны дунд өөрийгээ зөв авч явж чадахад суралцав. “Хүн сайн явах санааных” гэдэг ардын үгийн учрыг биеэрээ мэдрэх болсон зэрэг нь эцэг эхчүүд болон багш надад ажиглагдсан.

3.2.2. ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН АСУУДЛЫГ ХӨНДСӨН ТӨСӨЛТ АЖИЛ**Сэдэв сонгох**

Энэ удаагийн туршилт нь “Бид” гэсэн агуулгын дор “Хүмүүс хоорондын харилцаа” сэдвийн хүрээнд олон нийт, хувь хүмүүстэй харилцаж амьдрал үйл ажиллагааг нь биечлэн судалж турших зорилготой байлаа.

Эхний 2 цагт “Сэлэнгэ – миний нутаг, бидний бахархал” сэдвийн дор нутаг орныхоо дараах онцлогийг тусгасан дараах дэд сэдвүүдийг санал болгоцгоов.

1. Түүхийн дурсгалт газар
2. Хувьсгалын өлгий нутаг
3. Улсын хэрэгцээт үр тарианы 50 орчим хувийг үйлдвэрлэж улсад тэргүүлэх байрыг эзэлдэг
4. Өндөр ашиг шимт мал сүргийн эх нутаг
5. Дэд бүтэц сайн хөгжсөн, төмөр зам, авто зам, усан замын тээвэртэй
6. Байгалийн үзэсгэлэнт газар, гол мөрөн ихтэй
7. Домогт Тужийн нарс



Ингээд дээрх сэдвүүдийг судлахаар,

1. Байгаль хамгаалал
2. Талх
3. Загас
4. Хоол хүнс
5. Үр тариа

гэсэн 5 багт хуваагдаж баг тус бүр өөрсдийн судлах сэдвийнхээ агуулгыг ярилцаж сэдвийнхээ тороо цааш судлагдахуун болгон задалж улам нарийсган төлөвлөв.

“ТАЛХ” БАГИЙНХНЫ СУДАЛГАА

- | | | |
|----------------|--------------------|------------------|
| Багийн гишүүд: | 1. Б.Мөнхдэлгэр | 6. А.Бат-Амгалан |
| | 2. Б.Мандахбаяр | 7. Ш.Гантулга |
| | 3. О.Мөнх-Од | 8. Ц.Гансүх |
| | 4. Г.Нандин-Эрдэнэ | 9. Ж.Сайханбилэг |
| | 5. Г.Элбэгзаяа | |

Тус багийнхан маань сонгосон дэд сэдвээрээ дараах асуудлуудыг судлахаар баг дотроо ярилцаж ажлаа төлөвлөсөн байна.



Энэ багийнхан “Сэлэнгийн талх сайхан гэдэг үнэн үү? – яагаад?” гэсэн сэдвээр судалгаа хийв.

Сэлэнгэд ирсэн хүмүүс буцахдаа “Сэлэнгийн талх сайхан” гэж заавал талх авч явдаг. Сэлэнгийнхэн бусад аймаг, хот руу явахдаа ах дүүс, төрөл төрөгсөд, найз нөхөд, үр хүүхэддээ Сэлэнгийн талх авч очдог гэлцдэг.

Багийн гишүүн Б.Мөнхдэлгэр “Гурван мэргэд” захын талх худалдаалах тасагт очиж талх худалдан авагчдаас сурвалжилга авав. Энэхүү сурвалжилгаас хэсэглэн авав.

Б.Мөнхдэлгэр:

– Та Сэлэнгийн талх юугаараа онцлог гэж бодож байна?

Худалдан авагч залуу:

– Би ийм том талх өөр хаана ч хараагүй, том мөртлөө амттай шүү.

Б.Мөнхдэлгэр:

– Сэлэнгийн талх сайхан гэдэг нь үнэн үү? Яагаад?

Худалдан авагч залуу:

– Үнэн байлгүй яахав. Өөрийнхөө үржил шимт хөрсөнд тариа будаагаа тарьж гурил хийн түүгээрээ талх барьдаг тул сайхан амттай юм.

Худалдан авагч эмэгтэй:

– Эрүүл мэндэд хорттой химийн бодис ороогүй, “хмел” хэмээх цэцэгнээс хөрөнгийг нь гаргаж хийдэг болохоор эрүүл хүнс, онцлог талх гэж бодож байнга худалдан авдаг даа.

Худалдан авагч өвөө:

– Хүүхдүүд хотоос талх явуул, Улаанбаатарын талхаар хоолшихгүй байна гэх юм. Тэгээд ах нь талх авч явна. Манай талх үнэхээр амттай. Олон жилийн туршлагаар нутгийн бренд болсон талх шүү. Ах нь өөр зүйл сайн мэдэхгүй дээ.



Талхан цехүүдэд хийсэн судалгаа

“Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн талх нарийн боовны цех”, “сургуулийнхаа үдийн цайны талх нарийн боовны цех”, “Ундрах” талхан цех, “Оргил” талхан цех, “Гурван мэргэд” захын талх худалдан борлуулах тасаг, “Энхнарангийн талхан цех”-үүдэд очиж талхыг ямар гурилаар яаж хийдэг, талхчин хүний хөдөлмөр ямар байдаг, нэг талх ямар өртөг хөлсөөр бүтдэг, Сэлэнгийн талх сайхан байдгийн нууцыг судалж мэдлээ.

- Талхчин хүний хөдөлмөр амар биш. Өдөржин халуун пийшингийн хажууд зогсоогоороо ажилладаг, заримдаа талхнууд нь түүхийрч түлэгдэх зэрэг бэрхшээл гарч гологдол болдог гэнэ.
- Сэлэнгийн талх сайхан байдаг нь түүнийг исгэдэг хөрөнгийг хмел буюу зөрх цэцэг гэдэг ургамлаар исгэж хийдэг нь исэх чадвар сайтай байгалийн цэвэр бүтээгдхүүн юм байна.
- Хмелийн ургамлаа 2-3 цаг буцалгахад хар цай шиг өтгөн ханд болно. Хандаа тодорхой хэмжээний өтгөн зуурмаг болгон бэлтгэж 8 цаг исгэхээр бэлтгэж тавина. Исгэсэн зуурмагнаасаа дахин хөрөнгө гаргана.
- Талхан цехүүдэд том талхыг голдуу хмелээр, жижиг талхыг данбаолигаар исгэдэг юм юм шиг байна.
- Дэлгүүрт 600 төгрөгөөр худалдаалдаг нэг талхыг талхан цехүүдэд ойролцоогоор бидний тооцоолсноор

гурил – 350 грамм (245 төг)
 исгэгч – 1 боодол (8 төг)
 ус – 1 литр (10 төг)
 давс – 15 грамм (5 төг)
 түлээ – (80 төг)

1 ширхэг талх нийт 348 төгрөгөөр бүтдэг гэж үзвэл (үүнээс хямд ч байж магадгүй) өдөрт 1 ширхэг талхнаас 232 төгрөгийн цэвэр ашигтай, 100 ширхэг талх хийвэл өдөрт – 23200 төгрөгийн цэвэр ашигтай байх юм. Хэрэв өдөр бүр талх баривал сард – 696.000 төгрөгийн ашиг олно гэж тооцоолов.

Туршилтын явцад сурагчид олон ном, сонин, сэтгүүлээс талхны талаар мэдээлэл цуглуулж олон зүйлийг мэдэж авлаа. Үүний заримаас дурьдвал:

► Талх яагаад сэвсгэр зөөлөн, нүхтэй байдаг вэ?

Талх жигнэдэг гурилд наалдамхай цавуулаг бодис байдаг ажээ. Зуурсан гурилд байгаа исгэгч нь нүүрсхүчлийн хийтэй олон бөмбөлөг үүсгэнэ. Хийгээр дүүрсэн цавуулаг бодис бөмбөлөг шиг сунана. Жигнэхэд цавуулаг бодис хатаж зөөлөрнө. Нүүрсхүчлийн хийгээр дүүрсэн цавуулаг бөмбөлөг хагараад хий нь чөлөөтэй гардаг. Ингээд талх хөвсгөр зөөлөн болдог. Талханд байдаг нүх нь нүүрсхүчлийн хий гарахад үлдсэн мөр байдаг.

► Хар талханд бие организмд хэрэгтэй бүх бодис байдаг.

Хар талх В-1 аминдэмээр баялаг, мэдрэлийн системийг тайвшруулж, цус харвахаас хамгаалдаг. В-6 аминдэм нь ой санамжийг сайжруулна. Е аминдэм нь дархлалын системийг сэргээж бэхжүүлнэ. Цайр их агуулагддаг учир хумс хугарч, үс унахаас сэргийлнэ. Хөх тарианы гурил нь цардуул багатай хивэг ихтэй байна. Хивэг нь ходоодонд боловсрохгүй бүдүүн гэдсэнд очиж задрахдаа дулаан ялгаруулна. Дулаан нь гэдэсний нянгийн үржлийг саатуулдаг. Бүдүүн гэдэсний гүрвэлзэх хөдөлгөөнийг ихэсгэж өтгөнийг хөөж гаргана. Бүдүүн гэдсэнд өтгөн удаан хуримтлагдвал биед хорт бодис үүсэх сөрөг нөлөөтэй байдаг байна.

Бидний туршилт

Хмел цэцгээр талхны хөрөнгө бэлтгэхээр хмелийг зах дэлгүүрээр өдөржин эрсэн боловч олдсонгүй. Эрэл мухардаад явж байтал Мөнхдэлгэрийн өвөө нь тааралдаж учраа хэлтэл Орхон голын цаана зөндөө л ургадаг байсандаа гэв. Тэгээд Б.Мөнхтулга, Б.Мандахбаяр нарыг голын цаана байдаг эмээгийн дээ очиж туслахыг хүсч тэр хоёр эмээгийн дээ очиж, эмээгээрээ хмелийн ургамлыг заалган түүж явтал харанхуй болж завиар гол гарч чадалгүй маргааш нь хичээлээ таслан яаран сандран ирсэн ч хмелийн ургамал олсондоо их баяртай байлаа. Тэгээд түүсэн ургамлын нь зааврын дагуу гэртээ хөрөнгөө исгэж үзэхэд болж байсан тул улам ч их урам орлоо.

Бид талх хийж чадах болов уу?

Бид өдөрт 600 төгрөгөөр нэг талх авдаг гэж үзээд тэр 600 төгрөгөөрөө дараах бүтээгдэхүүнүүдийг авч өөрсдөө талх барьж үзэхээр шийдлээ.

1-р гурил 250 грамм – 175 төгрөг	}	Нийт бүтээгдэхүүн – 600 төг
2-р гурил 150 грамм – 100 төгрөг		
өндөг 1 ширхэг – 180 төгрөг		
цөцгийн тос – 70 төгрөг		
Цахилгааны үнэ – 75 төгрөг		

Эдгээр бүтээгдэхүүнээ авч хмелийн хөрөнгөөрөө талхныхаа зуурмагийг ангидаа исгэж тавиад 7 цагийн дараа үзтэл исээгүй байлаа. Учир нь ангид нэлээд сэрүүн байсны дээр талхныхаа зуурмагийг өтгөн, хатуу зуурснаас алдсан байх гэж таамаглав. Дээрх алдаагаа засч дахин зуураад үзтэл зуурмаг маань үнэхээр сайхан исч, хэвэндээ хийж жигнэхэд үнэхээр сайхан талх болсон байв. Талхны дээд тал нь түлэгдэх шинжтэй болонгуут тугалган цаас давхарлан тавихад түлэгдсэнгүй.

Бид амтлаг, тэжээллэг, үнэхээр сайхан талх хийж чадлаа.

Өөрсдийн хийсэн талхаа дэлгүүрийн талхтай харьцуулж үзэв.

Бидний хийсэн талх

Тэжээллэг
Амттай
Чигжүү
Ямар нэгэн хольц шаардлагагүй
Зүсэхэд үйрэхгүй
Идүүцтэй
Амархан цадаж байсан
2-р гурил хийсэн учир өнгө нь бор

Дэлгүүрийн талх

Зүсэхэд үйрч ихэнх нь хаягддаг
Дэндүү сэвсгэр
Цагаан гурилаар хийсэн
Цавуулаг ихтэй, идэц муутай

Хийсэн талхаа ангийнхандаа, бас хичээлд суусан багш нартаа амтлуулж үзүүлэхэд биднийг их магтсан шүү.



Талхны пийшин барих хэцүү юу?

Манай багийн 3 хүү нэг баг болж талхны пийшин барихаар шийдэж судалсан. Бид юуны өмнө талхны пийшин барих аргачлалыг харуулсан “Таны амьдралд ашиг тустай” номыг судалж үзэхэд 2-3 янзын аргаар пийшин барих аргачлалаас нэгийг нь сонгосон.

- Эхлээд пийшингийнхээ зургийг тоймлон зурсан
- Хатуу цаасаар пийшингийнхээ загварыг гаргаж хийсэн
- Загвараа улам сайжруулж модоор хийсэн
- Багийн гишүүн Ш.Гантулгын гэрт засвар хийгээд үлдсэн тал туйпуунууд, цемент, шаврыг ашиглан тэдний хашаанд талхны пийшингээ 2 талыг нь бариад, гадаа хүйтэрсэн учир гүйцээж чадаагүй орхисон. Дулаан болохоор гүйцээж барина гэж бодож байгаа.

ДҮГНЭЛТ

1. Дээрх тооцооноос үзэхэд бид хэрэгцээнийхээ талхыг өөрсдөө гэртээ барьж идвэл хамгийн ашигтай, хэмнэлттэй, дэлгүүрийн талхийг бодвол тэжээллэг чанартай болох юм байна гэж дүгнэж үзэв. Өдөрт 1 талх хэрэглэдэг гэр бүл нэг талхнаас 232 төг, сард 6960 төг, гэр хороололд байдаг байнга галтай байдаг айл бол үүнээс ч илүү хэмнэх боломжтой.
2. Эсвэл өдөрт 1 талх авдаг 600 төгрөгөөрөө дээрх бүтээгдэхүүнүүдийг аваад талх барих нь илүү үр дүнтэй юм байна гэж үзэв.
3. Ангийнхаа бүх охидыг талх барьж, бүх хөвгүүдийг талхны пийшин барьж сургавал төсөлт хичээлийн маань зорилго хамгийн сайн биелнэ дээ.

“ЗАГАС” БАГИЙНХНЫ СУДАЛГАА

Багийн гишүүд	Б.Баасанжаргал
	Б.Мөнхтулга
	У.Бат-Эрдэнэ
	Н.Хосбаяр

Энэ багийнхан судалгааныхаа явцад Сэлэнгэ аймаг нь Орхон-Сэлэнгийн үзэсгэлэнт сав газар оршдог. Хэнтийн уул нуруудыг сүлжсэн Орхон, Туул, Хараа, Ерөө, Ивэн, Бургалтай, Шүрэн, Манхтай, Шарын гол зэрэг том жижиг гол зүг зүгээс цутган нийлдэг учир Сэлэнгэ аймгийг олон голын бэлчир нутаг гэж хэлж болно. Монгол орны урсгал усны 55% манай аймгийн нутгаар урсан өнгөрдөг. Хөвсгөлийн уулсаас эх авсан Дэлгэрмөрөн, Хангайн нурууны араас эх авсан Идэр гол хоёр нийлж Сэлэнгэ мөрнийг үүсгэнэ. Энэ хоёр голын бэлчрээс авахуулаад 992 км алслан урсаж Байгал нуурт цутгадаг. 590 гаруй км нь манай нутагт байдаг. Сэлэнгэ мөрний хамгийн том цутгал нь Орхон гол юм гэдгийг мэдэж авлаа. Гол мөрөн ихтэй учир загас ихтэй. Утсан загас бол Сэлэнгэчүүдийн бренд бүтээгдэхүүн билээ. Багийн гишүүн Б.Баасанжаргалын өвөө Болд загас барихдаа алдартай, загасны талаар мэдлэг ихтэй тул багийн зөвлөхөөр ажиллаж бидэнд их зүйлийг зааж өглөө. Б.Баасанжаргал загас барьдаг бүх хэрэгслэлээр үзэсгэлэн гаргаж ангийнхандаа тайлбарлаж өгсөн нь их сонирхолтой болов.

Бидний туршилт

Туршилт-1 “ЗАГАС ХАТААХ”

Эхний туршилт маань загас хатаах байв. Б.Баасанжаргал өвөөтэйгөө загасанд явж маш олон жижиг загас барьж ирлээ. Эхлээд бид загас хатаах хайрцгаа хийсэн. Хайрцаг нь тал талаасаа салхи орох боломжтой тороор хийгдсэн, дотор нь загасаа өлгөж хатаах зориулалттай утаснуудыг татаж өгнө. Эхний хийсэн хайрцаг маань яйжийгаад уначихмаар муу болсон тул дахин хийж арай сайн болов.

Загасаа хатаахдаа загасныхаа хэвлийг зүсч угааж цэвэрлэнэ. Давс болон амтлагчаа хийж буцааж хавчина. Загасныхаа толгойн хэсгээр сатуркан утсандаа сүвлэж хайрцгандаа өлгөөд тагийн нь тавьж салхи орохоор сүүдэр газар 21-ээс дээш хоногоор хатаана. Эхний туршилт маань амжилттай боллоо.

Туршилт-2 “ЗАГАС УТАХ”

Бид зах дээр загас утаж зарах бизнес эрхэлдэг хувийн жижиг цехийн үйл ажиллагаатай танилцав. Тэнд маш олон загасыг зэрэг утаж, шарах төхөөрөмжтэй. Загасаа Гурван мэргэд зах дээр бөөндөж зардаг юм байна. Бид гэрийн нөхцөлд энгийн аргаар утах хялбар төхөөрөмж бэлтгэв. Хөнгөн цагаан том лаазыг хоёр талд нь цоолж нүхлэв. Нүхэндээ төмөр бэлдцийг тохируулан суулгав. Тэр төмөрнөөс загасаа дүүжилж утах юм. Модоо бэлтгэхдээ улиас, бургас, хус зэрэг модны аль нэгийг сонгож авна. Өөр модыг сонговол утсан загас маань гашуун амттай болох тул болохгүй. Давирхайгүй мод байх ёстой. Төмөр лаазныхаа амыг дээш харуулж ёроолд нь бэлтгэсэн модоо өрж тавина. Улиасны навчнуудыг дэвсэж өгвөл сайхан үнэр нь загасанд шингэнэ. Лаазныхаа дороос гал түлж өгнө. 3-4 цагийн дараа загас утагдаж бэлэн болно.

Бидний алдаа

Утах загасаа утсаар сайн ороож дүүжилсэн байхыг зах дээр зарж байгаа загаснаас зөндөө харсан мөртлөө бид нар утах загасаа толгойноос нь хатааж байгаа шигээ дүүжилсэнд толгой нь үлдээд бие нь тасраад бүх загаснууд маань уначихсан байсан

Туршилт-3 “ЗАГАС НӨӨШЛӨХ”

Бид дэлгүүрээс 2 ш дунд зэргийн загас худалдаж авсан. Хайрсыг нь цэвэрлэж сэлүүрүүдийг нь авсан загас байсан. Бид загасныхаа толгойг нь салган авч, гэдэс дотрыг нь цэвэрлэж, нурууг нь дагасан нөж зэргийг нь сайтар цэвэрлэсэн. Загасныхаа махыг хөндлөнгөөр нь хэрчиж бэлтгэсэн. Түргэн буцалгагчийнхаа ёроолд нь давхар ул тавьж хэрчсэн загасаа өрж тавина. Өрсөн махан дээгүүрээ 3 ш лаврын навч, бөөрөнхий хар перец 6-8 ш тарааж тавьж өгнө. Үл ялиг нунтаг давс цацаж, ургамлын тосыг махны дээгүүр 5 мм-ээс илүүгүй байхаар хийнэ. Давхар улнаас дээш 2-3 мм хэмжээтэй байхаар тохируулж ус хийнэ. Түргэн буцалгагчаа сайн таглаж 30 мин буцалгана. Хэсэг хугацааны дараа халаалтыг арай бууруулан дахин 20 мин буцалгаж бэлэн болгоно. Аварын клапан буусны дараа тагийг онгойлгож цэвэр томатыг элсэн чихэртэй хольж хутган консерв дээрээ

хийж буцалгах төдий халаагаад авна. Шилэн саванд хийж хөргөгчид хадгална. 5 хоногоос илүү хадгалж болохгүй.



*Туршаад үзээрэй,
маш гоё.*



“ХООЛ ХҮНС” БАГИЙНХНЫ СУДАЛГАА

Багийн гишүүд

Ц.Халиун
Ө.Намжилмаа
М.Мэндтуяа
Б.Солонго

Судлах асуудлууд

1. Эрүүл бус хоол хүнс, сануулга, сэрэмжлүүлэг
2. 10 муу хоол хүнс
3. 10 сайн хоол хүнс
4. Сургуулийн эмчтэй хамтарч ажиллах
5. Сургуулийн нийгмийн ажилтантай хамтарч ажиллах
6. Мэргэжлийн хяналтын байцаагч нартай хамтарч ажиллах
7. Бага ангийн сурагчидтай хамтарч ажиллах
8. Хүнсний дэлгүүр, хоолны газраар судалгаа хийх



Сургуулийн орчим олон “ТҮЦ” ажилладаг. Энд хятад улсаас оруулж ирсэн үнэ хямдтай, эрүүл ахуй шаардлага хангаагүй, баталгаагүй чихэр жимс худалдаалдаг. Сурагчид түүнийг их авч иддэг. Энэ багийн сурагч Ө.Намжилмаа амралтын өдөр гэрийнхээ ойролцоох “ТҮЦ”-ээс өнгөтэй будагтай модтой чихэр авч идсэний маргааш өглөө нь бүх биеэр нь улаан зүйл туурч эмнэлэгт хэвтэхэд эмч чихрийн хор гэж 10 хоног хэвтэж эмчлүүлсэн. Тус ангийн сурагч Д.Гэрэлсүрэн 4 найзтайгаа явж байгаад хямд үнэтэй ундаа авч ууснаас бүгд хордож, биеэр нь юм гарч, хичээлдээ 2 өдөр явж чадаагүй. Иймээс тэд ярилцаж хоол хүнс гэсэн сэдвээр судалгаа хийе гэж шийдсэн. Сургуулийн эмч, нийгмийн ажилтантай энэ тухай ярилцаж, тэд цаашид мэргэжлийн хяналтын газар уламжлан, сургууль орчмын “ТҮЦ”-үүдээс шаардлага хангаагүй, баталгаагүй чихэр жимсийг хураан авч, түүгээр нь бид сануулга сэрэмжлүүлэг гаргаж сургуулийн коридорт хадсан ба бүх бага ангийн сурагчдад яриа таниулга хийсэн.



“Хамгийн муу 10 хоол хүнс”

Ном сэтгүүлээс уншиж судлан, эдгээр 10 хоол хүнсийг хамгийн муу эрүүл бус хүнс гэж үзэн, биетээр нь цуглуулан тус бүрийг тайлбарлан тайлангаа тавилаа.

1. Тосонд шарсан хоол хүнс
 - ⊗ зүрх судасны өвчний гол гэмтэн
 - ⊗ хорт хавдар үүсгэгч бодис агуулна
 - ⊗ амин дэмийг устгана.
2. Даршилсан хүнс
 - ⊗ даралт ихэсгэнэ
 - ⊗ бөөрны ачааллыг хүндрүүлнэ.
3. Хиам, утсан мах
 - ⊗ нитрит их агуулдаг учир хавдар үүсгэх бодис агуулна.
4. Хийжүүлсэн ундаа
 - ⊗ кальцийг биеэс ихээр алдагдуулна
 - ⊗ ясыг сийрэгжүүлж хэврэг болгоно.
5. Бэлэн гоймон
 - ⊗ шим тэжээл муутай
 - ⊗ давс, хэт их амт оруулагч орсон учраас элгийг гэмтээнэ.
6. Нөөшилсөн хүнс
 - ⊗ аминдэм нь устаж, уургийн шинж чанар нь өөрчлөгддөг.

7. Хатаасан жимс, мармелад
 - ⊗ нитрит агуулна
 - ⊗ муудахаас хамгаалсан бодис элгэнд халтай.
8. Хөлдөөсөн хүнс, зайрмаг
 - ⊗ чихэр ихээр орсон тул хоолонд дургүй болгоно
 - ⊗ шүдэнд халтай.
9. Хайрсан, хуурсан хүнс
 - ⊗ хавдар үүсгэгч хорт бодисыг үүсгэнэ.
10. Хэт их чихэрлэг, өнгө будаг ихтэй жигнэмэг
 - ⊗ Өнгө, амт оруулагч ихтэй учир элэгний үйл ажиллагаанд ачаалал өгнө
 - ⊗ амин дэмийг устгана
 - ⊗ шим тэжээл багатай.

“Хамгийн сайн 10 хоол хүнс”

1. Шар буурцаг
 - ☺ “ургамалан мах” гэж өргөмжилдөг
 - ☺ 13 бүлгийн амин дэм ихтэй
 - ☺ цусан дахь холестеролыг бууруулна
 - ☺ зүрх судсанд тустай кали их агуулна.
2. Хэрээсэн цэцэгтэй хүнсний ногоо
 - ☺ кальци, кали, төмөр, шүлтлэг элементийн агууламжаар баян, хүний биед хүчил, шүлтийн тэнцвэрийг хангахад чухал нөлөөтэй.
3. Сүү тараг
 - ☺ кальцийн эх булаг
 - ☺ тараг ходоодны хүчлийг нэмэгдүүлдэг учир хоол боловсруулах ферментийг идэвхжүүлж, бүдүүн гэдэсний бактерийн өсөлтийг зогсооно.
4. Далайн загас
 - ☺ уургийн агууламж ихээс гадна амархан шингэдэг, ханаагүй өөхний хүчил 80%-аас дээш тул эрүүл мэндэд онцгой ач холбогдолтой
 - ☺ артерийн судасны хатуурал, цус өтгөрөлт, бүлхрэлтээс урьдчилан сэргийлнэ.
5. Улаан лооль
 - ☺ Олон төрлийн хорт хавдар, зүрхний титэм өвчний үүслийг багасгана.
6. Ногоон цай
 - ☺ цайнд агуулагддаг фенол нь зүрх, судасны өвчин, хорт хавдраас урьдчилан сэргийлнэ
 - ☺ вирус устгаж, нян эсэргүүцэж, тураана.
7. Хар мөөг
 - ☺ Цусны бүлэгнэлтийг бууруулж, судасны хатуурлаас сэргийлнэ.
8. Шар лууван
 - ☺ каротиныг их агуулдаг
 - ☺ нүдний харааг сайжруулна
 - ☺ хоол боловсруулалтанд сайн нөлөөтэй.

9. Гурвалжин будаа
 - ☺ цусны даралтыг бууруулна, зүрх судасны өвчинд сайн нөлөөлнө.
10. Өндөг
 - ☺ хүний биед зайлшгүй хэрэгцээтэй бараг бүх шим тэжээлийг агуулдаг
 - ☺ А, В1, В2, Д аминдэмүүдийг агуулна.

Бид сургуулийнхаа хоолны газар, сургууль орчмын дэлгүүрүүдээс сурагчид голдуу юу авч идэж байгааг судалсан.

- Сургуулийн хоолны газар зарагдаж байгаа, нэг тосонд олноор нь хайрсан пирожки
- Зайрмаг
- Иштэй чихэр болон хямд үнэтэй чихрүүд
- Напилеон хэмээх хувь хүний хийсэн давхраат жигнэмэг.

ДҮГНЭЛТ

Айл өрх бүр сайн 10 хүнсийг хоол хүнсэндээ түлхүү хэрэглэж, харин муу 10 хүнсийг аль болох хэрэглэхгүй байж сурах хэрэгтэй юм байна.

Ер нь сургууль дээр болон сургууль орчмын “ТҮЦ”-үүдээс хямд үнэтэй эрүүл хүнс олж идэх боломжгүй учир сурагчид аль болохоор гэртээ идэх хүнсээ бэлтгэж ирэх нь зохимжтой юм гэж дүгнэлээ.

Сургууль орчмын дэлгүүр, “ТҮЦ”-үүд нь бөөний дэлгүүрүүдээс хүнсний барааг хямд үнэтэй авч, үнэ нэмэн жижиглэнгээр зарж ашиг олдог юм байна. Иймээс сургуулийн захиргаа нь санаачлан сургууль дээр бөөний дэлгүүрийн тасаг нээж сурагчдад хямд үнэтэй сүү тараг, хүүхдэд хэрэгтэй эрүүл хүнс зарвал сургуулийн орчинд олон дэлгүүр байхгүй болно байх аа.

Бид ангийнхандаа дараах хүнсний бүтээгдэхүүнийг бэлтгэж, гэртээ ийм хоол хүнсийг бэлтгэж ирж байвал ямар вэ гэсэн саналыг дэвшүүлж туршилт хийлээ.

- | | |
|-------------|---|
| 1 дэх өдөр | Талхны багийнхны хийдэг шиг хивэгтэй булочка 1 ш, улаан лооль 1 ш |
| 2 дахь өдөр | Нэг зүсэм талх, жигнэсэн байцаа, лууван |
| 3 дахь өдөр | Жижиг контик, 1 ш алим |
| 4 дэх өдөр | Ууттай самар |
| 5 дахь өдөр | Чанасан өндөг, булочка – ийм байвал ямар вэ? |

Хүүхдүүд голдуу л 250 төгрөгөнд багтааж юм авдаг юм шиг байна, бид ч бас ингэж төлөвлөсөн.




“БАЙГАЛЬ ХАМГААЛАЛ” БАГИЙНХНЫ СУДАЛГАА

Багийн гишүүд

1. Г.Номин
2. Э.Золбоо
3. Г.Баярмаа
4. Л.Дөлгөөн
5. Б.Батдолгор
6. С.Туяачимэг

Судлах сэдвүүд

- Байгаль хамгаалахад бидний оролцоо
- “Гялгар уут цэцэг биш” сэдэвт ажил
- Тужийн нарсны байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаанд хийх судалгаа
- Мод үржүүлгийн газарт хийх судалгаа
- Нарсан төгөлхөн байгуулах
- “Хоёр модны яриа” зохиомж



Сүхбаатар сумыг бохирдуулж байгаа хог хаягдлын ихэнх хэсэг нь өнгө алаглан хэвтэж байгаа гялгар уутнууд юм. Бид “Гялгар уут цэцэг биш” сэдэвт ажлын хүрээнд ангийнхаа сурагчдын гялгар уутны хэрэглээний тооцоог хүүхэд тус бүрийг 7 хоног ажиглуулж судлуулсны үндсэн дээр нэг айл 7 хоногт 100 төгрөгний гялгар уут хэдийг хэрэглэж байгааг хүүхэд тус бүр дээр тооцоолон гаргалаа.

Тус анги нь 37 сурагчидтай, 7 хоногт нийт 103 ш уут худалдаж авсны үнэ 10300 төг, сард 253 ш уут худалдаж авч хэрэглэсний үнэ – 25300 төг болж байна. Тэгвэл гялгар уут авч хэрэглэхийн оронд өөрсдөө даавуун уут оёж байнга хэрэглэвэл дээрх мөнгийг хэмнэх боломжтой гэж үзлээ. Ингээд ангийнхаа охидын дунд хүнсний бүтээгдэхүүнд зориулсан даавуун уут хийх уралдааны болзлыг гаргав.

**8д ангийн охидын дунд зарласан хүнсний,
даавуу уут урлах уралдааны удирдамж**

2008-11-18

Сүхбаатар сум

“Гялгар уут цэцэг биш” сэдэвт ажлын хүрээнд даавуу уут урлан, амьдрал ахуйдаа ашиглан, гялгар уутыг хэрэглээнээс гаргаж мөнгө хэмнэх зорилгоор 8д ангийн охидын дунд “Даавуун уут урлацгаая” уралдааныг зарлаж байна. Уралдаан 2008 оны 11-р сарын 18-22-ны хооронд явагдана. Уралдаанд оролцох бүтээл нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

1. Өнгө үзэмжтэй
2. Загвар дизайн сайтай
3. Бат бөх
4. Даавуун материалаар хийгдсэн
5. Угаахад хялбар

Дээрх шаардлагыг ханган хамгийн гоё оёж эхний гурван байрт орсон уутыг шагнаж урамшуулна.

Та бүхнийг манай уралдаанд амжилттай оролцохыг уриалж байна.

“Манай охидууд цоглог шүү!”

“Байгаль хамгаалал” багийнхан

Уралдаанд бүх охидууд маань оролцсон. Хамгийн гоё уут урласан Б.Мөнхдэлгэр, Ц.Халиунаа, Г.Баярмаа нарыг шалгаруулж бяцхан шагнал гардууллаа. Ангийнхаа охидод маш их баярлалаа. Охидынхоо хийсэн уутнуудыг тусгай том самбарт гоё байрлалтай өлгөж бусад хүүхдүүдэд суртчлав. Нийт багш сурагчид, эцэг эхчүүдэд зориулж дараах уриалгыг гаргаав.

Уралдаанд охид маань идэвхтэй оролцсон. Хамгийн гоё уут урласан Б.Мөнхдэлгэр, Ц.Халиунаа, Г.Баярмаа нарыг шалгаруулж бяцхан шагнал гардууллаа. Ангийнхаа охидод маш их баярлалаа. Охидынхоо хийсэн уутнуудыг тусгай том самбарт гоё байрлуулж өлгөж, бусад хүүхдэд сурталчлав. Нийт багш, сурагчид, эцэг эхчүүдэд зориулж уриалга гаргав.



Охидын хийсэн даавуун уутнууд

Уралдаанаа дүгнэсний дараа өөрсдийн хийсэн сайн үйлсийг сургууль даяар өрнүүлэхээр шийдэж дараах уриалгыг гаргав.

Нийт багш, сурагчид, эцэг эхчүүдийн анхааралд

2008-11-22

Дэлхий нийтийн хог хаягдлын 30 хувийг гялгар уут эзэлдэг. Гялгар уут байгаль орчин, эрүүл мэндэд маш муу нөлөөтэйг эрдэмтэд баталж, Хөгжингүй орнуудад цаасан болон даавуун торыг өргөн хэрэглэх болсон. Манай улсын гялгар уутны хэрэглээ их. Жирийн айл сардаа 3000 орчим төгрөгийг гялгар уутанд зарцуулдаг гэсэн судалгааг гаргажээ. Гялгар уутыг хаясны дараа байгаль дээр 100-400 жил болдог учир муу нөлөөтэй байдаг. Гялгар уут нь модны үндсэнд наалдсан тохиолдолд 1 м² газрыг үржил шимгүй болгодог байна. Гялгар уутны оронд даавуун уутыг оёж ахуйн хэрэглээндээ ашиглаж хэвшвэл: манай багийнхны тооцоолсноор манай анги 37 сурагчидтай сард 253 ш уут хэрэглэдэг гэсэн судалгаа гарч байна. 1 ш уутыг 100 төг гэж үзвэл гялгар уут худалдаж авахгүй даавуун уут хэрэглэснээр сард 25300 төг хэмнэх тооцоо гарч байна. Иймээс тус сургуулийн нийт багш, сурагчид, ажилчид, болон эцэг эхчүүдэд хандаж өрх бүр ахуйн хэрэглээндээ даавуун уут ашиглаж мөнгөө хэмнэцгээе гэж уриалж байна.

8-д ангийн “Байгаль хамгаалал” багийнхан

“Гялгар уут цэцэг биш” сэдэвт ажлынхаа хүрээнд Сэлэнгэ аймгийн Мэргэжлийн хяналтын газрын байгаль орчны асуудал хариуцсан байцаагч Сэлэнгэ, Сүхбаатар сумын Тамгын газрын байгаль орчин хариуцсан мэргэжилтэн Эрдэнэбилэг, Сүхбаатар сумын хот тохижилтын газрын ажилтнуудтай уулзаж эдгээр байгууллага, хүмүүс ямар ажил, үйл ажиллагаа эрхэлдэг. Сүхбаатар сумаа хоггүй цэвэр цэмцгэр хот болгоход юуг анхаарах, ямар бэрхшээл тохиолддог талаар ярилцлага хийлээ. Эдгээр хүмүүс “Та нар их зөв юм хийж байна” гээд хүүхдүүдийг халуун дотно хүлээн авсанд тэд их л сэтгэл өндөртэй буцаж ирлээ.



Бидний туршилт судалгаа

Бид Тужийн нарсны байгалийн цогцолборт газрын Мод үржүүлгийн газарт гучин тавуулаа нэг өдрийн аялал хийлээ. Мод үржүүлгийн газар маань Сүхбаатар сумаас 10 гаруй километрийн зайтай оршдог. Энэ байгууллагын мэргэжилтэн Гэрэлбаатар гуай бидэнд,

- Ой гэж юу вэ?
- Ой ямар ашигтай болох
- Ойг яаж нөхөн сэргээдэг
- Мод үржүүлгийн газарт модыг яаж тарьдаг талаар сонирхолтой сургалт явуулж их зүйлийг зааж сургалаа.

Бид нийт 130 ширхэг нарс мод тарьж нарсан төгөлхөн байгуулах эх сууриа тавилаа.



“Байгаль хамгаалах” багийнхан Тужийн нарсны байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны сургалтын танхимд очиж энэ байгууллагын үйл ажиллагаатай танилцаж, манай аймагт ямар ямар мод ургамлууд ургадаг, ой мод устаж үгүй болж байгаа шалтгаануудын талаар судалж мэдлээ. Тэд их зүйлийг судалж мэдэхэд тусалсан тус байгууллагын ажилтан Мөнхцэцэг эгч, Гэрэлбаатар ах нартаа чин сэтгэлээсээ баярласнаа илэрхийлж байлаа.

Ийнхүү хүмүүст анхааруулах зорилгоор жүжгийн зохиомж бичсэнийг доор бүрэн эхээр нь орууллаа (Монгол хэлний хичээлээр тэдний олж авсан мэдлэг чадвар сайн байгааг харах болно).

“Хожуулханд тохиолдсон эмгэнэлт явдал”

(Зохиомж)

Мод хулгайгаар бэлтгэдэг хоёр нөхөр хөрөө сүх хангинуулсаар гарч ирэн,

– Өнөөдөр чинь ямар сайхан өдөр вэ? Ойн цагдаа байхгүй дээр нь хэдэн мод унагаагаад зараадахъя. – Энэ модыг авах уу? – Наад шатсан хар модоор чинь яах вэ?” гэж ярилцсаар залуу сайхан модноос нь түүж авъя гээд тэр хавьд байгаа хамаг сайхан моднуудыг хөрөөдөж, цавчиж аваад явцгаалаа. Бас сэтгэл нь ханаагүй бололтой эргэн хараад “– Энэ нэг сайхан хус модыг сүхнийхээ ишийг хийх гээд хадгалаад байгаа юм, маргааш ер нь цавчина” гэх нь тэр.

Саяхан цавчигдсан нэгэн модны хожуул:

– Ёо ёо ёо ёо, Ямар их өвдөж байна аа? гээд л учиргүй уйлж, ёолж гарлаа.

Гэтэл нэлээд хуучирсан нэгэн хожуул

– Битгий уйл даа, хожуулхан минь. Бидний хувь заяа иймээс л хойш яалтай билээ дээ, их өвдөж байгаа биз? гэвэл нөгөө шинэхэн хожуул:

– Тийм ээ, их өвдөж байна. Хожуулхан минь. Урьд нь би чиний зовлонг даан ч мэдэхгүй байж дээ. Чи хэзээ ийм хожуул болчихсон юм бэ? гэхэд,

– Гурав хоногийн өмнө нэг өвөө ирээд өвлийн хүйтэнд хөлдөж үхэх нь, чамайг авахаас даа гээд л саглагар сайхан биеийг минь цавчиж аваад явчихсан юм гэв.

– Чиний ойролцоо байгаа тас хар хожуулхан юу гэж хэлэхсэн бол?

– Хүмүүсийн анхаарал болгоомжгүйгээс болж би болон миний найзууд бүгд шатаж үгүй болсон, Одоо бидний орчинд ганцхан энэ нэг сайхан хус л үлдэх шив дээ” гэвэл хуучин хожуулхан,

“Зулзган цагаан хус нь зулай дээрээс гунхана

Цорын ганцхан чиний минь хувь заяа нь бүрхэг байна даа” гэв.

Хус, “– Гунхсан сайхан хус намайг хөрөөдөнө гэвэл гонжийн жоо” гэж хэлэхтэй зэрэгцэн хөрөө сүхний ханганах чимээ сонстов.

Модны хулгайч нар асуй...

ДҮГНЭЛТ

Байгаль хамгаалахад бидний хийж чадах зүйл нь:

- ▶ Хог хаягдлаа аль болох ил задгай хаяхгүй, зориулалтын саванд хийх
- ▶ Даавуун уутыг байнга авч явж хэвших, гялгар уутыг хэрэглээнээс шахах
- ▶ Хүүхэд бүр, айл өрх бүр боломжийнхоо хэрээр мод тарих.

“ҮР ТАРИА” БАГИЙНХНЫ СУДАЛГАА

Багийн гишүүд: Б.Уранзаяа
 Х.Гантуяа
 Д.Гэрэлсүрэн
 О.Тэргэл
 П.Хонгорзул

Судлах асуудлууд:

1. Тариалан эрхлэлтийг дэмжих газарт хийсэн аялал
2. Гурилын үйлдвэрт гурилыг яаж хийдэг вэ?
3. Бид ямар гурил иддэг вэ?
4. Цагаан гурил сайн хүнс үү?
5. Хивэг иддэг хүн байхгүй л байх
6. Бидний туршилт

Бидний иддэг гурил нь хэрхэн бий болдгийг үзэж сонирхов.

Эхний тээрэмдэлтээр хивэг, хоёр дахь тээрэмдэлтээр III гурил, гурав дахь тээрэмдэлтээр II гурил, дөрөв дэх тээрэмдэлтээр I гурил, тав дахь тээрэмдэлтээр дээд гурил, зургаа дахь тээрэмдэлтээр хэмхдэс буюу дээдийн дээд гурил болж гардгийг мэдэж авлаа. Бид, ер нь хүмүүс ихэвчлэн ямар гурил иддэг болохыг сурагчид болон багш нараасаа асууж судлахад ихэвчлэн дээд юмуу I гурил иддэг гэж хариулж байв. Бид өөрсдөө ч адил байв. Үүнээс үндэслээд чухам ямар гурил хамгийн сайн болохыг судалж мэдэхээр шийдэв.

Олон ч ном сэтгүүл уншлаа. Дэлхийн таван тив дээр улаан буудай тариалдаг юм байна. Канад, АНУ, ОХУ болон Африкийн умард эрэг, Аргентиний нутгуудад хамгийн дээд зэрэглэлийн буудай ургадгийг ч мэдэж авав.

Бүх төрлийн буудайнууд химийн найрлагаараа нэг янз буюу нүүрстөрөгч, уураг, өөх тос, эрдэс бодис, аминдэм болон будагч бодисуудыг агуулсан байдаг.

Үр тариаг 3 хувааж үздэг:

Амуу тарианы – Улаан буудай, хөх тариа, арвай, овьёос, эрдэнэ шиш, цагаан будаа

Хошуу будааны – Гурвалжин будаа

Буурцагт ургамлын – Вандуй, шош, шар буурцаг

эдгээрийг тус бүрт нь судалж үзлээ.

Хүн, аль болохоор хоол хүнсэндээ бүдүүн ширхэгтэй гурил хэрэглэвэл эрүүл мэндэд ач тустай юм байна гэдгийг олж тогтоолоо. Гурилыг олон удаа тээрэмдэх бүрт найрлагандаа байгаа үнэт зүйлүүдээ алддаг байна. Үр тариа, амуу будаа, үрт ургамал ислэгээр маш баялаг. Хүнсний ислэг нь бидний биед хоол шиг задарч шингэдэггүй, харин биеийг цэвэрлэж байдаг юм байна. Гурил бүдүүн ширхэгтэй тусмаа ислэг ихтэй байдаг гэнэ. Тиймээс аль болохоор II, III гурил, хивэг, арвайн гурил зэрэг ислэг ихтэй бүтээгдэхүүн хэрэглэснээр:

- Өвчинд амархан өртөхгүй
- Холестриныг өөртөө шингээж биеэс гадагшлуулж өгдөг
- Шулуун гэдэсний гүрвэлзэх хөдөлгөөнийг сайжруулна
- Ходоодны шархны эдгэрэлтэд тустай
- Жин хасдаг юм байна гэдгийг мэдэж авлаа.

Хамгийн эхний тээрэмдэлтээр гардаг хивэг нь элэг,цөс ,ходоод гэдэсний өвчтэй хүнд ач тустай, эрдэс бодис элбэгтэй, олдоц ихтэй учир ямар ч хоолноос илүү давуу талтай. Хивэг идсэнээр өтгөн хатахгүй, тэгээд ч ходооны гүрвэлзэх хөдөлгөөнийг сайжруулдаг сайн талтайг судалж мэдэв.

Бидний судалснаар улаан буудайн гурил дараах химийн бүрэлдэхүүнтэй байдаг байна:

Гурилын зэрэг	Ус	Уураг	Өөх тос	Нүүрс-ус	Эслэг	Ккал
2-р зэрэг	14.0	11.5	1.4	71.3	0.8	352
1-р зэрэг	14.0	11.0	1.1	72.9	0.3	354
Дээд	14.0	10.8	0.9	73.6	0.2	354

Дээрх хүснэгтээс харвал хоёрдугаар гурил ашигтай байгаа нь харагдаж байна. Мөн овьёосны гурилд, хүний биед чухал хэрэгцээтэй бодис агуулагдаж байдгийг судалж, манай худалдаанд байгаа гурилыг худалдан авч дараах туршилтыг хийлээ.

Бидний туршилт

Овьёосны хигэгдэс буюу геркулесны зутан хийх арга

3 аяга геркулес дээр хагас литр буцламгай сүү хийгээд таглаж тавина. 10 минутын дараа бүлж хөөсрүүлсэн 2 ширхэг өндөг, нимгэн зүссэн 1 ширхэг алим, бага зэрэг давс, элсэн чихэр нэмээд хутгана.

Ийнхүү бэлэн болсон 100 гр бүтээгдхүүний уураг – 12 гр., тос – 6 гр., нүүрсус – 51 гр., илчлэг – 306 ккал байна.



“Үр тариа” багийнхан судалж мэдсэнээ бодитоор нь авчирч нөхдөдөө танилцууллаа.

ДҮГНЭЛТ

1. Айл бүр хүнсэндээ аль болохоор бүдүүн ширхэгтэй гурил хэрэглэж хэвших, хүүхдүүд ялангуяа “Хар гурил муухай” гэж боддог энэ бодлоосоо салах нь зүйтэй гэж үзлээ.
2. Шар буурцаг, шар будаа, овьёос, эрдэнэ шиш, гурвалжин будаа зэрэг худалдаанд байгаа бүтээгдэхүүнийг хоол хүнсэндээ ашиглавал эрүүл мэндэд илүү тустай.
3. Талхны багийнханд хивэгтэй булочка хийх санал болгож тэдний баг хэрэгжүүлснээр амжилттай болсон. Бас геркулесны зутанг амтархан булаалдан идэж байсан нь хүүхдүүд гэртээ дахин хийж идэх сонирхлыг нь төрүүлсэн.

“НУТГИЙН ЦАЙ” БАГИЙНХНЫ СУДАЛГАА

Багийн гишүүд: З.Уянга
 Э.Долгормаа
 Б.Төгөлдөр
 А.Улсболд
 Г.Билгүүн

Хайрцаг савны дизайн чимэглэлийн баг:
 Б.Мөнхжин
 Т.Жавхлан
 М.Билгүүн
 Т.Түшигбаатар

Судлах асуудлууд:

- ✦ Төрөл бүрийн цай хийж турших
- ✦ “Шимт” брэнд тус ангийн нэрэмжит анхны цай
- ✦ Бөөрний цай
- ✦ Ядаргааны цай
- ✦ Цусны даралт буулгах буюу цэвэрлэгээний цай

Дэлгүүрүүдэд зарагддаг “Их Тайга”, “Хөвсгөл”, “Хангай”, “Сэлэнгэ” зэрэг цайнуудыг судлаад, иймэрхүү цайг нутгийнхаа өвс ургамлыг ашиглан хийж туршиж үзэхээр шийдлээ.

Бидний туршилт

“Шимт” нэрийн цай хийх

“Шимт” брэнд цайны орцонд:

Буриагулийн цэцэг
Нохойн хошуу
Тэхийн шээг
Аньсны навч
Аньс

Энэхүү цайнд ордог ургамлуудын талаар олон зүйлийг мэдэж авсан төдийгүй хайчилбаруудаараа “Нутгийн цай” сонин гаргаж нөхдөдөө танилцуулав.



Буриагулийн цэцэг – Манай аймгийн Мандал, Алтанбулаг сумын нутагт өндөр модтой газар ургадаг, анхилам үнэрт цайны ургамал. Нутгийн ард түмэн голдуу 8-р сард түүж, сүүдэр газар хатааж хэрэглэдэг. Биеийн дархлаа сайжруулах, бөөр, элэг, цэс, ходоод, нуруу нугасны өвчнийг анагаадаг (Энэ ургамлын тухай мэдээллийг бидэнд Долгормаагийн эмээ нь олж, хэлж өгсөнд бид нар маш их баярласан).

Нохойн хошуу – нохойн хошуунд А, С, В, Р аминдэмүүд элбэг байдаг. Нохойн хошууны жимсийг бүрэн боловсрохоос хэд хоногийн өмнө түүж, сүүдэр газар хатааж авна.

Аньсны навч – Хус ихтэй газар ургана. Тавдугаар сард түүж авбал шим сайтай, витаминлаг чанар болон өвчин эдгээх чанар нь сайн байдаг. Амьсгалын замын өвчинд сайн. Сүүдэр газар хатаана.

Тэхийн шээг – Сэлэнгэ аймагт их ургадаг. Тэхийн шээг нь бөөрөнд сайн ургамал.

“Шимт” цайнаас гадна **“Хүрэн манжингийн цай”** хийж туршиж үзэцгээсэн. Энэхүү цайг хийхдээ 1 литр буцалсан усанд дунд зэргийн хүрэн манжинг хальсалж түүхийгээр нь хийгээд, бүрж тавина. Түүнээсээ бүлээнээр өдөрт 3 удаа уувал даралт өндөртэй хүний даралт нь буух буюу цусыг цэвэршүүлдэг байна.

Энэ мэтчилэн манай багийнхан нийтдээ 5 төрлийн цай хийж туршиж үзэв.

Хамгийн гол нь цайны ургамлаа түүх хугацааг нь зөв тодорхойлж, зөв түүж, зөв хатааж, нүдэж бэлтгэх нь их чухал гэдгийг мэдэж авлаа.



Цайны сав хайрцагны дизайн, зураг чимэглэлийг хариуцсан багийнхан мод, шил, цаас, картон зэргийг ашиглан өөрсдийн бэлтгэсэн цайндаа хэдэн төрлийн хайрцаг хийж савлав. Бидэнд энэ хайрцаг савыг үзэмжтэй сайхан хийхэд манай сургуулийн Ш.Ганболд багш их тусаллаа.



Сурагчдын
хийсэн
цайны сав

ДҮГНЭЛТ

- ◆ Эмийн ургамал ихтэй манай аймгийн хувьд цайны ургамлаа өөрсдөө бэлтгэж, чанар сайтай, витаминлаг цайг үнэгүй хэрэглэх боломжтой юм байна.
- ◆ Ямар өвчинд ямар ургамал сайн гэдгийг мэдэж авснаар өөрт байгаа өвчнийг эмгүйгээр анагаах аргыг мэдэж авлаа.
- ◆ Хичээлд суусан багш нар ч биднээс их зүйлийг сурч авсанд бид баяртай байна.
- ◆ Сонингийн хайчилбарууд ашиглан “Нутгийн цай” нэртэй сонин гаргалаа.

Хичээлд суусан ажиглагч багш нарын сэтгэгдлээс:**Ч.Алтантуяа:**

- Олон байгууллага дээр очиж хүмүүстэй уулзаж, мэдээлэл цуглуулан тайлагнаж, үйл ажиллагаандаа ашиглажээ. Амьдрах ухаанд суралцаж, амьдралдаа хэрэгтэй олон сайхан материал цуглуулж, түүнийгээ хэрэглээ болгож чадсан байна.

С.Оюунцэцэг:

- Хамтран ажиллаж, тодорхой асуудлыг шийдвэрлэх явцдаа бие биеэндээ туслах зэргээр хамтач, нөхөрсөг уур амьсгалыг бүрдүүлж чаджээ.

Э.Ариунаа:

- Санаагаа оновчтой гаргаж, судалсан зүйлээ бусдадаа ойлгомжтой тайлбарлаж, мэдсэнээ амьдралд хэрэглэх чадвар сайн байна.

Ц.Баярмаа:

- Мэдээллийг цуглуулж боловсруулалт хийх чадвар ахисан нь ажиглагдаж байна.

Д.Нарантуяа:

- Судалгааны явцад олсон мэдээллээ ашиглан өөрсдөө хийж туршсан нь амжилттай болсон төдийгүй бусдадаа сайн үлгэр дуурайл боллоо.

Ц.Рэнцэнноров:

- Сурагчид маш их чадваржиж байгаа нь харагдлаа. Туршлагыг нийт сурагчдад сурталчилмаар байна.

Б.Сэлэнгэ:

- Илтгэх чадвар сайн байлаа. Цуглуулсан мэдээллээ олон талаас нь ашиглаж, эерэг, сөрөг талыг нь сайн гаргаж дүгнэж байна.

Б.Сарантуяа:


- Хамтарч ажиллах чадвар нь эрс сайжирсан, мөн асуудлыг шийдвэрлэх арга нь илүү нарийсч сайжирсан байна.

С.Олонтуяа:

- Бүтээлч ажлуудыг хийж чаддаг болжээ.

ТУРШИГЧ БАГШИЙН ДҮГНЭЛТ

- ◆ Төсөлт ажил хичээлийн хоёр дахь жилийн туршилтыг тогтвортой хөгжлийн боловсролыг сурагчдад төлөвшүүлж, сурагчдаа бүх талаар нь хөгжүүлэхэд анхаарч, үйл ажиллагаагаа чиглүүлж, зөвлөж ажиллалаа.
- ◆ “Бид” – сэдвийн хүрээнд олон байгууллага, хүмүүстэй хамтарч, тэднээс суралцаж ажилласан нь энэ жилийн төсөлт ажлын онцлог байлаа.
- ◆ Сурагчид өөрсдөө суралцаад зогсохгүй бусдад үлгэр жишээ үзүүлж, зааж сургаж, туршлагаа дэлгэрүүлж байв.
- ◆ Тайлант хичээлдээ эцэг эхчүүдээ бүгдийг оролцуулж санаа бодлыг нь сурагчидтайгаа хамт сонсож, цаашид хийх ажлаа дүгнэж, ярилцах явцад эцэг эхчүүд хүүхдүүдтэйгээ хамтарч төсөлт ажил хийгээд, түүнийгээ хамт олныхоо дунд тайлагнах шинэ санааг гаргасан ба дараагийн удаа хамтарч хийхээр төлөвлөж байна.
- ◆ Өнгөрсөн жилтэй харьцуулахад багуудын багаар ажиллах чадвар илүү сайжирсан нь ажиглагдаж байгаа бөгөөд багшийн хувьд ажиллахад нэлээд хялбар дөхөм болж байна.
- ◆ Сурагчид өөртөө оногдсон ажил, судлах зүйлийнхээ явцад бусад багуудын холбогдолтой ном зохиол, мэдээллийг олж өгөх, бусдадаа туслах сэтгэл гаргаж байгаа нь их сайшаалтай, баярлууштай байлаа.
- ◆ Тайлант хичээлээ урлагийн зааланд, бүх ангиудын сурагчдын төлөөллийг оролцуулан нээлттэй хийсэн нь төсөлт ажлын талаар сурагчдын ойлголтыг нэмэгдүүлэхэд тодорхой хувь нэмэр болсон гэж үзэж байна.



Нэгдүгээр цаг: СЭДЭВ СОНГОХ

Зорилго:

- Тогтвортой хөгжлийн боловсролын талаарх ойлголт өгөх
- Суралцагчдын сонирхолд нийцсэн сэдэв сонгох

Зорилт:


- Улс орны тогтвортой хөгжлийн төлөө өөрсдийн оруулах хувь нэмрийг тодорхойлох
- Өөрийн нутаг орны өмнө тулгамдсан асуудлыг судлан шийдвэрлэх аргад сурах
- Суралцагчдаар сэдвийн тор бүтээлгэх
- Санал бодлоо чөлөөтэй илэрхийлэх чадвар эзэмшүүлэх

Хичээлийн бэлтгэл: Суралцагчдын санал бичих хуудас, тогтвортой хөгжлийн боловсролын талаарх мэдээлэл, маркер, дэлгэц, цаас, шохой г.м.

Хичээлийн төлөвлөлт:

Суралцагчийн үйл ажиллагаа	Багшийн үйл ажиллагаа
1. Эдийн засаг Байгаль ахуй Нийгэм ахуй Мэдээлэл авч багшаас сонирхсон асуултуудаа асууна 2. Сэдвийн тор үүсгэхэд өөрсдийн саналыг оруулж тороо бүтээнэ. 3. Сонирхлын баг бүрдүүлнэ 4. Цаашдын судалгааны ажлын төлөвлөгөө гаргана. 2. Сэдвийн тор үүсгэхэд өөрсдийн саналыг оруулж тороо бүтээнэ. 3. Сонирхлын баг бүрдүүлнэ. 4. Цаашдын судалгааны ажлын төлөвлөгөөг гаргана.	1. Суралцагчдад тогтвортой хөгжлийн талаарх ойлголт өгнө. 2. Тогтвортой хөгжлийн гурвалжнаас “Байгаль ахуй” сэдвийг сонгож хэлэлцүүлнэ. 3. Сонгосон сэдвийн дагуу сэдвийн торыг бүтээлгэн цаашид судлах сэдвүүдийг төлөвлөнө. 4. Суралцагчдыг сонирхлын багт хуваана. 5. Багуудаар судалгааны ажлын сэдвийг сонгуулж, төлөвлөлт гаргуулна.

Суралцагчийн үйл ажиллагаа	Багшийн сэтгэгдэл
1. Суралцагчид тогтвортой хөгжлийн талаар мэдээлэл авч сонирхсон асуудлаа багшаас чөлөөтэй асууж байлаа. 2. Суралцагчид дэлхий нийт болон манай оронд, манай аймагт тулгамдаж байгаа хамгийн чухал гол асуудал нь байгаль орчин гэдэгтэй санаа нэгдэж, энэ асуудлыг сонгож авлаа. 3. Энэ хүрэнд судлах сэдвийн жагсаалт гаргаж, түүн дотроос “Гялгар уут” сэдвийг сонгон сэдвийн тор бүтээлээ. 4. суралцагчид сонирхлын дагуу 4 багт хуваагдаж багшийн өгсөн дараах чиглэлээр төлөвлөгөө гаргав. 1) Сэдэл 2) Төсөөлөл 3) Судалгаа 4) Судалгааны арга 5. Хичээлийн төгсгөлд сурагчид зорилго, чиглэлээ тодорхойлон, судлах ажлаа хуваарилж авлаа.	♦ Тогтвортой хөгжлийн боловсрол нь ганцхан томчуудын ярьдаг асуудал биш юм. Энд хүүхэд бидний оролцоо маш чухал байдаг юм байна гэсэн санааг олон сурагчид ярьж байв. ♦ Суралцагчид бүгд Дорнод нутгийнхаа хог хаягдал тэр дундаа гялгар уут орчинг ихээр бохирдуулж байгаад ихэд сэтгэл түгшиж явдаг нь ажиглагдаж байлаа. ♦ Суралцагчдын өөрийн үзэл бодлоо илэрхийлэх чадвар маш сайн байлаа. ♦ Багш хэдийгээр гялгар уут гэсэн жижиг сэдвийг сонгосон ч энэ нь эдийн засаг, байгаль орчин, нийгэмд хэрхэн нөлөөлдөг, хэрэглээ гэх мэт олон талаас нь судлах ёстойг суралцагчдад зөвлөлөө.



Хоёрдугаар цаг: ГЯЛГАР УУТ БИДНИЙ НҮДЭЭР

Зорилго:

- Сэдвийн торын дагуу гялгар уутны тухай олон талын судалгаа хийж мэдээлэл цуглуулж тайлагнах

Зорилт:

- Цуглуулсан мэдээллийг бусдадаа илтгэж тайлбарлах чадвар эзэмших
- Зурах бичих, нэгтгэн дүгнэх аргад суралцах

- Бусдыг хүндэтгэн сонсох, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх
- Багаар хамтарч ажиллах

Хичээлийн хэлбэр: Асуудал судлаад тайлагнах, дүрд орох төсөлт ажил

Хичээлийн бэлтгэл: Хаягдал гялгар уут, дэлгэц, цаас, маркер г.м.

Хичээлийн төлөвлөлт:

Суралцагчийн үйл ажиллагаа	Багшийн үйл ажиллагаа
1. Багууд судалгааны арга, зорилго зорилтоо танилцуулна 2. Бэлтгэсэн судалгаа тайланг илтгэх (дүрийн тоглолт г.м.) 3. Өөрийн тэмдэглэл хөтлөх, өөрийгөө үнэлэх - судалсан зүйл - төрсөн сэтгэгдэл - өөрийн үнэлгээ - цаашдын судалгаа 4. Багийн ахлагч нар багийн гишүүдийн идэвх оролцоог үнэлэх	1. Багуудийн зорилго зорилттой танилцаж, зөвлөгөө өгнө. 2. Суралцагчдын судалгааг бусад багуудын хамт сонсож хэлэлцэх 3. Суралцагчдаар өөрийн тэмдэглэл хөтлүүлэх, өөрийн үнэлгээ хийлгэх 4. Цаашдын хийх ажлийн төлөвлөгөөг гаргуулах 5. Хичээлийн бус цагаар суралцагчдын судалгааны ажилд туслах

Суралцагчийн үйл ажиллагаа	Багшийн сэтгэгдэл
1 дүгээр баг. Багийн ахлагч Хонгор “Гялгар уутны үүсэл” сэдвээр илтгэл тавилаа. Мэдээллийг интернэтээс авсан байна. 2 дугаар баг. “Гялгар уутны сайн тал”. Өдөр тутмын хэрэглээ, дахин боловсруулах үйдвэрийн тухай мэдээлэл бэлтгэсэн байна. Хувцас хийх гэсэн боловч маш хэцүү байсан тухай ярьж байлаа. 	1 дүгээр баг: Гялгар уут хэрхэн яаж үүссэн тухай сурагчид өмнө нь огт мэддэггүй байсан учраас илтгэлийг сонирхон сонсож байлаа. Багийн гишүүдийн өөрийн үнэлгээ, багийн ахлагчийн үнэлгээнээс харахад энэ мэдээллийг нэг сурагч бэлтгэсэн байна. Иймд багийн гишүүдэд бүгд судалгааны ажилд идэвхтэй оролцохыг зөвлөлөө. 2 дугаар багийн хувьд судалгааг маш хангалтгүй бэлтгэсэн учир бусад багийн гишүүдийн сонирхлыг татаж чадсангүй. Багийн гишүүд ч алдаагаа ухамсарлан дараагийн хичээлд идэвхтэй оролцохоо ангийнхандаа амлалаа. Багш багаараа хамтарч ажиллахыг зөвлөв.

3 дугаар баг. “Гялгар уутны байгаль орчинд үзүүлэх хор нөлөө”. Багийн гишүүд ажлын төлөвлөгөөг маш сайн хийсэн тул бүх судалгаа, үйл ажиллагаа эмх цэгцтэй сайн боллоо. Хогны машины жолоочтой уулзаж 7 хоногт орон сууцнаас гарч байгаа хог хаягдлын 50-55% нь гялгар уут байдаг тухай судалгаа хийсэн байна.



4 дүгээр баг. “Дахин боловсруулах үйлдвэр”. Дорнод аймагт гялгар уут дахин боловсруулах үйлдвэр байгуулагдсан тухай холбогдох хүмүүстэй уулзах гэсэн боловч чадаагүй байна. Гэвч энэ үйлдвэр нь хаягдал уутаар сандал, траншейны таг, цэцгийн сав, гялгар уут зэргийг хийдэг тухай зурагт мэдээлэл цуглуулсан байна.

5 дугаар баг. “Гялгар уут загварт”. Хаягдал гялгар уутаар янз бүрийн загвартай хувцас хийж болно. Хүүхдүүд хийх хувцасныхаа загварыг зурж, ямар материал хэдий хэмжээтэй орох тооцоог гаргалаа.

3 дугаар багийн онцлог нь Гялгар уутны байгаль орчинд үзүүлэх нөлөөг биологи, газарзүйн мэдлэгээ ашиглан олон талаас нь тайлбарлаж байлаа (хөрс, ус, хүн, амьтан, ургамал, орчин).

4 дүгээр баг. Энэ баг ажлын байранд судалгаа хийх зорилготой байсан боловч үйлдвэрийг нь түр хугацаагаар хааснаас болж, өөрсдөө энэ талаар сонирхолтой мэдээлэл бэлтгэжээ. Суралцагчид төсөлт ажлаар олсон мэдлэгээ бусад хичээлтэй холбон, амьдралд ойр жишээгээр маш оновчтой зөв тайлбарлаж байсан нь ангийн сурагчид болон ажиглагч багш нарын талархлыг хүлээж байлаа.

5 дугаар багийн онцлог нь загвар зохион бүтээж загвар өмсдөг охид олон байлаа. Дараагийн хичээлд өөрсдийн гараар хийсэн хувцсаа өмсч танилцуулахаар төлөвлөсөн байна.

Гуравдугаар цаг. ГЯЛГАР УУТ БИДНИЙ АМЬДРАЛД

Зорилго:

- Гялгар уутны хэрэглээ ач холбогдол, байгаль орчинд үзүүлэх хор нөлөөг судлах

Зорилт:

- Гялгар уутны хэрэглээг багасгах талд анхаарч санал солилцох, шийдвэрлэх, зөв хэрэглэх арга ухаанд сургах
- Санал бодлооо чөлөөтэй илэрхийлэх

Хичээлийн хэлбэр: Асуудал судлаад тайлагнах, дүрд орох төсөлт ажил

Хичээлийн бэлтгэл: LCD, дэлгэц, компьютер, ватум цаас, өнгийн цаас г.м.

Хичээлийн төлөвлөлт:

Сурагчдын үйл ажиллагаа	Багшийн үйл ажиллагаа
1. Багууд өөрийн судалгааг танилцуулж, тайлан тавих 2. Сурагчид өөрсдийн сонирхсон асуултыг бусад багуудад тавих 3. Өөрийн үнэлгээ хийж, цаашдын төлөвлөгөө гаргах	1. Сурагчдын хичээлийн бэлтгэлийг хянах 2. Багуудын тайланг сонсох, зөвлөн туслах 3. Хүүхдүүдээр өөрийн үнэлгээ хийлгэж, цаашдын төлөвлөгөө гаргуулах

Сурагчдын үйл ажиллагаа	Багшийн сэтгэгдэл
Хичээл эхлэхээс 20 минутын өмнө сурагчид өөрсдийн бүтээлийг цэгцлэн янзалж тайлан тавихад бэлтгэв. 1 дүгээр баг. “Гялгар уутны хэрэглээ”. Хэрхэн зөв ашиглах талаар илтгэл тавилаа. Мөн дэлгүүрт хагас өдөр ажиллан, ихэвчлэн ямар бараа бүтэгдэхүүн гялгар уутанд савлагддаг, хүмүүс хэр их хэрэглэдэг тухай судалгаа хийжээ. 	Хичээлийн зорилго чиглэлийг сайн ойлгож, судалгааны ажлын арга зүйд сайн суралцсан нь харагдаж байлаа. Энэ багийн онцлог нь дэлгүүрт 5 цаг ажиллаж, худалдагч нарт туслан, ажлын байранд судалгаа хийсэн байна.  Хүмүүст тусалж, олон хүмүүстэй харилцах нь тэдэнд маш их таалагдсан гэж ярьж байлаа. Энэ явцдаа тэд хүмүүст гялгар уутны хор уршгийн талаар мэдээлэл хийжээ.



2 дугаар баг. “Гялгар уут загварт”.
Багийн гишүүд өөрсдөө загварыг нь
зохиож, гялгар уутаар хувцас хийж
өмсөн ангийнхандаа үзүүллээ.



2 дугаар баг: Хүүхдүүд хувцас хийхэд
маш их цаг зарцуулсан байна. Мөн
энэ хувцсыг хийхэд хэдэн төгрөгний
гялгар уут хэрэглэсэн тооцоог хийжээ.
Суралцагчид бидний хог хаягдал гэж
боддог гялгар уутаар өөр олон юм хийж
болох талаар мэдэж авснаа ярив.
Энэ нь суралцагчдын бүтээлч сэтгэлгээг
хөгжүүлэх, эдийн засгийн тооцоо хийхэд
сургасан хичээл боллоо.

3 дугаар баг. “Гялгар уутны байгаль орчинд нөлөөлөх нөлөөлөл” сэдвээр ханын сонин гаргаж, жүжигчилсэн тоглолт бэлтгэн, “Бидний ирээдүй болсон хүүхэд залуучууд хоггүй эрүүл орчинд амьдраасай” гэсэн уриалга гаргажээ. Мөн хогны машины жолоочтой уулзан ярилцлага хийж, хог хаягдлын 55% нь гялгар уут байдаг тухай мэдээлэл авсан байна.



3 дугаар баг: Сурагчид тайлангаа, зурагт үзүүлэн, ханын сонин, жүжигчилсэн тоглолт зэрэг олон хэлбэрээр хамгаалав. Энэ багийн гишүүд бүгд судалгааны аргад сайн суралцсан ба ичиж зоволгүй өөрийгөө чөлөөтэй илэрхийлж чаддаг болсон байна.



4 дүгээр баг. “Гялгар уутны байгаль орчинд нөлөөлөх нөлөө” сэдвээр ханын сонин хийж мэдээлэл цуглуулан илтгэл тавилаа.



4 дүгээр багийн хувьд маш чухал мэдээлэл цуглуулсан боловч түүнийгээ нэгтгэж цэгцлэн, илтгэх тайлагнах чадвар зарим сурагчдад дутмаг байгаа нь ажиглагдаж байна. Гялгар уут ашиглан маш сонирхолтой ханын сонин хийжээ.



5 дугаар баг. “Гялгар уут дахин боловсруулах эдийн засгийн тооцоо”. Зөвхөн гялгар уут ашиглан өөрсдийн гараар ханын сонин гаргасан байна. Мөн нэг өрхийн 7 хоногийн, сарын, улирлын, жилийн гялгар уутны хэрэглээний тооцоог гаргаж, бусад багууддаа танилцуулав.



Хичээлийн төгсгөлд суралцагчидтай чөлөөт ярилцлагын цаг гарган цаашид юуг хиймэр байгаа тухай санал солилцов. Сурагчид:

1. Гялгар уут, хог хаягдлын талаар 8-р ангиудын дунд шүлгийн тэмцээн зохиох
2. Хаягдал уут, хайрцаг ашиглан, сургуульдаа хогийн сав хийх
3. Сургуульдаа хог хаяхгүй байх уриалга гаргах
4. Хогийн үйлдвэрт ажиллах
5. “Хаягдлыг зөвхөн хогийн саванд хийцгээ” аян зохиох саналтай байгаагаа хэлцгээлээ.

Суралцагчдаар хичээлийн эцэст дараах тэмдэглэлийг хөтлүүлж байсан нь тэдний мэдлэгийг дүгнэн, ахиц дэвшлийг судлахад дөхөмтэй байв.

Овог нэр Төсөлт ажлын сэдэв он сар өдөр
1. Хийсэн зүйл
2. Төрсөн сэтгэгдэл
3. Өөрийн үнэлгээ

Ээлжит хичээлийн төлөвлөлт

Дөрөвдүгээр цаг: ЮМХНААР ЮМ ХИЙЦГЭЭЭ

Зорилго:

- Хаягдал гялгар уут болон хуванцар хаягдлаар өөрт хэрэгтэй зүйлүүдийг хийж сурах

Зорилт:


- Гялгар уутны хэрэглээг багасгах талд анхаарч санал солилцох, шийдвэрлэх, зөв хэрэглэх арга ухаанд сургах
- Санал бодлоо чөлөөтэй илэрхийлэх
- Хаягдал ашиглан бүтээл хийх

Хичээлийн хэлбэр: Тоглоомын

Хичээлийн бэлтгэл: Ашигласан хуванцар ундааны лааз, сав баглаа боодол, хайрцаг гэх мэт

Хичээлийн төлөвлөлт:

Суралцагчийн үйл ажиллагаа	Багшийн үйл ажиллагаа,сэтгэгдэл
1. Суралцагчид саналаараа 4 үйлдвэр байгуулав. Өөрсдийн мөнгөнд тохируулан хаягдал бүтээгдэхүүнийг худалдан авцгаав. Багшийн зааврын дагуу худалдаж авсан бүтээгдэхүүнээр юу хийвэл өөрсдийн ашиг орлогоо нэмэгдүүлж болохыг ярилцан үйлдвэрлэх зүйлээ төлөвлөн бүтээгдэхүүнээ үйлдвэрлэнэ.  <i>Хаягдал ашиглаж хийсэн “үйлдвэр”-ийн бүтээгдэхүүн</i>	1. Одоо бүгдээрээ дахин боловсруулах үйлдвэр болж тоглоцгооё. 2. Дахин боловсруулах бүтээгдэхүүн тус бүрийг үнэлсэн байна. 3. Үйлдвэр бүрт 55000 төгрөг тарааж өгнө.Энэ мөнгөөрөө бүтээгдэхүүн худалдаж авна. Гэхдээ хэдэн төгрөгөнд багтааж авахаа өөрсдөө шийднэ. Явцын дунд та нарт дутуу байгаа бүтээгдэхүүнийг бусад үйлдвэрүүдээс худалдаж авч болно. Мөн хичээлийн төгсгөлд бусад багуудын үйлдвэрлэсэн, таалагдсан бүтээгдэхүүнүүдийг худалдаж авч болно гэдгийг сануулна. 4. Хаягдал бүтээгдэхүүнээр юу үйлдвэрлэвэл ашигтай болох талаар ярилцаж, урьдчилан төлөвлөхийг зөвлөнө. 5. Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг үнэ хаялцан худалдана. 6. Хичээлийн төгсгөлд ашиг, орлого зарлагыг тооцуулна. Яавал ашигтай ажиллах байсан бэ? гэдэг талаар харилцан санал солилцоно.




Эдний “үйлдвэр” завь, байшин хийсэн байна.

- Энэ хичээлийг явуулахын тулд өмнө нь багш бэлтгэлтэй байх шаардлагатай. Учир нь хэрэглэсэн ундааны сав, лааз зэрэг нь элдэв халдварт өвчин тараах магадлалтай тул хичээлд хэрэглэх хаягдал хэрэглэгдэхүүнийг хэдэн өдрийн өмнөөс бэлтгэн сайтар угааж ариутгах хэрэгтэй.

Сурагчид гарсан өөрчлөлт	Багшид гарсан өөрчлөлт
• Багаар ажиллах чадвартай болсон. • Бүтээлчээр ханддаг болсон. • Судалгааны зорилго, чиглэлээ тодорхойлж, мэдээлэл цуглуулдаг болсон. • АУБ, эцэг эхчүүд хичээлийг сонирхож, дэмждэг болсон. • Бие дааж мэдээлэл цуглуулж, боловсруулалт хийн, илтгэх чадвар сайн болсон.	◆ Багш, сурагчийн хамтын ажиллагаа сайжирсан. ◆ Суралцагчдаар өөрсдөөр нь мэдлэг бүтээлгэхэд анхаардаг болсон. ◆ Анги танхим, сэтгэл зүйн орчинг бүрдүүлэх талд анхаарч ажилласан. ◆ Багш аль болох олон талын мэдээлэл бүхий ном, сурах бичиг олж өгөхийг зорьсон. ◆ Сургуулиас шаардлагатай хэрэглэгдэхүүнээр хангаж, хамтран ажилласан.

Хос багш (Double teaching)-ийн заасан төсөлт ажил



Хичээлээр сурагчдад эзэмшүүлэх чадвар: Сурагчид банкны үйл ажиллагаатай танилцаж, санхүү эдийн засгийн анхны ойлголттой болох, өрхийн орлого зарлагаа тооцон, банк айл хүмүүсийн амьдралд хэрхэн холбогддогийг мэдэж авах.

Ажиглагчийн тэмдэглэл

Хичээлийн сэдвийн тухайд:

Энэ хичээл суурь боловсрол эзэмшиж байгаа сурагчдад амьдрал ахуйд нь яах аргагүй үгүйлэгддэг сэдвийг хөндөж, хүүхдүүдэд энэ талаар тодорхой мэдлэг, мэдээлэл өгсөн.

Багшийн үйл ажиллагааны тухайд:

1. Хичээлд Багш – Эцэг эх – Сурагч – Мэргэжлийн зочин гэсэн дөрвөн субъект оролцсон нь жинхэнэ хамтын хичээл боллоо.
2. Манай сургалтад төдийлөн байдаггүй “Хос багш”-ийн хэлбэрийг хоёр өөр сургуулийн багш нар хэрэгжүүлж, хоёр хүний хүч, оюун ухаан, ур чадвар нийлэхээр ямар төгс сайхан хичээл болж чаддагийг харуулж чадсан.
3. Төсөлт ажил, ангийн ажлын тухайд багш нар хүч, хөдөлмөрөө нэгтгэн хоршиж болох бодит жишээ болсон.

Сурагчийн үйл ажиллагааны тухайд:

1. НҮБ-ын 1992 оны хуралдаанаас “Тогтвортой хөгжлийн 3 тулгуур” гэж үзсэн эдийн засаг, байгаль ахуй, нийгэм ахуйн асуудлын нэг болох эдийн засгийн сэдвийг сонирхолтойгоор, хүүхэд, эцэг эхийн амьдралын хэрэглээнд тулгуурлан хөндөж чадсан хичээл болсон.
2. Дунд боловсролын бодлогын төвшинд чухалчлагдаж байгаа “Тогтвортой хөгжлийн боловсрол”-ын үзэл санаа, агуулгыг төсөлт ажлын хүрээнд тусган, хүүхдийн оюун санаанд хөрөнгө оруулалт болгохыг зорьсон.
3. Хүүхдийн бүтээлч үйл ажиллагаанд суурилсан, биеэр мэдрэх сургалт болсон.
4. Хүүхэд төвт төсөлт ажлын хөгжилд туршилт хичээлээр хувь нэмэр оруулж байгаа нэгэн ажил болсон.

5. Төсөлт ажлыг хүмүүсийн эдийн засаг, мөнгө, санхүүгийн амьдралтай холбохыг хичээсэн ба энэ сэдвээр хүүхдүүд өмнөх төсөөллөө баяжуулан зохих мэдлэгтэй болсон.
6. Хүүхдүүд **мэдээллийг бүтээлч үйлээрээ боловсруулан хүлээж авсан** бөгөөд энэ ялдамд үйлчилгээний харилцааны тухай мэдлэгтэй болж чадсан.
7. Харин цаашид уг ангийн хүүхдүүдийн хэл яриаг ээлжит хичээл, төсөлт ажил бүрээр хөгжүүлэх, хүүхдийг өөртөө итгэлтэй, бусдад хүртээлтэй ярих, тайлбарлахад сургах хэрэгтэй нь ажиглагдсан юм.

Хичээлд оролцогчдын тухайд:

Төсөлт ажлыг багш, сурагчид сайн бэлтгэсэн байлаа. Хичээлд хос багш Ц.Дулмаа, Б.Уранжаргал, болон 8а ангийн 29 сурагчаас гадна тус сургуулийг онц төгсөгч, аймгийн “Голомт” банкны мэргэжилтэн С.Төмөрхуяг **зочин багшаар**, Анударийн ээж Баасанжаргал нарын эцэг эхийн гурван төлөөлөгч багуудад **зөвлөгөө өгч ажиллахаар** ирсэн нь иргэд, эцэг эх, багш, сурагчид хамтарсан сонирхолтой хичээл болж чадлаа. Энэ удаагийн хичээл өмнөх хичээлийн үргэлжлэл бөгөөд уг хичээлээр сурагчдын гаргасан санал, дэлгэрүүлэн тодруулж ойлгох асуудал байв. Хос багш хичээлийг хийх ажлын төрлөөр хуваарилан авч хослон, зарим үед хамтран заасан юм.

Хичээлийн явц:

- ❖ Хичээлийн эхний хэсгийг Ц.Дулмаа багш чиглүүлэв.

Хичээлийн эхэнд багш нар хүүхдүүдийг бүлгээр ажиллуулахаар даалгавар бүхий том цаас, фламастер тараан, ажиллах зааврыг хэлж өгснөөр хүүхдүүд өрхийн орлого зарлагын нэг сарын дундаж тооцоог гаргав. Хүүхдүүд энэ талаар гэрийнхэнтэйгээ ярилцаж, жишиг гаргаж ирсэн нь тооцоо хийхэд ихээхэн дэм өгсөн юм. Энэ даалгаврыг зарим баг эцэг эхийн хамт гүйцэтгэж байлаа. Даалгавар хүүхдүүдэд сонирхолтой, амьдралд нь хэрэгтэй зүйл болохоор идэвхтэй, хэрдээ л хариуцлагатай хандацгааж байгаа нь илэрхий байв. Уг даалгаврыг багууд математикийн хичээлтэй холбон, тооцоолол хийж 14 минутад гүйцэтгэлээ.

Дээрх даалгаврын загвар:

Багааараа хэлэлцээд, нэг өрхийн сарын орлого, зарлагын тооцоо гаргах.

Даалгаврыг гүйцэтгэсэн 1-р багийн жишээ:

1. Ам бүл – гурав (аав, ээж, би)
2. **Сарын нийт орлого** **623 000 төгрөг**
 Үүнд:
 - аавын цалин 300 000 төгрөг
 - ээжийн цалин 170 000 төгрөг
 - миний тэтгэлэг 3000 төгрөг
3. **Сарын нийт зарлага** **545 000 төгрөг**
 Үүнд:

➤ Хоол, хүнсэнд	150 000 төгрөг
➤ Хувцас авахад	30 000-50 000 төгрөг
➤ Ахуйн хэрэглээнд	20 000-30 000 төгрөг
➤ Түлээ түлш, байр, гэрэл цахилгаан зэрэгт	100 000 төгрөг
➤ Зээл, түрээс зэрэгт	250 000 төгрөг
➤ Сургалтад зарах, ойр зуурын хэрэглээнд	10 000 төгрөг орчим
➤ Баяр ёслол, үзвэр, унаа, утасны нэгж зэрэг бусад зардалд	70 000 орчим төгрөг

4. Орлого, зарлагын баланс буюу үлдэгдэл нийт:

78 000 төгрөг

Багууд даалгаврын гүйцэтгэл болох нэг өрхийн сарын орлого, зарлагын тооцоог самбарт эгнүүлэн хадлаа. Багуудаас нэг хүүхэд өрхийн тооцоогоо тайлбарласан ба үлдэгдэл мөнгө, ашиг гарч буй эсэхийг самбарт бодож үзүүлэв.

Дулмаа багш “Багуудын тооцоог үзвэл өрхийн төсвөөс заримдаа үлдэгдэл гардаг юм байна. Энэ мөнгөө танайхны гэр бүл яадаг вэ? Илүү юм гээд үрж зардаг уу, эсвэл хадгалдаг уу?” хэмээн асуухад хүүхдүүд “Хадгалдаг” гэж хариулав.

Багш, сурагчдын дунд дараах яриа үүсэв:

- Тэр илүү мөнгөө аав ээж чинь яаж хадгалдаг вэ?
- Хадгаламжийн дэвтэр нээгээд банкинд хадгалдаг.
- Манайх болохоор ээж гэртээ авдрандаа хадгалчихдаг. Сар сард нэмэгдээд их мөнгө болдог. Тэгэхээр нь гэртээ томоохон эд хогшил авдаг.

❖ Хичээлийн хоёр дахь хэсгийг Б.Уранжаргал багш чиглүүлэв.

Б.Уранжаргал багш:

- Үлдэгдэл мөнгөө гэртээ хэн хэнийх хадгалдаг вэ? (Хүүхдүүдийн 70-аад хувь нь гар өргөв)
- Банкнд хэн хэнийх хадгалдаг вэ? (Хүүхдүүдийн 30-аад хувь нь гар өргөв)

Багш:

- Бидэнд банкны талаар мэдлэг бага байгаа. Иймд бид банкинд мөнгөө хадгалуулах, авахад тэр талын мэдээлэл их хэрэгтэй. Энэ тухайд манай сургуулийг онц төгссөн, “Голомт” банкны мэргэжилтэн С.Төмөрхуяг ах чинь та нарт тус болно гэж бодож байна. Бид түүнийг хичээлдээ зочин багшаар урьсан юм. Одоо зөвлөгөөг нь сонсоцгоё.

Зочин багш харилцааны банкны зорилго, үүрэг, гүйцэтгэдэг ажил, үйлчлүүлэгчидтэйгээ хэрхэн холбогддог, үйлчлүүлэгч мөнгөө хэрхэн хадгалуулж, авдаг талаар 8 минут танилцуулав. Түүний “Банкны үйл ажиллагаа бол саяын та нарын ярьсан өрх гэрийн санхүүгийн үйл ажиллагаатай адилхан, тодруулбал, орлого, зарлага, алдагдал, ашиг, данс тооцоотойгоороо яг л нэгэн өрх, гэр бүлтэй адилхан” гэх мэтээр ярьсан нь хүүхдүүдэд ойлгомжтой, их таашаагдав.

Зочин багш ярианыхаа төгсгөлд хүүхдүүдийг өөрийн авчирсан банкны харилцааны тухай лавлагаа самбараас сонирхсон материалаа авч үзэхийг урив. Сурагчид банкны тухай сонирхсон мэдээллээ авч үзэж, баг дотроо ярилцан бие биеэс зарим зүйлийг асууж тодруулж байв.

Зочин багшаас хүүхдүүд сонирхсон асуултаа асууж, хангалттай хариулт авав. Түүний дотор нэг хүү “Таны сарын орлого хэд вэ?” гэж асуусан нь бүх хүүхдийн сонирхож байсан асуулт байсан бололтой, тэд нирхийтэл инээв. Зочин багш “Та нарын гаргасан сарын үлдэгдэлтэй манай өрхийн үлдэгдэл ойролцоо юм байна” гэж хариулав.

Дараа нь хүүхдүүд банкны өдөр тутмын гол үйл ажиллагаа болох “орлогын касс”, “зарлагын касс”-ны ажилтнуудын харилцагчидтайгаа ажиллаж байгаа сэдвээр жүжигчилсэн тоглолт хийв. Баг бүр орлогын бланк, зарлагын бланк бөглөж, орлого зарлагын дансыг хариуцан ажиллаж байгаа хоёр сурагчтай харилцан мөнгөн гүйлгээ хийв. Тэд, банкны ажилтнууд үйлчлүүлэгчидтэйгээ хэрхэн зөв харилцаж туслах тухай дадлага хийлээ. Хүүхдүүд кассын өмнө дугаарлан зогссон нь үнэхээр итгэл үнэмшилтэй үйл ажиллагаа мэт харагдаж байлаа. Тэд яг л банкинд үйлчлүүлж байгаа боловсон харилцаатай үйлчлүүлэгчид шиг “Баярлалаа, та дахин ирж үйлчлүүлээрэй” гэх мэт үг хэллэгийг зөв боловсон хэрэглэж байлаа. Тэндээс хүүхдүүд, харилцагчдын хоёр талын боловсон харилцаа, харилцан хүндэтгэл дээр байгууллага, хувь хүмүүсийн хамтын үйл ажиллагаа тогтдог гэдгийг мэдэрсэн.

Дараа нь банкны өдрийн орлого, зарлага, мөнгөн гүйлгээний явц, дүнг хянан шалгах аар банкны мэргэжилтэн-зочин багшийг дагалдан туслахаар нь сурагч Ганхүү ажиллаж, гүйлгээний дүн зохих журмаараа явагдсаныг хүүхдүүдэд мэдэгдэв. Айл өрх бүр мөнгөө хяналттайгаар зөв зарж байх ёстой шиг байгууллага бүр өдрийн үйл ажиллагаандаа хяналттай, цэгцтэй ханддаг болохыг хүүхдүүд эндээс давхар мэдэж авлаа.



- ❖ Хичээлийн гурав дахь хэсгийг Ц.Дулмаа багш чиглүүлэв.

Дулмаа багш:

- Хүүхдүүд ээ, сая бид хадгаламжинд мөнгөө хадгалуулах, авах талаар дадлага хийж мэдэж авлаа. Ийнхүү мөнгө хадгалуулах, хадгаламжийн дэвтэр нээлгэхийн ач холбогдол юу болохыг Ариунсанаагийн ээж Э.Хосбаяр эгчээсээ мэдэж аваарай. За, одоо сонсоцгооё.

Ариунсанаагийн ээж Э.Хосбаяр гэрийнхээ болон хүүхдийнхээ хадгаламжийн дэвтрийг авчирснаа хүүхдүүдэд үзүүлж, тайлбарлалаа.

- ❖ Хичээлийн төгсгөл хэсгийг Б.Уранжаргал, Ц.Дулмаа багш нар хамтран чиглүүлэв.

Уранжаргал багш багуудад том цаасан дээрх даалгаврыг тарааж өгсөн ба энэ нь “Гурван М”-ийн аргаар хүүхдүүд ажиллах даалгавар байлаа.

1-р багийн гүйцэтгэсэн ажлын жишээ:

а. Банкны тухай өмнө нь МЭДДЭГ байсан зүйл

1. *Валютыг англиар FOREX гэдгийг,*
2. *Мөнгөний хүү яаж өсдөгийг,*
3. *Банкны ажилтнууд үйлчлүүлэгчтэйгээ хэрхэн харилцдаг тухай,*
4. *Мөнгөө банкинд хадгалуулах нь ашигтай болох тухай.*

б. Банкны тухай юу МЭДМЭЭР байна?

1. *АТМ дотор мөнгө яаж байдгийг,*
2. *Жирийн хүмүүс бид мөнгө тоологчгүй үед их мөнгө тоолох бол яаж түргэн шуурхай тоолохыг,*
3. *Банкны ажилтан болохын тулд ямар ямар шаардлага хангасан байх ёстойг,*
4. *Банкинд алдаа гарна, ашиг орлогогүй болно гэж байдаг эсэхийг,*
5. *Хадгаламжийн банкинд хүн огт мөнгө хадгалуулахгүй болчихвол тэр банк яах бол? Ажиллаж чадах болов уу?*

в. Банкны тухай МЭДСЭН зүйл

1. *Орлого зарлага хоёрын ялгааг,*
2. *Мөнгө яаж гуйвуулдгийг,*
3. *Ямар ч хүнтэй зөв харилцах ёстойг,*
4. *Хадгаламж нээлгэхийн ач холбогдлыг,*
5. *Банкны бланкийг зөв бөглөж сурлаа.*

Энэ ажлыг багууд 10 минутад бичиж бэлэн болгосон ба баг бүр ажлаа самбарт хадав. Энэ хооронд Дулмаа багш уг төсөлт ажилд оролцон хүүхдүүдтэйгээ нэг баг болцгоосон эцэг эхээс санал сэтгэгдлийг нь асуулга бүхий цаасаар авч байлаа.

Багаас хүүхдүүд төлөөлөн гарч ирж, банкны үйл ажиллагаа бидэнд хэр ач холбогдолтой талаар өмнө нь мэдэж байсан, мэдэхийг хүссэн, мөн юу мэдсэн тухайгаа тайлбарлалаа. Энэ хэсэг нь нэг ёсны төсөлт ажлын зорилго, зорилт хэрхэн биелэснийг нэгтгэн дүгнэсэн, шинэ мэдлэгээ бататгасан ажил боллоо.

Б.Уранжаргал багш хичээлийн төгсгөлд, хүүхдүүдээс “Банкны ажилтан болохыг хүсдэг хүүхэд бий юу?” гэж асуухад хоёр хүүхэд гар өргөв. Энэ нь төсөлт ажлаар хийвэл зохих гадаад интеграци бөгөөд нөгөө талаар мэргэжлийн чиг баримжааг төсөлт ажлаараа харгалзан холбож өгч байх сэдлэг асуулт байв.

Ц. Дулмаа багш:

- Та нарын цаашид мэдэхийг хүсэж байгаа зүйлийг “Тогтвортой хөгжил, эдийн засаг” бүлэг сэдэв доторх дараагийн дэд сэдэв дээр судалж мэдэх болно. Одоо хоёр багшаасаа асууж тодруулах зүйл байна уу? гэв.
- Энэ хичээлд оролцсон эцэг эх, зочин-багшдаа баярлалаа гэж хэлээд хичээлээ дуусгав. Хичээл 90 минут үргэлжилж төлөвлөсөн хугацаандаа багтав. Хичээл зорилгоо сайн хангаж хүүхдүүдийн сонирхол, хэрэгцээнд нийцсэн, тун сайн хичээл боллоо.

Багш таныг энэхүү хамтын хичээлээс санаа авах боломжийг бүрдүүлэх үүднээс хоёр багшийн нэгж хичээлийн хөтөлбөрийг доор танилцуулав.

Төсөлт ажлын төлөвлөлт

Батлав: Сургалтын менежер Е.Алтангэрэл

Төсөлт ажлын сэдэв: “Банк бидний амьдралд”

Хамрагдах анги: Хэрлэн сумын Хан-Уул цогцолборын 8а анги

Зорилго: Банкны үйл ажиллагаатай танилцаж, өрхийн орлого, зарлагаа тооцож сурах, банкны ач холбогдол, хэрэглээг мэдрүүлэх.

Зорилт:

1. Хүүхэд орлого, зарлагын ялгааг мэдэх, гэр бүлийн орлого, зарлагаа тооцох
2. Банкны үйл ажиллагаатай танилцаж банк зөв бөглөн, гүйлгээ хийж сурах
3. Хадгаламж нээлгэхийн ач холбогдлыг мэдэх, хүүг тооцох, мөнгийг зөв зохистой хэрэглэх аргад сурах

Хичээлийн хэлбэр: Бүтээлч үйл ажиллагаанд суурилсан биеэр мэдрэх хамтын хичээл (Хос багш)

Хичээлийн бэлтгэл:

1. Ангид банкны бичил орчин бүрдүүлэх,
2. Банкны мэргэжилтэнг зочин багшаар урьж оролцуулах,
3. Эцэг эхийн төлөөлөгчдийг хичээлд урьж, сурагчдын багийн бүрэлдэхүүнд оролцуулах,
4. Хичээлийн хөтөлбөр боловсруулан, үзүүлэн болон холбогдох хэрэглэхүүнийг цаасан дээр бэлтгэх.

Төлөвлөлт:

1. Суралцагчдыг багаар ажиллуулах
2. Гэртээ ажиглахаар өгч явуулсан өрхийн тооцоог багууд хэлэлцэх
3. Банкны бичил орчин бүрдүүлэх
4. Банкны мэргэжилтнээс мэдээлэл авах
5. Багууд өгөгдсөн даалгаврыг хамтран гүйцэтгэх
6. “Гурван М”-ийн аргаар асуулга авах (багуудаас), бататгал, дүгнэлт хийх.

Хичээлийн үйл ажиллагаа:

№	Суралцагчийн үйл ажиллагаа	Багшийн үйл ажиллагаа
1	Сурагч бүр гэрийн даалгаварт хийсэн өрхийн тооцоог багийн гишүүддээ танилцуулан, багаараа өрхийн дундаж орлого, зарлагыг тооцох	■ Сурагчдыг сонирхлын 4 багт хуваарилах ■ Сурагчдаар орлого, зарлагын жагсаалт гаргуулах, тооцуулах
2	Гаргасан тооцоог самбарт байрлуулан тайлбарлах	Асуулт 1. Орлогоо хэрхэн зохистой зарцуулах вэ?
3	Гаргасан тооцоонд багууд санал бодлоо илэрхийлэх	Асуулт 2. Хэмнэсэн мөнгөө хэрхэн нэмэгдүүлэх вэ? гэсэн асуулгаар хөтөлж банк гэсэн санааг гаргуулах
4	Сурагчдаас банкны ач холбогдол, хэрэглээний талаар санал гаргах	Асуулт 3. Одоо банк болж тоглоцгооё.
5	Суралцагчид ангид байрлуулсан банкны бичил орчинтой танилцаж, сонирхсон асуултаа банкны мэргэжилтэн – зочин багш С.Төмөрхуягт тавьж ярилцах	– Сурагчдын саналаар: ✦ Банкны мэргэжилтэн ✦ Орлогын касс ✦ Зарлагын касс ✦ Харилцагчдын зөвлөхийг томилох – Багуудад даалгавар өгч банкаар гүйлгээ хийлгэх – Гүйлгээнд хяналт тавьж, бланк бөглөх ажлыг зөвлөхүүдээр шалгуулах – Банкны мэргэжилтнээр шалгуулах
6	Даалгавар 1. Танай эгч чамд 150 000 төгрөг гуйвуулсан байна. 14 цагт банкнаас очиж авна уу.	Суралцагчдаас асуулт асуух:
7	Даалгавар 2. Та сургалтын төлбөр болон 60 000 төгрөгийг Голомт банкны 4500241299 тоот дансанд тушаана уу.	Асуулт 1. Банкны ажилтнаар ажиллах хэцүү байв уу?
8	Даалгавар 3. Та бүхэн улиралд олгох хүүхдийн 25 000 төгрөгийн жилийн хүүг тооцож олгоно уу.	Асуулт 2. Гүйлгээнд хүндрэл гарав уу, ямар хүндрэл гарсан бэ?
9	Даалгавар 4. Танд мөнгөний хэрэгцээ гарлаа. Хадгаламжаасаа 85 000 төгрөг авна уу.	Асуулт 3. Банкны мэргэжилтэн болох гэсэн бодол төрсөн хүүхэд байна уу? – Ариунсанаагийн ээж Э.Хосбаяраар хадгаламжийн дэвтэр нээхийн ач холбогдлыг тайлбарлуулах

10	Багууд ямар үйл ажиллагаа хийсэн (гуйвуулга, орлого, зарлага)-ээ бусад багуудад тайлагнах	– Багуудаас “Гурван М”-ийн аргаар асуулга авах
11	Багшийн асуусан асуултад хариулах, санал бодлоо илэрхийлэх.	– Эцэг эхээс хичээлийн талаарх сэтгэгдлийг асуусан асуулга авах
12	Сурагчид асуулгыг багаар хэлэлцэн бөглөж, хананд байрлуулан бусад суралцагчдад тайлбарлах.	Эцэг эхээс авах асуулга: – Таны бодлоор энэ хичээл хүүхдийн чинь хэрэгцээ сонирхолд нийцэх болов уу? – Хичээлийн талаар танд төрсөн сэтгэгдэл – Төсөлт ажлын талаар таны өмнөх ойлголт – Багшид та юу зөвлөмөөр байна вэ? ✦ Сурагчдын мэдэхийг хүссэн зүйл нь дараах хичээлээр судлах зүйл болно гэдгийг хүүхдүүдэд ойлгуулах ✦ Хичээл завсарлана.

Хичээл заасан багш нарын сэтгэгдэл:

1. Сурагчид өрхийн тооцоог хийснээр орлогын хэдэн хувь нь юунд зарцуулагддаг болох, орлогыг нэмэгдүүлэх, хэмнэх, зөв зарцуулах тухай ойлголттой болж, мөнгөтэй харьцаж сурах эхлэл тавигдлаа.
2. Энэ хичээлээр суралцагчид өдөр тутмын хэрэгцээгээ зөв тодорхойлон, үлдсэн мөнгөө хэрхэн өсгөх вэ гэдэг эдийн засгийн тооцоог өөрийн амьдралд хэрэгжүүлэхэд нь нэмэр болно гэж багш бид бодож байна.
3. Сурагчид үйлчилгээний байгууллагын ажилтан болж тоглосноор харилцааны соёлын чухлыг мэдэрч, гэр бүл, найз нөхөд, хамт олонтойгоо зөв боловсон харилцах хэрэгтэйг мэдэрсэн.
4. Энэхүү хичээл нь багш – сурагч – эцэг эх – байгууллага, иргэд гэсэн дөрвөлсөн холбоо, хамтын ажиллагааг харуулсан онцлог бүхий хичээл боллоо.
5. Бусад мэргэжлийн хичээлд ч гэсэн энэ арга барилыг хэрэглэж болно гэж бодож байна.
6. Хоёр өөр сургуулийн багш хамтарч хичээл заасан нь суралцагчдад сонирхолтой байлаа.

Эцэг эхээс авсан асуулгад эцэг эх хариулсан баримтаас:

Эцэг эхээс авах асуулга

1.Таны бодлоор энэ хичээл хүүхдийн хэрэгцээ сонирхолд нийцэж сонирхолтой болж чадсан уу?

Мин сонирхолтой байлаа. Урьд хүүхдүүд бодом турал нэгдлийн олон, хичээл их сонирхолтой ажлаа.

2.Хичээлийн талаар танд төрсөн сэтгэгдэл?

Хүүхдүүд хичээл танин болон бусад зүйл хичээлийн тэ хичээл дунд байсан урьдхууд их өргөмж байх болно тэд бодом байсан.

Өмнөх хичээл 10% өргөмж хүүхдүүд сонирхолтой болсон байсан хичээл болон өмнөх.

3.Төсөлт хичээлийн талаар таны өмнөх ойлголт?

Урьд нь ойлголт байсангүй.

4.Багшид өгөх таны зөвлөгөө:

Бодом турал хичээл зохом байгуулах болон байлаа. Урьдхууд зохомж танин хичээл бодом бодом хичээл танин хичээл зохом байсан.

Хан - Урьд хичээл хичээл 8-а хичээл
Б. Ариунсанаагийн тани З. Хосбаар.

Эцэг эхээс авах асуулга

1. Таны бодлоор энэ хичээл хүүхдийн хэрэгцээ сонирхолд нийцэж сонирхолтой болж чадсан уу?

Хүмүүнлэг сэтгэлээр мэддэг зүйлсийг бодит байдалтай үзвэл, бусад өргөн хүрээнд энэ эх, бусад, хүмүүнийг хамттай оролцоог хамтаар сайн хийх болно.

2. Хичээлийн талаар танд төрсөн сэтгэгдэл?

Хүүхдэд бусад нь эдийн засгийн талаар тэр тусмаа өргөн ороо, үүсгээ төсөх ашиг туршилтад хэрэг бүрдүүлэх түүхийг ашиг тусыг талаар дэлгэрэнгүй мэдлэгт ороо хүүхдэд, энэ хийх оролцоог хамтаар амьдрал дээр, бусадтай хийх байдаг.

3. Төсөлт хичээлийн талаар таны өмнөх ойлголт?

Хүүхдийн дорвитойг хамт ашиг, шийдвэрлэх асуудлыг дэлгэрэнгүй туршигт тал талаар нь авч үздэг.


4. Багшид өгөх таны зөвлөгөө:

- Энэ хичээл хийх бүхий сэтгэлдээ өргөн хийх зөв байгаагаар үзэж энэ эх арга хамтаар үзэж үзвэл.
- Тал бүхий ашигт ашигт хувь.

Хан - Чин шалбар
сүүдрийн 8-ашиг.

Анхныгт тал Нарантарал.

3.2.3. МОНГОЛ ЁС ЗАНШИЛ, УЛАМЖЛАЛЫН АСУУДАЛ ГОЛЛОСОН ТӨСӨЛТ АЖИЛ



Зорилго:

Энэ улирлын төсөлт ажлаараа сурагчдад Монгол үндэстний соёлын үнэт зүйл – үндэсний хувцас, түүний хэрэглээ, эдэлж хэрэглэх ёс заншил, үүсэл гарал, түүх соёл, үндэстэн ястны зан үйл, онцлог ялгааг судлан, тэдгээрийг өөрсдийн амьдрал ахуйдаа хэрэглэж сурах

Үйл ажиллагаа


1. Сэдэв сонголт



Сурагчдын сонгосон сэдэв нь “Монгол үндэсний хувцас” байлаа. Энэ нь өнөө үед түүх, соёл, ёс заншил, гарал үүслээ мартаж шахаж буй залуу үеийнхэнд маань маш сонирхолтой сэдэв байсан бөгөөд бусад хичээлтэй уялдаж байсан нь сурагчдын мэдлэгийн хүрээг тэлэхийн сацуу зарим хичээлүүдийг улам гүнзгийрүүлэн судлах сонирхол төрүүлэх зэрэгт сайнаар нөлөөлж байлаа.

2. Сэдвийн тор

Сурагчид сэдвийн тороо монгол үндэсний хувцасны үүсэл гарал, түүх соёлыг судлан цаашид судалгаа, шинжилгээ хийхэд боломжтойгоор бүтээсэн. Багууд өөрсдийн сонгосон дэд сэдвийн (“Малгай”, “Дээл”, “Гутал”) дагуу судалгаа хийж судлагдахуунаа оновчтой гаргасан болно. Сурагчдын өмнөх хичээлүүдээс олж авсан туршлага нь сэдвийн торыг оновчтой гарган, судлах судлагдахуунаа олоход их дөхөм болж байлаа. Сэдэв нь сонирхолтой байсан учраас сэдвийн задаргаа хийхэд хялбар байсан.



3. Багшийн чиглүүлэх үйл ажиллагаа хийлээ

Багш сонгосон сэдвийн дагуу монгол үндэстнүүдийн тухай болон монгол үндэсний хувцасны талаарх ерөнхий ойлголтыг сурагчдад тайлбарлан мэдээлэл өгсний зэрэгцээ, судалгаа шинжилгээг хэрхэн яаж явуулах, ямар арга барил сонгох нь оновчтой байх зэргийг тайлбарлан чиглүүлж өглөө.



Багш сурагчдад монгол үндэсний хувцасны талаар ерөнхий ойлголт өгч байгаа нь

Багшийн зөвлөгөө:

- Монгол үндэстнүүдийн тухай ерөнхий ойлголт
- Хувцасны талаарх ойлголт
- Судалгааг хэрхэн явуулах талаар
- Мэдээллээ ямар эх сурвалжаас авбал оновчтой болох
- Бусад хичээлүүдээр олж авсан мэдлэг чадвар, туршлагаа ашиглах талаар тус тус анхаарахыг зөвлөв.

Багшийн үйл ажиллагаа ямар байвал зохих вэ?

- ☒ Сурагчдын хийсэн судалгааны дагуу дүн шинжилгээ хийж, нэмэлт мэдээллийг техник хэрэгсэл ашиглан цаг тухайд нь мэдээлж, сурагчдын цааш судлах сэдлийг төрүүлэх
- ☒ Сурагчидтай хамтран судалгаа хийх
- ☒ Судалгаа хийхдээ мэргэжлийн ном, сурах бичиг болон ахмад настан, хувь хүн, багш нараас асуух, зөвлөгөө авах зэрэгт нь туслах
- ☒ Сурагчдыг ярих явцад (хичээлийн явцад) багш анхааралтай сонсон, ажиглалт хийж, тэмдэглэл хөтлөх
- ☒ Цэгцтэй ярьж буй сурагчдыг дэмжин стандарт бус үнэлгээгээр үнэлэх зэрэгт чиглэж байлаа.

4. Багуудын судалгаа, бүтээлч үйл ажиллагаа

Баг тус бүр судалгаагаа олон хэлбэрээр явуулж хоорондоо санал солилцон хамтран ажиллав. Өөрөөр хэлбэл багууд дотроо санал солилцохоос гадна бусад багуудтай хамтран ажиллав.

Мэдээллийг олон сувгаар цуглуулсан нь маш сайшаалтай байсан. Үүнд түүх, угсаатны зүйтэй холбоотой ном сурах бичиг, гарын авлага уншиж судалснаас гадна хэвлэл мэдээллийн хэрэгсэл, интернэтээс шаардлагатай мэдээллийг татан авч, хувь хүмүүстэй (ахмад хүмүүстэй) уулзаж ярилцан тэднээс үнэтэй олон сайхан зүйлүүдийг сурч, “Угсаатны зүйн музей”-г үзэж цуглуулсан мэдээллээ техник хэрэгсэл ашиглан илтгэл тавьж, “Том ном” хийх, эсээ бичих, ханын сонин гаргах, зарим нь жүжигчилсэн тоглолт бэлтгэн, биет зүйл авчирч бусдадаа тайлбарлаж үзүүлсэн нь сонирхолтой бөгөөд ойлгомжтой байлаа.

Багуудын харилцан мэдээлэл солилцсон хэлбэр	Бодит үзүүлэн (монгол гутал, тоорцог малгай, казак малгай, хүүхдийн баривч ...)
	Зурагт хуудас (сэдэвтэй холбоо бүхий сурагчдын бүтээл)
	Ханын сонин
	Илтгэл
	Аварга ном
	Жүжигчилсэн тоглолт

“МАЛГАЙ” баг

“Малгай” багийнхан судалгаа шинжилгээ сайн хийж, бодит үзүүлэн, слайд, ханын сонин, power point зэргийг бэлтгэн тайлбарлаж хүргэсэн нь оновчтой сайхан болсон. Эхнэр хүний толгойны боолтноос эхлээд тоорцог, өвлийн лоовуузан малгай, буриад, казак гэх мэт олон төрлийн малгайны онцлог, бэлгэдэл зэргийг гаргаж чадсан.

Тэдний бэлтгэсэн жүжигчилсэн тоглолтын агуулга нь “Монголчууд эрт дээр үеэс малгай, бүсээ эрхэмлэн дээдэлж ирсэн” тухай байсан нь сурагчдад болон ажиглагч багш нарт их таалагдсанаас гадна олон зүйлийг мэдүүлж өгснөөрөө ач холбогдолтой байв.



“Малгай” багийн жүжигчилсэн тоглолтын хэсгээс

“ДЭЭЛ” баг

Энэ багийнхан монголчууд жилийн дөрвөн улиралдаа тохируулан хувцасласаар ирсэн. Монгол үндэсний дээлийг хүүхдийн баривчнаас эхлээд энгийн, гоёлын, ихэс дээдсийн өмсдөг дээл гэж ялгаж болох тухай, мөн ястан үндэстний хувцасны онцлогийн талаар тодорхой мэдээлэл өгч чадлаа. Дээлийг хийсэн материалаар нь торго, даавуу, даалимба, цэмбэ, тэрмэн дээл, алтан утсаар оёж, эрдэнээр чимэглэсэн хаад хатдын дээл, тэрлэг, хөвөнтэй дээл, үстэй дээл гэх мэт олон янз байдгийг, мөн дээлний загвар хийцийг их л нарийвчлан судалж тайлбарласан бөгөөд бусад багийнхны сонирхсон асуултад оновчтой хариулт өгч байлаа. Ялангуяа дээр үед ихэс дээдсийн өмсч байсан алтан утсаар хийж эрдэнээр чимэглэсэн дээлийн талаар сурагчид их сонирхож байлаа.



Туршигч багш Ц.Оюунсанаа явцын тэмдэглэл хөтөлж буй байдал

“ГУТАЛ” баг

“Гутал” баг судалгаагаараа хүүхдийн бойтогноос эхлээд халх, буриад, урианхай, торгууд, захчин, хасаг гэх мэт үндэстэн ястны олон төрлийн гуталны талаар маш сайн мэдээлэл цуглуулсан байлаа. Монгол гутал гэхэд оймс, оймсны хараа, улыг юугаар, хэрхэн хийдэг, бэлгэдэл зэргийг нарийн судалсан байв.

Хэдийгээр гаднаас ажиглахад Монголын олон үндэстний гутлын онцлог байдлыг яриад байга мэт авч угтаа монгол гутлын хэв загвар нь монголчуудын байгаль дэлхийгээ хайрлах өнө эртний сайхан ёс заншил, уламжлалтай (монгол гутлын хоншоорыг эх дэлхийнхээ газар шороог гутлынхаа хоншоороор өшигчиж явахгүй гэсэн бэлгэдлээр ээтгэр хийдэг байжээ) холбоотой болох тухай, гар урлал, хатгамлын давтагдашгүй ур хийцийн гайхамшгийг ярьж тайлбарласнаараа хүүхдүүдэд энэ сайхан эдийн соёл, ёс заншил уламжлалаа дээдлэн ойлгож хэрэглэх, хойч үедээ өвлүүлэн үлдээх нь чухал юм гэсэн эерэг сайхан бодлыг төрүүлж чадлаа. Тэд зурагт үзүүлэн, слайд бэлтгэж ирснээс гадна гуталнуудыг бодитоор нь авчирч тайлбарлан ярьж байсан нь бусад багуудын сонирхлыг илүү ихээр татаж байлаа. Үүнийг дараах зургаас үзнэ үү.



ТУРШИГЧ БАГШИЙН СЭТГЭГДЭЛ

❖ Сурагчид монгол үндэстэн ястан, угсаатны хувцас, ёс заншил, соёл, бэлгэдлийг судалж, хэрхэн, яаж, хэзээ хэрэглэдгийг мэдэж, харилцан мэдээллээ солилцож буй нь хэн хэнд нь маш сонирхолтой байлаа.	❖ Сурагчид маань музей, үйлдвэрийн газар, хувь хүмүүстэй уулзан судалгаа хийсэн байдал нь, тэд хичээлдээ ямар их ач холбогдол өгч байгааг харуулж байна.
❖ Сурагчид монгол угсаатны хувцас, ёс заншил, түүх, соёлын талаар өргөн мэдлэгтэй болсон.	❖ Анги удирдсан багшийн ярианаас тухайн ангид “Төсөлт ажил” явагдаж байгаагийн үр дүнд ангийн сурагчдын бусад хичээлд оролцох идэвх эрс сайжирсан гэдгийг мэдэж авлаа.

ЭНЭ ЖИЛ ТУРШСАН “ТӨСӨЛТ АЖИЛ”-ЫН ОНЦЛОГ

“Би”-гээс “Бид” агуулга/сэдвийн хүрээнд ажилласан.	Бидний монголчуудын уламжлалт ёс заншил, гутал хувцас, тэдгээрийн бэлгэдлийг судлах
Сурагчид мэдээлэл цуглуулах дадал чадвар эзэмшсэн байсан нь хичээл явуулахад дөхөм байлаа.	Мэдээллийг олон сувгаар, ялангуяа интернэтээс олж авах, боловсруулалт хийх
Бусад хичээлүүдтэй уялдаа холбоотойгоор явагдсан. Үүнд: ■ Монгол хэл ■ Уран зохиол ■ Уран зохиол ■ Түүх ■ Байгалийн ухаан ■ Зураг	Олон төрлийн зүйр цэцэн үгс, бэлгэ дэмбэрлийн үгс, ардын өв уламжлал, олон үндэстнүүдийн тухай мэдээлэл олж авсан нь сурагчдын мэдлэгийн хүрээг тэлж өгсөн.




АЖИГЛАГЧ БАГШ НАРЫН СЭТГЭГДЭЛ

- ☞ Төсөлт ажил нь сурагчдын хэл ярианы чадварыг сайжруулж байна. Хэл сэтгэхүй хоёр холбоотой гэдэг. Тэдний хэрхэн ярьж байгаагаар сэтгэх чадвар нь ямар байгааг харж болно.
- ☞ Сурагчдын нүдэн дээр зөв бичих дүрмийн алдаатай үг, өгүүлбэр огт байж болохгүй. Жижиг алдаа гэлгүйгээр засч байвал сайн байна.
- ☞ 8б ангийн багшийн хувьд энэ хичээл явагдсанаар манай ангийнханд маш олон сайхан эерэг өөрчлөлт гарч байгааг тэмдэглэн хэлэх нь зүйтэй гэж бодож байна.

ДҮГНЭЛТ

- ◆ Энэ хичээлийн жилийн гол сэдэв/агуулга нь “БИД”. Монголчууд бид даяаршлын нөлөөгөөр үндэснийхээ соёл, уламжлалыг хойч үедээ өвлүүлэн үлдээх тал дээр муу анхаарах болсныг мэдэрч сэдвээ сонгосон нь ач холбогдолтой боллоо гэж үзэж байна.
- ◆ Энэ удаагийн төсөлт ажлаараа “БИД”-ий уламжлал, зан заншил, эрхэмлэн дээдэлдэг зүйлсийн тухай мэдлэгтэй болоход чиглэсэн зорилгоо биелүүлж чадсан.
- ◆ Өнгөц харахад гутал хувцасны тухай ярьж буй мэт боловч цаанаа Монголын олон ястан үндэстний соёлын үнэт зүйл, тэдгээрийн онцлог, бэлгэдэл, ахуйн хэрэглээний тухай өргөн хүрээнд ойлголт авсан нь олзуурхууштай байна.
- ◆ Энэ анги туршилтад хамрагдан, төсөлт ажлаа амжилттай явуулснаар сурагчдад эерэг өөрчлөлтүүд гарлаа. Үүнд,
 - ☐ Аливаад хандах хандлага
 - ☐ Хэл ярианы чадвар нэмэгдсэн байдал
 - ☐ Мэдээлэл цуглуулж боловсруулалт хийх чадвар
 - ☐ Аливаа зүйлийг олон талаас нь харж судлах чадвар
 - ☐ Асуултыг оновчтой тавих, асуултад тодорхой хариулах чадварт сайн суралцсан нь харагдаж байлаа.

3.2.4. АМЬДРАХ УХААНЫ СЭДЭВ ГОЛЛОСОН ТӨСӨЛТ АЖИЛ



- Сурагчид юуны түрүүнд багшийн зөвлөгөө, зөвлөмж 2-д тусгасан агуулга/сэдвийн хүрээ болон сонгож болох боломжит сэдвийн жагсаалтыг нарийн судалжээ (Ц.Наранцэцэг, Б.Булган, Наканиши Рейко, Ц.Оюун, “Төсөлт ажлын арга зүй” Зөвлөмж-2, 22 дахь талаас харна уу). Ингээд “БИД – ХҮМҮҮС ХООРОНДЫН ХАРИЛЦАА” агуулга/сэдвийн хүрээнд нийцүүлэн, өөрсдийн хэрэгцээ сонирхолдоо уялдуулж, сэдвээ сонгожээ.

Хүүхдүүдийн дэвшүүлсэн сэдэв тус бүр дээр санал авахад:

- “Хүүхэд нялхас, хөгшид настныг асарч хайрлацгаая” – 6,
- “Манай аймаг, сумаас төрсөн алдартнууд” – 2,
- “Цагаан идээ хийх, борлуулах нь” – 2,
- “Дэлхийд данстай тамирчид” – 1,
- “Суут хүмүүсийн амьдралын нууцаас суралцъя” – 10,
- “Өөрийн сонирхдог зүйлээ судлах” – 5,
- “Сэлэнгэ нутгийн домгийг судлах” – 3,
- “Цэцэг хүмүүст аз жаргал авчирдаг уу?” – 14,
- “Ном унших нь харилцааны шилдэг хэрэгсэл мөн үү?” – 11,
- “Цаг уурын өөрчлөлтийг судалъя” – 2,
- “Хүнсний ногоогоор эрүүлжих аргыг амьдралдаа хэрэглэж суръя” – 9 хүүхэд байв.

Ингээд хамгийн олон санал авсан сэдвүүдийг судлахаар болсон юм.




Баг бүр судлах сэдвээ тодорхойлж, сэдвийн тороо үүсгэхдээ удтал ярилцсаны эцэст нэмж хасаж, өөрчлөлт оруулсаар түүнийгээ ангийн сэдвийн “ТОМ ТОР”-д нэгтгэж байлаа

ТОДРУУЛАГА


АНГИЙН СЭДВИЙН ТОМ ТОР

Хүүхдүүд судлах сэдвээ сонгон, судалгааны баг бүрдүүлсний дараа багаараа хэлэлцэж, СЭДВИЙН ТОР-оо үүсгэнэ. Энэ нь цаашид судлах дэд сэдвүүд буюу судлагдахуунаа тал тал тийш нь бичсэн задаргаа юм. Сэдвийн торыг гоё сайхан бичих нь гол биш, харин судлах сэдвээс халихгүйгээр оновчтой, өргөн хүрээтэй байхыг чухалчилна.

Баг тус бүрийн үүсгэсэн сэдвийн тороос гадна АНГИЙН СЭДВИЙН ТОМ ТОР-ыг хүүхдүүд хамтдаа бүтээнэ. Багийн сэдвийн торыг ангийн хананд байрлуулсан том дэлгэцийн цаасан дээр хүүхдүүд өөрсдийн гараар бичнэ. Ингэж бүх багийн сэдвийн торыг нэгтгэн тухайн ангийн хүүхдүүдэд харагдахуйц байрлуулах нь сурагчдын судалгааны ажлын сэдэв, чиглэл, явц байдал ил тод болон, бусад багш, сурагчид хамтран ажиллах боломж бүрдэнэ. Мөн судлаач хүүхдүүд хийсэн ажилдаа урам, итгэл авах давуу талтай.



- Судалгааны багууд эхлээд хийх ажлын төлөвлөлтөө нарийн гаргав. Багтаа өөр өөрийн онцлогт тохирсон нэр өгснөөс гадна судлах зүйл буюу асуудлаа багаараа томъёоллоо.



Мэдээллийн эх сурвалжууд

Баг ном, сонин, сэтгүүл, интернэт ашиглахын зэрэгцээ холбогдох хүмүүсээс зөвлөгөө авч, судалгаандаа оруулсан нь сурагчдад өгөөжтэй байж, баялаг мэдээллийг олж авсан юм. Заримаас нь дурдвал:

Багийн нэр	Мэдээллийн эх сурвалж
МЭРГЭД	Аймгийн төв номын сангийн ном зүйч Нарандалайтай хамтран ажилласан. Чингис хаан комикоор АХА тэмцээн явуулсан. I-XI ангийн сурагчидтай хамтран олон ажил зохиосон.
ОЮУНЫ ТҮЛХҮҮР	“Суут хүмүүсийн амьдрал” цуврал номоос “Өглөөний сонин” хэвлэл “Шинэ толь” сэтгүүл Аймгийн номын сан

ЭРҮҮЛ АМЬДРАЛ	“Орос ардын эмчилгээний шилдэг жорууд” “Эмчилгээний бор дом” гарын авлага “Өвчингүй бол жаргал” “Гэр гэртээ тогооч” “Эрүүл мэнд” сэтгүүл “Эрүүл амьдрал” сонин Сэлэнгийн поликлиникийн мэдрэлийн ба дотрын тасгийн эмч нартай уулзан, ярилцлага авч, тэмдэглэл хөтөлсөн.
ЖАРГАЛАН	Цэцгийн дэлгүүр “Тасалгааны ургамлыг арчлах нь” ном “Шинэ ертөнц” сэтгүүл “Цэцгийн сонин хачин” ном Биологийн багш нараас зөвлөгөө авсан.

Баг тус бүрийн судалгаа, судалгааны үр дүн

I баг: “МЭРГЭД”

Зорилго: Хүнтэй зөв боловсон харилцах, ажлын байранд судалгаа хийх, бусдыг сайн үйлд уриалан дуудах

Хийх ажил	Сурч мэдсэн зүйл, ололт, үр дүн
1. Сургуулийн багш, сурагчдаас судалгаа авах	1. Багш, сурагчдаас авах судалгааны асуулгыг боловсруулсан.
2. Аймгийн төв номын сантай хамтран ажиллах төлөвлөгөө гаргаж мөрдөх	2. Удирдах ажилтан болон бусад мэргэжлийн хүмүүстэй ярилцсан.
3. Сургууль дээр явуулын номын сан ажиллуулах	3. Өөрийн сургууль дээр 150 гаруй номтой номын сан ажиллуулж, өөрсдөө номоор үйлчилсэн.
4. V-VII ангийн сурагчдын дунд “Уншихаа боливол сэтгэхээ болино” зохион бичлэгийн уралдаан явуулах	4. Хэл найруулгын алдааг өөрсдөө уншиж засан, “ШИЛДЭГ”-ийг шалгаруулж урамшуулсан.
5. II-IV ангийн сурагчдын дунд “Ном – миний сайн нөхөр” зургийн уралдаан зохиох	5. Зургийн багштай хамтран уралдааныг дүгнэсэн.
6. Ахлах ангийн сурагчдын дунд танин мэдэхүйн АХА тэмцээн зохиох	6. Өөрсдөө сонирхолтой олон ном сурах бичиг уншиж, АХА-ны асуулт бэлтгэн, тэмцээн явуулсан.
7. Оюунлаг анги, оюунлаг сурагч шалгаруулах	7. Хамгийн олон ном уншиж, карт нээлгэсэн ангиудыг шалгарууллаа.
8. Тооцооны дэвтэр хөтөлж сурах	8. Шинэ ном захиалах, гэрээр ном олгох, хувийн ном унших зэрэг 3-4 дэвтрийг хөтөлж сурсан.


Хүүхдүүдийн явуулсан ажил нь олон хүүхдийг хамарсан, бусдад өгөөжтэй сайхан болж чадсан юм.




Ном зүйч Ч.Нарандалай уралдаанд шалгарсан хүүхдүүдийн шагналыг гардуулж байгаа нь



“ОЮУНЛАГ СУРАГЧ”-аар бага ангийн сурагч Энхнаран шалгарсан юм.



Номын сандаа ажилласан өдөр маш зугаатай өнгөрдөг.



*Явуулын номын сан
Яг үнэндээ маш гайхалтай байлаа
Хэнээр ч шаардуулахгүйгээр
Хүүхдүүд өөрсдөө хүрээд л ирнэ
Өглөө бүр шинэ “номын санч” инээмсэглэн угтана
Өдөр бүр “уншигчид”-ын сэтгэл дүүрэн баяртай...*



“Мэргэд” багийнхан хийсэн ажлаа амжилттай тайлагнаж, ажил хэрэгч багаар шалгарсандаа баяр хөөрөөр бялхаж байлаа (баруун гар талаас 5 дахь нь ном зүйч).

Судалгааны ажлын явцад хүүхдүүд дараах зүйлийг мэдэж авчээ. Үүнд:

1. Номоор дамжуулан, маш олон хүмүүстэй танилцаж нөхөрлөдөг.
2. Ном ухааныг хурцалж, сэтгэлгээг тэлдэг.
3. Зах зээлийн хүнд нөхцөлд номын санд ном уншсанаар өөртөө оюуны хөрөнгө оруулалт хийгээд зогсохгүй эдийн засагт хэмнэлт гаргана.
4. Ном хүний амьдралыг өөрчлөх аугаа шидтэн мөн.
5. Ном баяр баясал авчрахын зэрэгцээ дуусашгүй эрч хүч бэлэглэдэг ач тустай.

Багийн хийсэн ажлыг тоогоор илэрхийлбэл:

№	Хийсэн ажил	Хамарсан хүрээ
1	Карт нээж, номоор үйлчилсэн.	353 багш, сурагчдад карт нээж, ном уншуулсан.
ТООЦОО: Карт нээлгэхэд хүүхэд 500 төгрөг, том хүн 1000 төгрөг Нийт 47 хүүхдийн 23 500 төгрөг + 3 багшийн 3000 төгрөг = 26 500 төгрөг Ангидаа хуримтлалтай болсон.		
2	Гэрээр ном олгосон.	47 багш, сурагчдад 50 ширхэг ном гэрээр уншуулсан.
3	Захиалга авч, аймгийн төв номын сангаас ном татсан.	Захиалгаар 110 ном номын сангаас авч багш, сурагчдад үйлчилсэн.
ТООЦОО: Хүүхэд 1 ширхэг нимгэн номыг 500 төгрөгөөр, зузаан хатуу хавтастай номыг 1500-3500 төгрөгөөр, комик номыг 8000-10000 төгрөгөөр авдаг бол номын санд 1 удаа 500 төгрөгөөр карт нээлгэснээр 2000-9500 төгрөгийн хэмнэлт гаргаж, маш олон номыг гэрээр үнэгүй авч уншиж болно. Том хүн 1 номыг 3500-15 000 төгрөгийн хооронд авч уншдаг бол номын санд 1 удаа 1000 төгрөгөөр карт нээлгэснээр өөртөө 2500-14 000 төгрөг хэмнэж, оюуны том хөрөнгө оруулалт хийхийн зэрэгцээ эдийн засгийн ач холбогдолтой.		

“Та бүхэн уншихаа боливол сэтгэхээ болино. Ном таны амьдралыг өөрчлөх хүчирхэг зэвсэг мөн. Номын ач тус агуу” гэсэн сургаалыг мөрдлөг болгон, сард 1-2 номыг заавал уншиж хэвшээрэй! гэж уриалж байна. Энэ уриалгаа “Мэргэд” багийнхан сургуулийнхаа анги бүрийн хаалганд ойр, хүүхдүүдийн нүдэнд ил харагдахуйц бичиж тавьсан юм.

Төсөлт ажлын үр дүнд хүүхдүүд хийсэн ажлынхаа туршлагад тулгуурлан, уриалга, сэрэмжлүүлэг, зөвлөгөө, санамж, тэмдэглэл зэргийг бичиж, бусдад хүргэдэг нь их үнэ цэнэтэй. Хамгийн гол нь өөрсдөө судлаад, мэдээд зогсохгүй бусдад түгээн дэлгэрүүлж, хэрэглээ болгодог нь төсөлт ажлын давуу тал юм.

II баг: “ОЮУНЫ ТҮЛХҮҮР”

Зорилго: Суут болон алдартай хүмүүсийг судлан, тэдний амжилтад хүрсэн нууцыг нээж, өөрсдийн амьдралд хэрэгжүүлж, бусдад хүргэх

	Суут хүмүүс	Амжилтад хүрсэн нууцаас нь ...
Дэлхийн	Моцарт	Төрөлхийн авьяас нь 3 настай байхад нь илэрсэн, 5 настайдаа хөгжмөө бичсэн. Нийт 626 бүтээл туурвисан, авьяаслаг гэр бүлээс мэндэлсэн нь дэлхийн суут хүн болоход нөлөөлсөн.
	Уолт Дисней	Хүүхдэд их хайртай байсан. Ажилч хичээнгүй зантай, сайхан сэтгэлтэй, мөрөөдөлдөө хүрэхийн тулд уйгагүй хөдөлмөрлөдөг. Бизнес нь олон удаа бүтэлгүйтсэн боловч шантралгүй дахин дахин эхэлсээр амжилтад хүрсэн.
	Леонардо Да Винчи	Бага нас нь хэцүү өнгөрсөн. Ажигч, гярхай, сониуч зантай, тухайн үед түүний бүтээлийг хүмүүс ойлгоогүй ч хожим нь алдаршсан.
Монгол орны	Б.Ринчин	5-8 орны хэлийг бие даан суралцаж эзэмшсэн. 15 улсын 80 гаруй зохиолчийн 100 гаруй бүтээл орчуулсан. Үндсэрхэг үзэлтэй, эх оронч сэтгэлгээтэй, орос, герман, хятад хэлээр чөлөөтэй ярьдаг.
	Б.Лхагвасүрэн	Их хөдөлмөрч, амьдралын хатуу бэрхийг багаасаа амссан тул зохиол бүтээл нь бусдад ямагт ухаарал бэлэглэдэг.
Бүс нутгийн	С.Баярцогт	Сурагч байхдаа математик, орос хэл, газарзүй, физикийн олимпиадын аварга сурагч байсан. Ажил хэрэгч зан нь цэл залуу насандаа төрийн өндөрлөгт хүрэхэд нөлөөлсөн. Сурагч байхдаа бүх хичээлдээ жигд сайн суралцаж байсан. Зоригтой, шийдэмгий алхам хийдэг нь Монголд ардчиллыг хөгжүүлэхэд тодорхой хувь нэмрээ оруулсан.
	Т.Үйтүмэн	Ямар ч хүнтэй чин сэтгэлээсээ, зөв харьцдаг. Тэсвэр хатуужилтай, эр зоригтой, спортоор уйгагүй хичээллэсэн нь алдрын оргилд хүргэсэн. Зоригтой, шантардаггүй зантай ба нийтэч, хүүхдэрхүү зан нь бусдад их таалагддаг.

“Авьяасын дээд, төгс төгөлдөр илэрхийлэл нь суу ухаан мөн. Хүн уураг тархиныхаа аравны нэг хувийг л ашигладаг. Хэрэв аравны хоёр хувийг ашиглавал гоц авьяастай, аравны гурван хувийг ашиглавал суут ухаантан болдог ажээ”. Судалгааны эцэст хүүхдүүд, энэ бүхэн их зүйл бодогдуулж байгааг хэлээд, “Цаашид өөртөө тусган, үлгэр дуурайл болгох л үлдэж байна” гэж ярилцав.



Багийн ахлагч Алгирмаа ажлаа тайлагнаж байна. Ахлагчид багийн гишүүдийг зохион байгуулах, зангидах, нөөц боломжоо зөв тооцох, хийсэн ажлаа багийн өмнөөс хариуцлагатай ярьж танилцуулах гээд ажил маш их.



Судалгаа хийх явцад сургуулийнх нь багш нар хүүхдүүдэд зөвлөгөө өгч тусалжээ.



“Оюуны түлхүүр” багийнхан дэлгэмэл “Том ном” хийж, багаараа тайлангаа хамгаалав.

III баг: ЭРҮҮЛ АМЬДРАЛ

Зорилго: Амьдралынхаа хэв маягт судалгаа хийж, зөв, эрүүл амьдрах арга ухааныг судалж, өөртөө болон найз нөхдөдөө хэрэглээ болгох

Хийсэн ажил, судалсан ном зохиол, сонин сэтгүүл



Судалгааны үр дүнд хүнсний ногоогоор эмчилгээний зууш бэлтгэх зөвлөгөө боловсруулан, өөрсдөө ч хийж, бусдад ч зааж сургасан.



Хүнсний ногоогоор эрүүлжих арга ухааныг судалж, гэр бүлийнхэндээ туршсанаа тайлбарлав.



Зуушнуудын нэр төрөл олон, амт чанар сайн байлаа.



“Эрүүл амьдрал” багийнхан туршилтын үр дүнгээ танилцуулж, судалгааны тайлангаа амжилттай хамгаалав.

Хүүхдүүд хүнсний ногоогоор эрүүлжиж болдгийг дараах туршилтаар нотолжээ. Намуунтөгсийн эмээ Жамц, Ганзулын ээж Ганцацрал нар дээр 7-10 хоногийн хугацаанд хэрэглүүлж ажигласан ба эдгээр хүмүүст эерэгээр нөлөөлсөн байна. Тэдний судалж, олж мэдсэн эмчилгээний жороос толилуулъя.

ЖОР 1. Даралт ихэдсэн үед хүрэн манжингаар эмчлэх нь

- а. Цусны даралт ихэдсэн үед өглөө өлөн элгэн дээрээ 100-150 грамм хүрэн манжинг түүхийгээр нь иднэ.
- б. Хүрэн манжингаас шахаж авснаас хойш нээлттэй саванд 2 цаг хадгалсан шүүсийг 0,5 граммын стаканаар өдөрт 3-4 удаа ууна.
- в. Чанаж болгосон хүрэн манжинг ургамлын тостой холин, зууш хийгээд, өлөн элгэн дээрээ иднэ.

ЖОР 2. Даралтыг 100 грамм хүрэхгүй цагаан будаагаар 3 хоногт эмчлэх нь

Хоолны 2 халбага цагаан будааг угаагаад, 0.75 литр усанд хийж хонуулна. Өглөө нь 7 минут орчим буцалгаж, дутуу болгон, усыг нь асгаад, будааг өглөөний хоол болгон, өлөн элгэн дээрээ иднэ. Дараа нь 3 цаг юу ч идэж уухгүй. 3 хоног ингэж хэрэглэснээр 1 курс эмчилгээ болно. Хэрэглэх үед согтууруулах ундаа, халуун ногоо, давсалсан хүнс идэж, ууж болохгүй.

ЖОР 3. Зүрхний өвчнийг шинэ ногоон халгайгаар эмчлэх нь

Шинэ ногоон халгай 50-70 граммыг паалантай саванд хийж, дээр нь 450 грамм хүйтэн ус хийнэ. 1 цаг байлгасны дараа зөөлөн галаар 10 минут буцалгана. Сайн хөргөсний дараа шүүж, шаараа зайлуулна. Хөргөгчид хадгалж байгаад тасалгааны температуртай болтол бүлээсгэн хэрэглэнэ. 5 хоног уугаад, 3 хоног завсарлана. Өдөрт 1 удаа 75 граммаар ууна. Энэ нь 1 курс эмчилгээ болдог байна.

Энэ мэтээр хүүхдүүд ходоодны шарх, сэвх толбо арилгах, үс унах зэргийг эмчлэх, анагаахад тустай олон жорыг судалж мэдсэнээр өөрсдөдөө болон ойр орчныхондоо тулгамдсан олон асуудлыг шийдвэрлэж чаджээ.

“ЭРҮҮЛ АМЬДРАЛ” багийнхан эрүүлжих жорууд бичсэн зөвлөгөө, санамжаас бүтсэн “ЭРҮҮЛ АМЬДРАЛЫН НОМ” бүтээж, тайлангаа хамгаалав.

IV баг: ЖАРГАЛАН

Зорилго: Цэцгийн үнэ цэнэ, ид шидийг судалж мэдрээд, цэцэг ургуулж, арчилж, тордох аргад суралцан, сургууль орчноо цэцэгжүүлж, хүмүүсийн сэтгэл санааг өөдрөг байлгах



Хүүхдүүд эхлээд сэдвийн тороо үүсгэж, дараа нь ажлын төлөвлөлт гарган, түүний дагуу их зүйлийг хийж бүтээжээ.

Үүнд:

- ✿ Цэцэгсийн тухай ном сонин уншиж, хайчилбар хийсэн.
- ✿ Цэцгийн дэлгүүрүүдээр явж, судалгаа хийсэн.
- ✿ Цэцэг сайхан тарьж ургуулдаг зэргэлдээх цэцэрлэг, сургуулийн багш нар болон эцэг эхчүүдтэй уулзаж, туршлагыг нь сонсож судалсан.
- ✿ Өөрсдөө цэцэг тарьж, ургуулж, түүндээ ажиглалт хийж, тэмдэглэл хөтөлсөн.
- ✿ Цэцэг, навч, нахиа, ус, нар, хөрс, бордоо болж, жүжигчлэн тоглосон.
- ✿ Сургуулийн коридорыг цэцэгжүүлсэн гэх мэт.



“Жаргалан” багийнхан тарьж ургуулсан цэцгээ нарийн судалж, мэдээлэл цуглуулан, цэцэгсийн тухай зохиол бичин, өөрсдөө жүжигчлэн тоглосон юм.



Бусад багийн гишүүд “Жаргалан” багийнханд олон асуулт тавьж бас санал сэтгэгдлээ хэлсэн юм. Тэдний санаа маш үнэ цэнэтэй байлаа.



Хүүхдүүд судалгааны явцад юу судалж, юу сурч мэдсэнээ ямагт баримтжуулж байв.



Хүүхдүүд ар өвөргүй асар их мэдээлэл агуулдаг дэлгэмэл ном хийж танилцуулсан.



ТООЦОО:

	ЦЭЦГИЙН САВ	ХӨРС (100 грамм)	ЦЭЦЭГ
Дэлгүүрээс авбал	500-3000 төг	300-1000 төг	1500-15000 төг
Өөрсдөө хийвэл	500-1500 төг	Өөрсдөө бэлтгэнэ.	Өөрсдөө тарьж ургуулна.

Гэрийн нөхцөлд цэцэг тарьж ургуулснаар тоосжилт, чимээ шуугианыг багасгаж, гэр бүлийн гишүүд өөр хоорондоо эелдэг зөөлөн харилцахад нөлөөлдгийг хүүхдүүд мэдэж авсан. “Жаргалан” багийн судалгааны ажлын үр дүнд сургуулийн коридор,

анги танхим цэцэгтэй болсон ба ихэнх цэцгийг хараад, төрөл зүйл, ургалт, хөрс арчлалт, хортон шавжны талаар хүмүүст зөвлөгөө өгөх туршлагатай болсон нь маш сайшаалтай байлаа.

ХИЧЭЭЛИЙН ҮР ӨГӨӨЖ БА ОРОЛЦОГЧДЫН СЭТГЭЛ ХАНАМЖ

“Би энэ хичээл орохоос өмнө чөлөөт цагаа өөртөө хэрэгтэйгээр зөв өнгөрөөж чаддаггүй байсан. Бас хүний өмнө ярьж ч чаддаггүй байв. Харин энэ хичээлийг орсноос хойш үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлж, үүрэг хариуцлагаа ухаарч, багийнхантайгаа хамтарч ажиллаж чаддаг болсон”

“Багш аа, таньтай бас ангийнхантайгаа хамтарч төсөлт ажил хийхэд сайхан байлаа. Урьд нь багшийн дэргэд, самбарын өмнө зогсоход хэн нэгэн цохиод авах гэж буй мэт айдаг байсан. Харин энэ жилээс би шал өөр болсон, хаана ч, хэнтэй ч ярьдаг болсон. Хөөр баяртай 4 долоо хоног өнгөрчээ. Ийм гоё хичээл заасан багш тандаа баярлаж байна”

“Би төсөлт хичээлд оролцсоноор өөртөө маш их өөрчлөлт хийсэн гэж бодож байна. Үүнд багш таны ач тус их шүү. Өөрийн хийсэн, судалсан ажлаа ярьж тайлагнахдаа хүүхдүүд үргэлж инээмсэглэж, баяр хөөртэй байдгийг би ажигласан”

“Энэ хичээл анх ороход цаг гарзадсан хичээл гэж бодож байлаа. Одоо бол бүх юмыг өөрөөр харж байна. Бусад хичээл дээр ч төсөлт ажлаар сурсан мэдсэнээ ашигладаг болсон. Бас ангийнхныхаа нууц авьяасыг олж харж чадсан”


“Эцэг эхчүүд бид эхэндээ энэ хичээлд хамаг цагаа зориулж байгаад нь дургүй байлаа. Гэтэл хүүхдүүд маань нүдэн дээр илт өөрчлөгдөж, хөгжиж байна. Хүүхдүүдийн өөрийгөө илэрхийлэх, ярих чадвар маш сайн байна. Хийсэн ажлаа мундаг тайлагнаж байна. Өмнө нь сонсож байгаагүй олон шинэ мэдээллийг тэднээс авлаа”

“Анги удирдсан багшийн хувьд хүүхдүүдээ цэгцтэй ярьж, аливаад нухацтай ханддаг болсонд нь бахархаж байна. Энэ хичээл хүүхдүүдэд эерэгээр нөлөөлж, дээд зэргээр хөгжүүлж, төлөвшүүлж байгаа. Нарантуяа багш манай хоёрдахь анги удирдсан багш мэт, маш ойр дотно байдаг”

“Монгол хүүхдүүд дүрийн тоглолт хийхдээ маш гарамгай. Энэ нь хүмүүс хоорондын харилцаанд сайнаар нөлөөлж, соёлтой зөв харилцах чадвартай болоход нь нөлөөлдөг болов уу. Хүүхдүүд мэдээллийг эрж хайж, цуглуулж, боловсруулж, өөрийн болгох аргад багаасаа суралцаж байна”

“Төсөлт ажил нь бусад хичээлийг бодвол их цаг шаарддаг. Мэдээллийн янз бүрийн орчинд ажиллаж, судалгааг олон янзаар, өргөн хүрээтэй хийж, цуглуулсан мэдээллээ боловсруулж сургадаг. Энэ бүхэнд багшийн чиглүүлэг чухал болохыг, багш хүүхдүүдтэйгээ зэрэг судалгаа хийхийн чухлыг туршилтын явцад ойлгож мэдэрсэн юм”

3.2.4. БАЙГАЛЬ ОРЧНЫ АСУУДАЛ ХӨНДСӨН ТӨСӨЛТ АЖИЛ



Төсөлт ажлын зорилго:

Сурагчид “БИД/ХҮМҮҮС ХООРОНДЫН ХАРИЛЦАА” – агуулга/сэдвийн хүрээнд “БИД – БАЙГАЛЬ ЭЭЖИЙН ХҮҮХДҮҮД” сэдэв сонгон, нийгмийн амьдралд орж, хүмүүсийн үйл ажиллагаатай танилцах, хамтран ажиллах, амьдралын арга ухаан, туршлагатай болох

Зорилт:

1. Сонирхлын дагуу сэдэв сонгон судлах,
2. Багаар хамтран ажиллах, хүмүүстэй харилцах, мэдээлэл цуглуулах,
3. Цуглуулсан мэдээллээ цэгцлэх, боловсруулах, өөрийн үгээр чөлөөтэй илэрхийлж бусадтай хуваалцах,
4. Өөрсдийн ажилд үнэлгээ дүгнэлт өгч, тайлагнах,

Төсөлт ажил явуулахын өмнөх бэлтгэл

- Х.Амаржаргал багштай 8д ангийн сурагчидтай уулзаж, өнгөрсөн жилийн төсөлт ажлын явц байдал, ололт амжилт, тайлан, цаашид сайжруулах зүйлээ ярилцан, энэ жилийн зорилгоо танилцуулсан.
- Сурагчдын оюун ухааны хөгжлийг судлах тулгуур судалгааг сурагч бүрээс авч, өмнөх жилийнхтэй харьцуулж, ажиглалт хийсэн.

Төсөлт ажил явуулсан үйл ажиллагааны тэмдэглэл

№	Сар өдөр	Сэдэв	Цаг	Багшийн үйл ажиллагаа	Сурагчийн үйл ажиллагаа
1	11-р сарын 20	Сэдэв сонголт	2	Агуулга/сэдвийн хүрээг танилцуулах Сэдэв сонгож, сэдвийн тор үүсгэхэд туслах дэмжих Судалгааны ажлын төлөвлөлтийн хүснэгт хийж өгөх	Судалгааны багаа бүрдүүлэх, Багаараа ярилцан, сэдэв сонгох Сэдвийн дагуу тороо хамтран гаргах Ажлын төлөвлөлт хийж, ажлаа хуваарилах
2	11-р сарын 27	Явцын тайлан	2	Хичээл дээр үйл ажиллагааны тэмдэглэл хөтлөн, баг бүр дээр хийсэн ажлын явц, биелэлтийг дүгнэн хэлж урамшуулаад, анхаарах зүйлсийн талаар зөвлөгөө өгөх	Баг тус бүр судалж мэдсэн зүйл, цуглуулсан мэдээллээ цэгцлэн энэ хугацаанд юуг, хаанаас яаж судалж мэдсэнээ бусад багууддаа танилцуулах
3	12-р сарын 4	Явцын тайлан	2	Ангид мэдээллийн орчин бүрдүүлэх	Цаашид ямар ажил хийхээ ярилцах
4	12-р сарын 11	Эцсийн тайлан	2 цаг	Багуудын тайланг сонсох. Төсөлт ажлын 2 дахь жилийн явц, байдлыг дүгнэх Өөрийн үнэлгээний хуудас гаргах	Завсрын тайлангуудаа нэгтгэн цэгцэлж танилцуулах, тайлагнах Төлөвлөсөн ажлууд ямар хэмжээнд хийгдсэнээ ярих. Төрсөн сэтгэгдлээ бичих (юу сурав, юу мэдэв, чамд ямар хэрэг болов)

Дараах хүснэгтийн дагуу багийн ажлын төлөвлөлтөө хийж, ажил үүргийн хуваарь гарган, биелэлт, үр дүнг нь нарийн тооцон ажиллажээ.

“.....” багийн ажлын төлөвлөлт

№	Хийх ажил	Хугацаа	Очих байгууллага, уулзах хүн	Хариуцах эзэн	Хүрэх үр дүн, биелэлт
1					
2					
3					

Бэлтгэсэн зүйлс:

“.....” сэдвээр судалга явуулж буй тухай хаяг, ангийн сэдвийн том тор бичих дэлгэцийн цаас, бичгийн цаас, фламастер 2-3, өнгийн цаас, хуулга, скоч г.м.

Тус ангийн хүүхдүүд “Ногоон хүрэм”, “Усны дусал”, “Цаг агаар”, “Эрүүл орчин”, “Аюулгүй хүнс” гэсэн сэдвүүдийг сонгон, судалгааны ажлын төлөвлөлтөө багаараа хийсэн. Бичгээр илэрхийлсэн ном зохиол, бусад эх сурвалжуудыг судалсанаас гадна эцэг эх, эмээ өвөө, ойр орчмын иргэдтэй уулзаж ярилцан, мэдээлэл цуглуулжээ. Ингэхдээ ус, цаг уурын газар, мод үржүүлгийн газар, хүнсний дэлгүүр, супермаркет, дүүрэг болон өрхийн эмнэлэг зэрэг ажлын байранд очиж судалгаа хийн, цаг уурч, мод үржүүлэгч, худалдагч, эмч, сувилагч зэрэг ажил мэргэжлийн хүмүүстэй уулзаж, өргөн хүрээтэй мэдээлэл цуглуулсан байна.

Төсөлт ажлын үед багш:

1. Хүүхдийн сонирхсон сэдвийг чөлөөтэй сонгуулах
2. Сурагч бүрийн хэлж ярьж байгааг анхааралтай сонсох, үгэн тэмдэглэл хөтлөх
3. Сэдэв сонгох болон сэдвийн тор үүсгэхэд дэмжих, чиглүүлэх
4. Баг бүрт очиж ажлын төлөвлөлт гаргахад зөвлөн туслах
5. Багийн гишүүн бүр төсөлт ажилд идэвх санаачилгатай хандахыг сануулах сурагчдыг жигд оролцуулах
6. Багуудын завсрын тайлангийн үед ажлын явц биелэлтыг дүгнэн хэлж урамшуулах, цаашид анхаарах зүйлийн талаар зөвлөгөө өгөх
7. Эцэг эх, олон нийт, бусад мэргэжлийн багш нарыг төсөлт ажилд татан оролцуулж, тэдэнтэй хамтран ажиллахыг зорьсон.


Төсөлт ажлаар сурагчид:

1. Сэдэв сонгон, түүнийхээ дагуу хийх ажлаа төлөвлөж сурлаа.
2. Хийсэн ажлаа өөрийн үгээр бусдадаа ойлгомжтой ярьж илэрхийлж сурлаа.

3. Хамтран суралцах арга барилд суралцан, нөхдөдөө туслахын ач холбогдлыг ойлголоо.
4. Судалгааны явцад янз бүрийн ажил мэргэжил, нас хүйсийн хүмүүстэй уулзаж, хүнтэй харилцахад ухаан хэрэгтэйг ойлгоцгоожээ.
5. Өөрөө өөрийгөө үнэлж дүгнэн, өөртөө итгэл үнэмшлийг олж чадав. Би чадна, би чаддаг, би мэднэ, би мэддэг зэрэг үгийн мөн чанарыг ойлгон, үйл ажиллагааг (унших, бичих, зурах, бүтээх, ярих, сонсох г.м.) олон дахин эмх цэгцтэй хийсний дараа тэр хүн юмыг мэддэг, чаддаг болдгийг мэдэрлээ.
6. Мэдээллээ аль болох олон сувгаар цуглуулж, түүнийгээ цэгцлэн боловсруулж ажлаа олон хэлбэрээр тайлагнах аргад суралцлаа.

Судалгааны ажлын тайланг:


- ◆ Дэлгэмэл том ном бүтээх
- ◆ Зохиол бичиж, жүжигчилсэн тоглолт хийх
- ◆ Илтгэл тавих
- ◆ 81 нүдний аргаар багцлан судлах
- ◆ Бодит биет материал, амьд хэрэглэгдэхүүн ашиглан тайлбарлах
- ◆ TV нэвтрүүлэг хийх
- ◆ Сонины хайчилбараас бүтсэн сонин гаргах
- ◆ Уриалга, санамж, зөвлөгөө бичиж, бусдад түгээн дэлгэрүүлэх гэх мэт олон хэлбэрээр хамгаалж болно.



Дэлгэмэл ном нь ар өвөргүй бичиж, нугалж, хааж нээж болдгоос гадна хамгийн их мэдээллийг багтаадгаараа онцлогтой.



“Ногоон хүрэм” багийнхан ой модтой холбоотой бүхий л мэдээллийг ханын зурагт сонин, дүрслэг хэрэглэгдэхүүн хэлбэрээр хийж, багцлан харуулжээ.



“Мод, хожуул хоёрын яриа” зохиол бичиж, өөрсдөө жүжигчлэн тоглосон.





“Усны дусал” багийнхан устай холбоотой, өргөн хүрээтэй судалгаагаа 81 нүдний аргаар багцлан гаргажээ. Тус бүртээ 9 нүд бүхий 9 асуудлыг багийн гишүүн бүр нэг нэгээр нь ярьж хамгаалсан нь сонирхолтой байв.






“Цаг уур” багийнхан монгол орны эрс тэс уур амьсгалыг судалж, түүнд зохицон аж төрөх, хооллох хувцаслах тухай илтгэл бичиж хамгаалав. Хүүхдүүд хамтран power point программ дээр слайд бэлтгэж, илтгэхдээ ч хамтрав.



“Эрүүл орчин” багийнхан эрүүл ба эрүүл бус орчныг бодитоор нь бүтээж, харьцуулан тайлбарласан нь оновчтой бас ойлгомжтой болжээ.



“Аюулгүй хүнс” багийнхан өдөр тутмын хоол хүнсэндээ судалгаа хийж, аюултай 10 хүнсний бүтээгдэхүүний талаар зөвлөмж-сэрэмжлүүлэг бичиж тайлбарласан. Мөн хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэлт, савлагаа , хадгалалт, үнэ, хэрэглээ, ач тус зэргийг нарийн судалж, зэргэлдээх анги, ойр орчмын хүмүүст таниулжээ.

ТОДРУУЛАГА

ТӨСӨЛТ АЖЛЫН БАГ

Төсөлт ажлын судалгааны явцад хийсэн, бүтээсэн ажил бүрээ цаасан дээр бичиж, босоо хэлбэрээр наан, багана болгон босгоно. Энэ нь төсөлт ажлын явцад хүүхдүүд ямар бүтээлч үйл ажиллагаа хийж, хэрхэн олон талт судалгаа явуулсныг илтгэнэ.

Дээрх төсөлт ажлын хувьд 14 бүтээлч ажил хийж, өндөр багана босгосон байна.



Төсөлт ажлын эцэст СУРАГЧДЫН СЭТГЭГДЭЛ-ийг тандахад:

“Өнгөрсөн хугацаанд бид олон сайхан зүйл болон олон бэрхшээлтэй тулгарсан. Тэгсэн ч бид шантрахгүйгээр энэ бүгдийг даван туулсан”.

Ө.Хүрэлшагай

“Бидэнд энэ төсөлт ажил маш их хэрэгтэй байсан. Энэ хичээл нь бидэнд өмнөх жил орсон, энэ жил ч орж байна. Ийм учраас илүү сайн, чөлөөтэй харилцаж байна. Өмнө жилд бид өөрийгөө таньж мэдсэн бол энэ жил хамтдаа багаараа ажиллаж сурсан”

Б.Цэрэнлхам

“Энэ төсөлт ажил маань хүүхдүүдийг нэг нэгэнтэйгээ илэн далангүй, хэнээс ч ичиж зовохгүй, цагийг үр бүтээлтэй өнгөрөөхөд хэрэгтэй, маш чухал хичээл болж байна”.

Л.Долгор

“Төсөлт ажил надад ямар нэгэн юм хийхдээ заавал сайн бодож, ажлаа төлөвлөж хийх нь чухал юм байна гэдгийг ухааруулсан”.

Б.Оюун-Эрдэнэ

“Бид бүхэн аливаа юманд хариуцлагатай хандаж, эмх цэгцтэй байвал юуг ч хийж, бүтээж чадна. Төсөлт ажлаар үүнийг мэдэж авлаа”.

У.Хишигцэрэн

“Би төсөлт ажил хичээлээс өмнө хүмүүсийн өмнө нүүр хагараагүй, ичиж зовдог байсан. Одоо бол би хүмүүсийн өмнө өөртөө итгэлтэй ярьж сурсан. Мөн багаар ажиллаж сурсан”.

Д.Ганзаяа

“Цаашид бусадтай зөв харилцах суурийг тавьж өгсөнд баярлалаа”.

Б.Ажиймаа

“Багаар ажиллах чадвартай болсон. Нийтэч зантай болсон. Бусдад хэлэх гэсэн зүйлээ ойлгомжтой, тодорхой ярьдаг болсон”.

Т.Энхмаа

НОМЗҮЙ

1. Асанума Шигэрү. *Киррикулимьн менежмент*. Эмхтгэл, Токио, 2006
2. Асанума Шигэрү. *Төсөлт ажил хичээлийн киррикулимьг зохиох*. Токио, 2000
3. Б.Бурмаа, Н.Оюунцэцэг нар. Багш нарт зориулсан сургалтын гарын авлага: *Тогтвортой хөгжлийн боловсрол*. УБ., 2008
4. *Оюуны хөтөч*. МУБИС-ийн боловсрол судлалын онол, арга зүйн эрдэм шинжилгээний бичиг. УБ., 2007
5. Тацуо Койдэ. *Японы төсөлт ажлын сургалт*. Лекц. УБ., 2004
6. *Тогтвортой хөгжлийн үзэл санааг анги танхимд хэрэгжүүлэх нь*. “Дэлхийн тунхаглал”-ын багш нарт зориулсан гарын авлага. УБ., 2005
7. *Тогтвортой хөгжлийн төлөөх боловсрол*. Үндэсний зөвлөгөөний эмхтгэл. УБ., 2007.04.06.
8. *Туршигч багш нарын тайлангууд*. УБ., 2006, 2007, 2008
9. Ц.Балхаажав. *Хүүхэд*. УБ., 2001
10. Ц.Наранцэцэг. *Төсөлт ажил - Цуврал 1*. УБ., 2006
11. Ц.Наранцэцэг, Б.Булган, Наканиши Рейко. *Төсөлт ажлын арга зүй*. Зөвлөмж–I. УБ., 2007
12. Ц.Наранцэцэг, Б.Булган, Ц.Оюун, Наканиши Рейко. *Төсөлт ажлын арга зүй*. Зөвлөмж–II. УБ., 2008
13. Ш.Ичинхорлоо. *Хүүхдийн хөгжил*. УБ., 2007
14. <http://www.yononaka.net>
15. http://www.yononaka-net.com/mypage/report/view_material.php
16. http://www.yononaka-net.com/mypage/traning/view.php?traning_no=37
17. <http://www.google.com/search?h=/ja&q=>
189. <http://www.yomiuri.co.jp/nie/note/kids/chogak.htm>

